

**АРИЛЖААНЫ ЗАНШИЛ, ТОГТСОН ПРАКТИКИЙН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

2020

Судалгааны захиалагч: “Ханнс-Зайделийн” сангийн “Эрх зүйн боловсрол” академи

Судалгааны гүйцэтгэгч: “Өмгөөлөл судлалын академи” ТББ

Судалгааны баг: **Тайлан боловсруулсан:**

Багийн удирдагч Б.Амарсанаа (Хууль зүйн ухааны доктор /LL.D/)

Багийн ахлагч З.Сүхбаатар (Бизнесийн удирдлагын доктор /Ph.D/), өмгөөлөгч

Тайлан боловсруулалтад оролцсон багийн гишүүд:

Багийн гишүүн П.Оюундэлгэр (Хууль зүйн магистр LL.M), өмгөөлөгч

Багийн гишүүн Б.Мөнхбат (Хууль зүйн магистр), өмгөөлөгч

Багийн гишүүн Б.Оюунтуул (Хууль зүйн магистр), өмгөөлөгч

Багийн гишүүн Э.Эрдэнэцэцэг (Хууль зүйн магистр), өмгөөлөгч

Багийн гишүүн Э.Шүрэнцэцэг, хуульч

Багийн гишүүн Т.Эрхбилгүүн, хуульч

АГУУЛГА

<u>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ</u>	<u>5</u>
<u>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</u>	<u>6</u>
<u>ГРАФИКИЙН ЖАГСААЛТ</u>	<u>6</u>
<u>ЯРИЛЦЛАГЫН ЖАГСААЛТ</u>	<u>6</u>
<u>НЭГ. УДИРТГАЛ.....</u>	<u>7</u>
1.1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО	7
1.2. СУДАЛГААНЫ АСУУДАЛ	9
1.3. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ	9
1.4. СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ.....	12
1.5. СУДАЛГААНЫ АРГА	12
<u>ХОЁР. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</u>	<u>12</u>
2.1. Судалгааны ажлын төлөвлөгөө	12
2.2. СУДЛААЧДЫН СУРГАЛТ	14
2.3. СУДАЛГААНЫ БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	15
<u>ГУРАВ. АРИЛЖААНЫ ЗАНШИЛ, ТОГТСОН ПРАКТИКИЙГ ОЙЛГОХ НЬ</u>	<u>16</u>
3.1. АРГА ЗҮЙН АСУУДАЛ.....	16
3.2. ЗАНШИЛ, ТОГТСОН ПРАКТИКИЙН УХАГДАХУУН	18
3.2.1. Монголын эрдэмтэн, судлаачдын заншлын талаарх байр суурь	18
3.2.2. Гадаадын зарим улсад заншлыг авч үзсэн нь	20
3.2.3. Арилжааны заншил, тогтсон практикийг ялгах асуудал	22
3.3. Дүн шинжилгээ	25
<u>ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ</u>	<u>27</u>
4.1. Монгол Улсын олон улсын гэрээнд арилжааны заншил, тогтсон практикийн талаар тусгасан нь.....	27
4.2. Хуульд арилжааны заншил, тогтсон практикийн талаар тусгасан нь	27
4.3. Дүн шинжилгээ	31
<u>ТАВ. АРИЛЖААНЫ ЗАНШИЛ, ТОГТСОН ПРАКТИКТ ХОЛБОГДОХ ШҮҮХ, АРБИТРЫН ШИЙДВЭР</u>	<u>33</u>
5.1. АРИЛЖААНЫ ЗАНШИЛД ХОЛБОГДОХ ШҮҮХ, АРБИТРЫН ШИЙДВЭР	33
5.2. АРИЛЖААНЫ ОРЧИНД ТОГТСОН ПРАКТИКТ ХОЛБОГДОХ ШҮҮХ, АРБИТРЫН ШИЙДВЭР	41
5.3. Дүн шинжилгээ	44
<u>ЗУРГАА. АРИЛЖААНЫ ХҮРЭЭНД ТОГТСОН ПРАКТИКИЙН ЖИШЭЭ</u>	<u>45</u>
6.1. Ярилцлагын, ажиглалтын болон баримт бичгийн судалгааны дүн	45

1. Зээлийн харилцаанд	45
2.Барьцаа хөрөнгийн үнэлгээний харилцаанд	48
3. Түрээсийн харилцаанд	48
4. Үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах харилцаанд.....	49
5. Ажил, үүргээ дүгнэхтэй холбоотой харилцаанд	50
6. Итгэлцэлтэй холбоотой харилцаанд	50
7.Компанийн харилцаанд	51
8.Фидуцийн харилцаанд	52
9.Гэрээний харилцаанд	53
10.Бизнесийг шилжүүлэхтэй холбоотой харилцаанд	54
11.Үүрэн телефоны сүлжээгээр дамжуулан хэлцэл байгуулах.....	55
12. Цахим орчин дахь арилжааны харилцаанд.....	55
13. Газрын харилцаанд	55
13. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал	56
14. Төлбөр тооцооны харилцаанд	56
15. Өрсөлдөгч, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад шилжин ажиллах тухай	57
6.2. Дүн шинжилгээ	57
<u>ДОЛОО. ДҮГНЭЛТ, САНАЛ.....</u>	<u>60</u>
<u>ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ</u>	<u>63</u>

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

1. **ОХУ**- Оросын Холбооны Улс
2. **ХБНГУ**- Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
3. **БНСУ**- Бүгд Найрамдах Солонгос Улс
4. **БНХАУ**- Бүгд Найрамдах Хятад Ард Улс
5. **ИХ**- Иргэний хууль
6. **ААН**- Аж ахуйн нэгж
7. **ХХК**- Хязгаарлагдмал хариуцлагатай компани
8. **ХК**- Хувьцаат компани
9. **ТӨҮГ**- Төрийн Өмчит Үйлдвэрийн газар
10. **НӨАТ**- Нэмэгдсэн өртгийн албан татвар
11. **СБД ЗДТГ**- Сүхбаатар дүүрэг Засаг Даргын Тамгын газар
12. **ТББ**-Төрийн бус байгууллага

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн болон байгууллагын мэдээлэл	11
Хүснэгт 2. Судалгааны ажлын төлөвлөгөө.....	12
Хүснэгт 3. Арилжааны заншлын хэм хэмжээний талаар дурдсан хууль.....	28
Хүснэгт 4. Арилжааны хүрээнд тогтсон практикийн талаар дурдсан хууль.....	29

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Үйл ажиллагааны салбарын ангилал	12
---	----

ЯРИЛЦЛАГЫН ЖАГСААЛТ

Шигтгээ 1. “ДХА” ХХК-ийн менежертэй хийсэн ярилцлагаас.....	
Шигтгээ 2. “Б компьютерс” ХХК-ийн захирлын туслахтай хийсэн ярилцлагаас.....	
Шигтгээ 3. “БНБ” ХХК-ийн нягтлан бодогчтой хийсэн ярилцлагаас.....	
Шигтгээ 4. Иргэн А-тай хийсэн ярилцлагаас.....	
Шигтгээ 5. “Р” ХХК-ийн захиралтай хийсэн ярилцлагаас.....	
Шигтгээ 6. Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2017-06-18-ны өдрийн 287 дугаар магадлалын хэсгээс.....	
Шигтгээ 7. Баянзүрх дүүргийн оршин суугч Б-тэй хийсэн ярилцлагаас.....	
Шигтгээ 8. Өмчлөгч “Ж”-тэй хийсэн ярилцлагаас.....	
Шигтгээ 9. “МТ” ХХК-ийн гүйцэтгэх захиралтай хийсэн ярилцлагаас	
Шигтгээ 10. “СМ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч Т-тэй хийсэн ярилцлагаас	
Шигтгээ 11. “Ж” ХХК-ийн 50 хувийн хувьцаа эзэмшигч иргэн А-тай хийсэн ярилцлагаас	
Шигтгээ 12. Монгол улсын дээд шүүхийн 2017-12-05-ны өдрийн 01540 дугаар шүүхийн тогтоолын хэсгээс.....	
Шигтгээ 13. “СТР” ХХК-ийн ахлах хянагчтай хийсэн ярилцлагаас.....	
Шигтгээ 14. “СМГ” ХХК-ийн ерөнхий менежертэй хийсэн ярилцлагаас.....	
Шигтгээ 15. “Ц” ХХК-ийн борлуулагчтай хийсэн ярилцлагаас.....	
Шигтгээ 16. “ХОМ” ХХК-ийн борлуулалтын албаны ахлах менежертэй хийсэн ярилцлагаас.....	
Шигтгээ 17. “Unegui.mn” вэбсайтаас.....	
Шигтгээ 18. “ББ” ХХК-ийн захиралтай хийсэн ярилцлагаас.....	
Шигтгээ 19. “У” рестораны захирал “Ч”-тэй хийсэн ярилцлагаас.....	
Шигтгээ 20. “Т” ХХК-ийн захирал “ПР”-тэй хийсэн ярилцлагаас.....	

НЭГ. УДИРТГАЛ

1.1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Нийгмийн бүхий л харилцааг тэр дундаа талуудын хүсэл зоригт суурилсан бизнес (арилжаа)-ийн харилцааг хууль тогтоомжоор бүрэн зохицуулах боломжгүй тул бичмэл бус эх сурвалж болох заншлын хэм хэмжээ чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Зарим бүтээлд “бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн заншил нь эзэн хааны зарлигтай адил хуулийн дээд хүчин чадалтай”¹ байдаг гэсэн байхаас гадна заншил нь ард түмний дунд бий болсон байдгаараа легитим чанар нь төлөөллийн ардчилалд үндэслэсэн парламентаас баталсан хуулиас илүү гэж үзэх нь бий.

Мөн арилжааны үйл ажиллагаа эрхлэх явцад тодорхой бизнес эрхлэгч (арилжаа эрхлэгч)-дийн хооронд ажил хэргээ явуулдаг практик тогтох нь бий. Энэхүү тогтсон практик бизнес эрхлэгч (арилжаа эрхлэгч)-дийн өөрсдийнх нь хүсэл зоригт үндэслэн бий болсон, өөрөө сайн дураар даган биелүүлэх дэг жаяг болдгоороо шударга ёсыг тогтооход ихээхэн ач холбогдолтой гэсэн логикт үндэслэсэн гадаадын олон улсын хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилсээр байна.

Монгол Улсад заншлын хэм хэмжээг арилжаа (худалдаа)-ны харилцаанд хуулиас гадна нэн чухал эрх зүйн эх сурвалж болохыг хүлээн зөвшөөрдөг. Эл судалгааны хүрээнд арилжааны орчинд тогтсон практик болон заншлыг нээн илрүүлэхийн тулд бичиг баримт судлах, ярилцлага, ажиглалтын аргаар мэдээлэл цуглуулж шинжилгээ хийхийн зэрэгцээ заншлын талаарх гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачдын байр суурь, хууль тогтоомжийн зохицуулалт, заншлын хэм хэмжээг хэрэглэсэн шүүх, арбитрын шийдвэр болон бизнесийн харилцаанд тогтсон практикийг авч үзэх болно.

Энэ судалгаа нь арилжаа эрхлэгчдийн хооронд болон арилжаа эрхлэгч хэрэглэгчийн хооронд үүсэж тогтсон практик, арилжааны заншил Монголын арилжааны орчинд байгаа гэсэн таамаглалд үндэслэн, эдгээрийг судлах зорилготой болно.

Монголчуудад аж ахуйн шинжтэй харилцаа, түүний үндсэн суурь болсон өмчийг хамгаалан дэмжиж ирсэн уламжлал бий. Монголын орчин үеийн түүхэнд Иргэний хуулийг 1926-1929 онд бүлэг бүлгээр баталсан бол 1934 онд хэмжээний хувьд төдийлөн том биш “БНМАУ-ын Худалдааны тухай хууль”² -ийг “гадаад худалдааны тухай”, “дотоод худалдааны тухай” гэсэн хоёр бүлэгтэйгээр баталж, тус хуулийн хоёрдугаар бүлгээр “худалдааны байгууллага ба хүмүүс”, “худалдааны зүйл, улсын ба копиративын худалдаа”, “хэрэглэгчдийн хоршоо хэмээх худалдааны хоршоо”, “энгийн худалдаа, тэмдэгт ба албан татвар”, “хууль цаазын талаар холбогдох худалдаа”, “худалдааг тэгшитгэх ба худалдааны

¹ Г. Ф. Шершеневич. Учебник русского гражданского права (по изданию 1907 г.). стр. 39

² Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл III боть /1926 VI сар-1936/ УБ. 2010., 625-628 дахь тал

явууллагын талаар хуулийг хэрхэн биелүүлж байгаад хяналтыг тавих” зэрэг харилцааг зохицуулж байсан.

1940 оны Үндсэн хуульд 1949 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “хувийн өмч”-ийг “аминч өмч” болгон улмаар 1952 оны Иргэний хуулийн 31 дүгээр зүйлд өмчийн төрлийг “улсын өмч, хоршооллын ба бусад олон нийтийн байгууллагуудын өмч, ард иргэдийн амины өмч”³ гэж ангилан зааж “бүх газар шороо ба түүний хөрсөн доторхи зүйлүүд, ой мод, ус ба тэдгээрийн баялаг, фабрик, завод, төмөрлөгийн уурхай, алт боловсруулах явдал, төмөр, авто тээврийн зам, усан ба агаарын тээвэр, холбоо харилцааны хэрэгсэл, банк, машинаар өвс хадах станц, улсын аж ахуйнууд, ангийн буунаас бусад буунууд, тэсрэх бодисууд, улсын бүх барилгууд, түүнчлэн орон сууцны барилгууд” нь гагцхүү улсын өмч байна гэж хуульчилсан. Харин ард иргэдийн амины өмчид 1940 оны Үндсэн хуулийн зургадугаар зүйлд заасан “ард иргэдээс мал ба хөдөө аж ахуйн багаж зэвсэг хийгээд үйлдвэрлэлийн бусад багаж зэвсэг, түүхий эд, мөн боловсруулсан үйлдэхүүн, орон сууц, хашаа, барилга, гэр хогшил, орлого” зэргийг хамааруулахаар зааж, өмчийн хүрээ хязгаарыг нэрлэн заасан түүхтэй. Ийнхүү уламжлагдан ирсэн хувийн өмчийн ойлголт, үзэл сэтгэлгээг амины өмч болгон явцууруулсан нь цаашид хувийн өмчид суурилсан аж ахуй, арилжааны харилцаа үгүйсгэгдэх эх үндэс болсон байна.

1960 оны Үндсэн хуулийн есдүгээр зүйлд “...социалист өмч бол улсын /бүх ард түмний хөрөнгө/, хоршооллын /хөдөө аж ахуйн нэгдэл ба бусад төрлийн хоршооллын хөрөнгө/ ийм хоёр хэлбэртэй байна” гэж заагаад улсын өмчид “бүх газар, түүний хөрсөн доорхи баялаг, ой мод, гол ус, тэдгээрийн баялаг, улсын фабрик, завод, уурхай, цахилгаан станц, төмөр зам, авто машин, усан ба агаарын тээвэр, засмал зам, холбооны хэрэгсэл, банк, улсын хөдөө аж ахуйн үйлдвэрийн газар /сангийн аж ахуй, мал аж ахуйн машинт станц зэрэг/, улсын нийгэм ахуйн газар, хот, суурин газрын орон сууцны улсын үндсэн фонд, улсын үйлдвэрийн түүхий эд, материал, бүтээгдэхүүн, улсын худалдаа бэлтгэлийн ба соёл, шинжлэх ухааны газрууд, мөн улсын бүх байгууллагын эд хөрөнгө”⁴ орохоор, амины өмчид “иргэдийн хөдөлмөрлөж олсон орлого, хадгаламж, орон сууц, амины туслах аж ахуй, амины хэрэгцээт зүйлс, гэрийн эд хогшлыг”⁵ хамаарахаар хуульчилж, амины өмчийн эрхийг улс нийгмийн эрх ашигт харш ашиглаж үл болно гэж заасан.

1963 оны Иргэний хуулиар өмчийн төрлийг “социалист өмч”, “амины өмч” гэж ангилсан. Социалист өмч нь улсын өмчид (бүх ард түмний хөрөнгө), хоршооллын өмч (хөдөө аж ахуйн нэгдэл, хоршооллын бусад байгууллагын өмч), үйлдвэрчний эвлэл, олон нийтийн бусад байгууллагын өмчөөс бүрдэж байсан. Ийнхүү социалист системийн үед хувийн өмчийг үгүйсгэн хязгаарлахын зэрэгцээ хувийн өмчийн аж ахуй, арилжааны харилцааг “дамын наймаа”, “мөлжлөг” гэж үзэж хориглох болсон.

Тус улсад 1990 онд өрнөсөн ардчилсан хөдөлгөөний дүнд өмчийн олон хэвшил бүхий эдийн засагтай нийгмийг сонгож авсан нь нийгмийн бүхий л хүрээ,

³ Монгол Улсын иргэний хууль тогтоомж (түүхэн эмхтгэл) 1206-2012. УБ. 2012., 86 дахь тал.

⁴ Эмхэтгэсэн. Д.Батаа. Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүд /1924-1992/. УБ.1998., 49 дэх тал.

⁵ Мөн тэнд. 50 дахь тал.

салбарыг хамарсан шинэтгэл хийх эхлэл болсон билээ. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 1990 оны 5 дугаар сарын 10-ны өдөр БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийг баталсан бол 1990 оны 12 дугаар сарын 6-ны өдөр Иргэний хуулийн өмчийн хэсгийг өөрчлөн найруулж⁶, амины өмч бус “хувийн өмч”-ийг, “социалист өмч” бус “нийтийн өмч”-ийг хүлээн зөвшөөрч, улмаар 1992 онд Үндсэн хуулиа баталж мөрдсөнөөр бүхий л хууль тогтоомжийг Үндсэн хуульд нийцүүлэн хувийн өмчид суурилсан аж ахуй, арилжааны харилцаа хөгжих суурь тавигдсан билээ.

Энэ судалгааны хувьд сүүлийн 10 орчим жилийн хугацаанд хамаарах шүүх, арбитрын шийдвэрийг судалснаас гадна цаг хугацааны хувьд тухайлсан арилжааны заншил, тогтсон практик хэдийд бий болсон нь туйлын тодорхой бус хэдий ч 1990 оноос өмнө эдийн засгийн харилцаа явагдаж байсан утгаараа арилжааны заншил, тогтсон практик байх магадлалтай гэж үзсэн болно.

1.2. СУДАЛГААНЫ АСУУДАЛ

Судалгааны хүрээнд шийдвэрлэх дараах асуудлууд байна. Үүнд:

- Монгол Улс дахь бизнесийн орчин (цаашид арилжааны орчин гэх), практикийг судалсны үндсэн дээр ажил хэргийн хүрээнд тогтсон заншил (цаашид арилжааны заншил гэх), тогтсон практик байгаа эсэхийг тодруулах;
- Монгол Улс дахь арилжааны орчинд нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш арилжааны заншил, тогтсон практик байгаа эсэх, анхаарах асуудал;
- Монгол Улсын холбогдох олон улсын гэрээ, хуульд арилжааны заншил, тогтсон практикийн асуудлыг хэрхэн авч үзсэн, анхаарах асуудал байгаа эсэх;
- Шүүх, арбитр арилжааны заншил, тогтсон практикийг талаар шийдвэртээ тусгасан эсэх, тийм бол хэрхэн авч үзэж байгаад дүн шинжилгээ хийх.

1.3. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү судалгааг дараах хүрээнд хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. Гол мэдээлэгч (*key informant*) буюу бизнесийн тухайн салбарын талаар өргөн мэдлэгтэй 73 бизнес эрхлэгч (арилжаа эрхлэгч)-тэй ярилцлага хийсэн болно. Үүнд:
 - Компани, нөхөрлөл, хувиараа бизнес эрхлэгч (1-9 ажилтантай)-ээс 29 ярилцлага;
 - Компани, нөхөрлөл, хувиараа бизнес эрхлэгч (10-49 ажилтантай)-ээс 27 ярилцлага;
 - Компани, нөхөрлөл, хувиараа бизнес эрхлэгч (50-аас дээш ажилтантай)-ээс 16 ярилцлага
 - Төрийн бус байгууллага (1-9 ажилтантай)-аас 1 ярилцлага.

⁶ Иргэний хуулиуд /1926, 1952, 1963, 1994, 2002/, нэмэлт, өөрчлөлтүүд II боть. УБ. 2002., 164-165 дахь тал.

2. Заншлын талаарх Монголын болон гадаадын зарим улсын эрдэмтэн, судлаачдын үзэл баримтлалд шинжилгээ хийсэн болно.
3. Арилжааны заншил, практикт холбогдох шүүх, арбитрын практикийг судалж тэдгээрт дүн шинжилгээ хийсэн болно.

Ярилцлагын судалгаа

Дэлхий нийтийг цочроосон COVID-19 цар тахал улс орон даяар тархаж, манай улсад хорио цээрийн дэглэм тогтоосны улмаас ярилцлагын судалгааг биечлэн уулзалт, ярилцлага хийх аргаар явуулах боломж хязгаарлагдсан нөхцөл байдал үүссэн болно.

Иймд ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулахдаа тухайн бизнесийн салбарын гол мэдээлэгч (key informant) буюу өргөн мэдлэг бүхий үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, гишүүн, гүйцэтгэх удирдлага, удирдах албан тушаалтан, менежер, санхүү хариуцсан ажилтан (нягтлан бодогч), хуулийн зөвлөхүүдтэй утсаар, цахим шуудан ба олон нийтийн цахим суваг (фэйсбүүк/Facebook/, вайбер /viber/, телеграм/telegram/, вичат /we chat/, зүүм/zoom/ гэх мэт)-аар дамжуулан харилцах аргыг ашигласан болно.

Судалгааны ажлын даалгаварт Улаанбаатар хот болон шаардлагатай тохиолдолд бусад төв суурин газруудын бизнес эрхлэгчдийг ажилтан (ажиллах хүч)-ы тоо болон хуулийн этгээдийн хэлбэрийг харгалзан хамруулсан болно.

Тиймээс Улаанбаатар хотод байршилтай нийт 73 бизнес эрхлэгчдийг ажилтан (ажиллах хүч)-ы тоо болон хуулийн этгээдийн хэлбэрийг харгалзахгүй ярилцлагын судалгаанд хамруулсан бөгөөд үүнээс 44.4 хувийг биечлэн уулзаж, 20.9 хувийг утсаар харилцаж, 34.7 хувийг цахим шуудан ба олон нийтийн цахим суваг (фэйсбүүк/Facebook/, вайбер /viber/, телеграм/telegram/, вичат /we chat/, зүүм/zoom/ гэх мэт) ашиглан ярилцаж мэдээллийг цуглуулсан болно.

Мөн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны салбарын ангиллыг харгалзаагүй ч ярилцлагын мэдээллийг дүгнэхийн тулд тэдгээрийн үйл ажиллагааг Монгол Улсын эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилалд заасныг баримталсан болно.

Судалгаанд 73 бизнес эрхлэгч тэдгээрийн гол мэдээлэгч (key informant) хамрагдаж, ганцаарчилсан аргаар мэдээлэл өгсөн болно. Үүнээс бизнес эрхлэгчдийг хуулийн этгээдийн хэлбэрээр нь ангилан авч үзвэл, 91.7 хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 4.10 хувь нь хувьцаат компани, 2.73 хувь нь нөхөрлөл, 1.36 хувь нь төрийн бус байгууллага байна. Эдгээр бизнес эрхлэгчдийн 41.09 хувь нь 1-9, 36.9 хувь нь 10-49, 21.9 хувь нь 50-2300 ажилтан (ажилтны тоо)-тай байна.

Харин судалгаанд оролцсон гол мэдээлэгч (key informant)-дийн 51.7 хувь нь үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, гишүүн, 9.58 хувь нь гүйцэтгэх удирдлага, 4.10 хувь нь санхүү хариуцсан албан тушаалтан, 17.8 хувь нь хуулийн зөвлөх, 4.10 хувь нь салбарын захирал, нэгж хариуцсан албан тушаалтан, 10.95 хувь нь ерөнхий менежер, ахлагч, 2.73 хувь нь бусад мэргэжилтэнүүд байсан бөгөөд бизнесийн үйл ажиллагаанд оролцогчийн бүхий л төлөөллийг хамруулснаараа энэхүү судалгаа онцлогтой юм. Өөрөөр хэлбэл, эдгээр хүмүүс нь бизнесийн үйл

ажиллагааны алхам тутамд гар бие оролцдог тул үүсч буй бэрхшээл, тулгамдаж байгаа асуудлуудыг нээн илрүүлэхэд чухал ач холбогдолтой байлаа. (хүснэгт №1-ээс харна уу.)

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн болон байгууллагын мэдээлэл

№	Ерөнхий агуулга	Тоо	Хувь
Бизнес эрхлэгчдийн хуулийн этгээдийн хэлбэр			
1	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	67	91,7
2	Хувьцаат компани	3	4,10
3	Нөхөрлөл	2	2,73
4	Төрийн бус байгууллага	1	1,36
Ажилтаны тоо			
1	1-9 хүнтэй	30	41.09
2	10-49 хүнтэй	27	36.9
3	50-2300 хүнтэй	16	21.9
Гол мэдээлэгч (key informant)			
1	Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, нөхөрлөлийн гишүүн	37	51.7
2	Гүйцэтгэх удирдлага	7	9.58
3	Санхүү хариуцсан албан тушаалтан	3	4.10
4	Хуулийн зөвлөх	13	17.8
5	Салбарын захирал, нэгж хариуцсан албан тушаалтан	3	4.10
6	Ерөнхий менежер, ахлагч	8	10.95
7	Мэргэжилтэн болон бусад	2	2.73

Судалгаанд оролцогчдын бизнесийн үйл ажиллагааны салбарыг ангилахын тулд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомжийг баримталсан бөгөөд Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаалаар “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”⁷-ын шинэчилсэн хувилбарыг баталжээ.

Тус ангиллын дагуу судалгаанд оролцогчдын үйл ажиллагааны салбарын ангиллыг харуулбал, 31.5 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 19.17 хувь нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, 13.69 хувь нь уул уурхай, олборлолт, 9.58 хувь нь мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, 6.84 хувь нь барилга, 4.1 хувь нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 4.1 хувь нь хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ, 4.1 хувь нь тээвэр, агуулахын үйл ажиллагаа, 1.36 хувь нь үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, 1.36 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас, ан агнуур, 1.36 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 1.36 хувь нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны газрын үйл ажиллагааг эрхэлж байна. (график № 1-ээс харна уу.)

⁷ Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2018 оны 319, А/160 дугаар тушаалын хавсралт

График 1. Үйл ажиллагааны салбарын ангилал

1.4. СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

2019 онд ХБНГУ-ын Ханнс Зайделийн сангийн дэмжлэгтэйгээр “Арилжаа (худалдаа)-ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа”⁸-г хийж гүйцэтгэсэн байна. Заншлын талаар зарим доктор, магистрын ажил, илтгэл зэрэг судалгаа хийгдсэн боловч Монгол Улсын арилжааны орчинд тогтсон практик, заншлыг нээн илрүүлэхтэй холбоотой судалгаа өмнө нь хийгдэж байгаагүй тул шинэлэг бөгөөд практик ач холбогдолтой юм.

1.5. СУДАЛГААНЫ АРГА

Уг судалгааны мэдээлэл цуглуулахад шүүхийн шийдвэр зэрэг баримт бичиг судлах, ярилцлага (ганцаарчилсан) хийх, ажиглалтын аргууд ашигласан болно.

ХОЁР. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Судалгааны ажлын төлөвлөгөө

Судалгааны ажлыг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр дараах ажлын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

Хүснэгт 2. Судалгааны ажлын төлөвлөгөө

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа		Ажиллах хугацаа											
	Нийт 180 хоног		1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар					
СУДАЛГААНЫ БЭЛТГЭЛ ҮЕ ШАТ													
1.	Багийн гишүүд, захиалагч талтай уулзалт хийх												

⁸. <http://legaldata.mn/b/519>

2.	Судалгааны хөтөлбөрийг эцэслэн боловсруулах																		
3.	Сургалт явуулах: тоологчид болон операторууд, судалгааны багийн гишүүдэд зориулсан сургалт																		
4.	Талбарт судалгаа хийх зохион байгуулалтын бэлтгэлийг хангах, судалгааны талбарт гарах																		
СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮЕ ШАТ: МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, ӨГӨГДӨЛ ОРУУЛАХ																			
1.	Судалгаа авах байгууллагуудын байршил, мэдээлэлтэй танилцах																		
2.	Тухайн талбараас түүврийг нарийвчлан тодорхойлох																		
3.	Судалгааны багууд талбараас мэдээлэл цуглуулах (ярилцлага, ажиглалт, бичиг баримт судлах)																		
4.	Судалгааны мэдээлэл цуглуулах ажлын явцын тайланг гаргах																		
5.	Цуглуулсан мэдээллийг программд оруулах																		
6.	Цуглуулсан мэдээллийн чанарыг шалгах																		
7.	Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж тайлан гаргах																		
8.	Холбогдох хууль тогтоомж болон Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээг судлах																		
9.	Заншлын хэм хэмжээ хэрэглэсэн шүүхийн практик болон тогтсон практикийг судлах																		
10.	Заншлын талаар гадаадын зарим улс болон Монголын судлаач, эрдэмтдийн байр суурийг судлах																		
СУДАЛГААНЫ ТӨГСГӨЛ ҮЕ ШАТ: МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, ТАЙЛАН БОЛОВСРУУЛАХ																			

	талаар сургалт хийсэн.	өдөр	
4.	Судалгаа авах байгууллагуудын байршил, мэдээллийг судлаачдад танилцуулж, судалгаа авах байгууллагын байршлыг судлаачдад хуваарилсан.	2020 оны 1-р сарын 20-ны өдөр	Судалгааны багийн гишүүд
5	Судалгааны үр дүнг нэгтгэх, хянахтай холбоотой уулзалт	2020 оны 2-р сарын 19-ний өдөр	Судалгааны багийн гишүүд

2.3. СУДАЛГААНЫ БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Судалгааны багийн ахлагч ажлын төлөвлөгөөний дагуу судлаачдыг багийн зохион байгуулалтад оруулж, ажил үүргийг хуваарилан, ажлын чиглэлийг нарийвчлан танилцуулж, тэдний ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэн ажилласан. Тус судалгааны багийн хуваарилалтыг дараах схемээс харна уу.

Тус судалгааг гүйцэтгэхэд багийн ахлагч 1, багийн гишүүн буюу судалгааны мэдээлэл цуглуулах, баримт бичгийн судалгаа хийх 6, мэдээллийг нэгтгэх 2, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллав.

ГУРАВ. АРИЛЖААНЫ ЗАНШИЛ, ТОГТСОН ПРАКТИКИЙГ ОЙЛГОХ НЬ

3.1. Арга зүйн асуудал

Энэхүү судалгааны хүрээнд дараах алхам (2, 3, 4 дэх алхам нь заавал нэг нэгэндээ үндэслэх шаардлагагүй, зэрэг эхлэх боломжтой)-ыг хийсний үндсэн дээр судалгааны зорилго, зорилтыг биелүүлсэн болно. Энэхүү зорилго, зорилтыг биелүүлэхийн тулд судалгааны тавигдсан асуултад хариулах арга зүйгээр судалгааны ажил хийгдлээ.

1. Юуны түрүүнд заншил хэмээх ухагдахууныг онолын хувьд ямар агуулгатай болохыг Монголын судлаачид хэрхэн ойлгож байгааг судалсан бөгөөд

судалгааны асуудлын харьцангуй бага судлагдсантай холбоотойгоор арилжааны олон зуун жилийн хөгжлийн түүхтэй гадаадын улсуудад заншлыг хэрхэн үздэгийг товч хөндсөн. Энэ үндсэн дээр заншил, тодруулбал арилжааны эрх зүйн заншил, түүний шинжийн талаар судлаачдын нэгдмэл байр суурь байгаа эсэх, тогтсон практик болон бусад холбогдох ойлголтуудтай хэрхэн холбогдох, уялдан тогтоохыг зорьсон. Энэ нь арилжааны заншлыг ажил хэргийн хүрээнд тогтсон практик, худалдааны аргаас ялгаж салгах, улмаар судалгааны үр дүн алдаагүй гарахад суурь хүчин зүйл болох ёстой юм.

2. Ярилцлагын болон ажиглалтын аргын хүрээнд заншил хэмээн арилжаа эрхлэгчид ойлгож байгаа зан үйлийн журам байгаа эсэхийг тандан судалсан (энэ нь арилжааны заншил болно) бөгөөд арилжаа эрхлэгчид түүнийг хуулийн адилаар дагаж мөрдөх ёстой гэж ухамсарлаж (*opinio juris*) байвал эсхүл шүүх, арбитр хүлээн зөвшөөрсөн тохиолдолд арилжааны заншлын эрх зүйн хэм хэмжээ болох юм. Гэхдээ хүмүүс нь тодорхой заншлыг *opinion juris* гэж ойлгохгүй байвал энэ заншлын эрх зүйн хэм хэмжээ бус заншил төдий эрх зүйн үр дагаваргүй байж болохыг харгалзан үзсэн болно.

Мөн арилжаа эрхлэгч тодорхой этгээдүүдийн дунд тогтсон практик байгаа эсэхийг тандан судалсан. Арилжааны тогтсон практикийн хувьд субъектээр нь авч үзвэл тодорхой арилжаа эрхлэгч хоорондын харилцаанд болон арилжаа эрхлэгч, хэрэглэгчийн хооронд гэсэн 2 хувилбараар бүрэлдэн тогтох боломжтой юм.

3. Ийнхүү тодорхойлсон үндсэн ойлголтыг “заншил”, “практик” хэмээх түлхүүр үгсийн тусламжтайгаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль (2020 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар)-д хэрхэн туссан болохыг шүүж үзлээ. Ийнхүү хуулиас хайлт хийх арга зүйн үндэслэл нь нэгдүгээрт, Монгол Улс өөрийн эрх зүйн тогтолцоогоо эх газрын эрх зүйн бүлд хамааруулдаг гэж үздэг, хоёрдугаарт, Монгол Улсын эрх зүйн тогтолцоо, хууль зүйн практикт хууль хэмээх бичигдмэл эрх зүйн эх сурвалжийг голлох (ухамсартай, ухамсаргүйгээр цорын ганц легитим эх сурвалж хэмээн үзэх) хандлага илт давамгайлдаг байх магадлалтайг харгалзсан, гуравдугаарт, арилжааны эрх зүйн хувьд өндөр ач холбогдолтой субъект болох шүүх, арбитр нь заншил, практикийн асуудлыг зөвхөн хуульд заасан, зөвшөөрсөн, хориглосон бол анхааралдаа авдаг байх магадлалтай гэж үзсэнтэй холбоотой юм.

Энэ хүрээнд хэрэв заншил хэмээн тодорхойлж болох зүйлийг хууль тогтоогчид хуульд тусгавал заншил байхаа больж, харин хуульд тусгагдсан заншлаас уг сурвалжтай эрх зүйн хэм хэмжээ болдгийг ялгаж салган ойлгох нь арга зүйн хувьд төөрөгдөхөөс сэргийлэх учиртай. Энэ түүх Францын Иргэний хууль (Наполеоны кодекс) батлагдахад гарч байсныг санахад илүүдэхгүй юм.

4. Парламентаас баталсан бичигдмэл эх сурвалж болох хуулиас гадна тодорхой маргаан шийдвэрлэсэн шүүх, арбитр нь арилжааны заншил, тогтсон практикийг олж тогтоосон эсэх, заншил, практикийн хэрхэн авч үздэг, тэдгээр нь гаргасан шийдвэрийн үндэслэл, тогтоох хэсэгтээ заншил, тогтсон практикийг эрх зүйн эх сурвалж хэмээн үзэж байгаа эсэх эсхүл шийдвэр гаргахдаа заншил,

тогтсон практикийг харгалзан үзэх эх сурвалж болгосон эсэх, ер нь заншил, тогтсон практикийг эрх зүйн ямар ач холбогдолтойг судаллаа. Ингэхдээ “заншил”, “практик” гэсэн үгийн үндэстэй түлхүүр үгсээр шүүхийн шийдвэрийн www.shuuh.mn дата сангаас 2013-2020 оныг хамруулан, МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын олон улсын арбитрын шийдвэрийн 2006-2019 оны оныг хамруулан хайлт хийсэн болно.

5. Ийнхүү арилжаа эрхлэгчидтэй ярилцлага хийх, тэдний үйл ажиллагааг ажиглах, бичиг баримт (хууль, шүүх, арбитрын шийдвэр)-ыг судлах явцдаа судлаачдын нээн илрүүлсэн гэгдэх арилжааны заншлын эрх зүйн хэм хэмжээ, тогтсон практик нь хууль (*contra legem*), нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцэж байгаа эсэх талаар таамаглал дэвшүүлэн, дүгнэлт хийсэн болно. Аливаа судалгааны объектив шинжийг бууруулдаг эрсдэлт хүчин зүйл болох судалгааг хийсэн судлаачдын субъектив үнэлэмж аль болох нөлөөлөхгүй байх үүднээс нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш эсэх гэсэн шалгуурыг гол болгосон.

3.2. Заншил, тогтсон практикийн ухагдахуун

3.2.1. Монголын эрдэмтэн, судлаачдын заншлын талаарх байр суурь

“Заншил” гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт “ёс журам болсон юм”⁹ гэсэн бол Монгол хэлний товч тайлбар тольд “хэв журам болсон юм”¹⁰ гэж тайлбарлажээ. Өөрөөр хэлбэл, хүний үйл хөдлөлд нөлөөлдөг зүйл гэсэн утга хэл зүйн хувьд яригдаж байна..

Монголын эрх зүйн эх толь бичигт “**эрх зүйн заншил**”- (*анг. legal custom; ор. правовой обычай*) гэж олон удаа давтагдан хэвших замаар зан үйлийн журам болж, төрийн хамгаалалтад авагдсан хийгээд түүний албадлагын хүчээр хангагддаг тодорхой нийгэмд (буюу газар нутаг) түүхэн ёсоор бүрэлдэн тогтсон зан үйл... Эрх зүйн зан заншлын нийлбэр цогц нь заншлын эрх зүйг бүрдүүлнэ”¹¹ гэсэн байна. Заншлыг хэл зүйн утгаар нь авч үзвэл тогтсон хэвшил журам болсон зүйлийг хэлэх бол хууль зүйн утгаараа олон удаа давтагдан хэвших замаар зан үйлийн журам болж, төрийн албадлагын хүчээр хангагддаг нийгэмд бүрэлдэн тогтсон зан үйл гэж үзэж байна.

Монголын хууль зүйн салбарын зарим эрдэмтэн, судлаачид “заншил”, “эрх зүйн зан заншил”, “эрх зүйн заншил”, “заншлын хэм хэмжээ” гэсэн харилцан адилгүй нэр томьёо хэрэглэн заншлын талаар өөрсдийн байр суурийг илэрхийлсэн байдаг. Доктор, профессор И.Дашням “Чингис хааны үеийн “Их засаг” хэмээх Монголчуудын анхны төрөлжүүлэн нэгтгэсэн бичмэл хууль нь заншлын эрх зүйн хэм хэмжээ, эрх зүйн хэмжээний хослол, харилцан хамаарлыг багтаасныг яруу тод харуулсны бодит үлгэр жишээ мөн”¹² болохыг онцлон тэмдэглээд

⁹. Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь. УБ. 2018., 155 дахь тал.

¹⁰. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966., 267 дахь тал.

¹¹. С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. Хоёр дахь хэвлэл. УБ. 2008., 611-612 дахь тал.

¹². И.Дашням. Заншлын эрх зүйн хэм хэмжээний харилцан хамаарлын асуудал. Монгол ба буриадын зан заншил, заншлын эрх зүй. УБ. 2008., 7-8 дахь тал.

заншлын хэм хэмжээ үйлчилсэн цаг хугацааны хамаарлыг дараах үеүдэд хуваан авч үзсэн байна. Үүнд:

1. Овог аймгууд бүрэлдсэн үеэс төр үүсэх хүртэлх хугацаанд заншлын хэм хэмжээ тогтон, дангаараа үйлчилсэн үе;

2. Төр үүссэн үеэс заншлын хэм хэмжээ төрөөр зөвшөөрөгдөж түүний баталсан хууль зүйн актуудад илэрхийлэгдсэн, заншлын ба эрх зүйн хэм хэмжээний хамт үйлчилсэн үе;

3. Нийгмийн гол харилцааг зохицуулах болсноор эрх зүйн хэмжээ давамгайлах шинж төлөвийг олж өдгөө хүртэл үйлчилж байгаа үе хэмээн түүхэн талаас нь авч үзсэн байдаг.

Академич С.Нарангэрэл “Заншлыг эрх зүйн эх сурвалжийн нэг төрөлд судлаачид олон зуун жилийн турш тооцож ирснийг үгүйсгэх аргагүй. Энэ чиглэлээр хоёр үндсэн үзэл баримтлал бий. Нэг талаар заншил нь эрх зүйн эх сурвалжийн дотор дорвитой байрыг эзлэх бөгөөд чухамхүү заншлын хэм хэмжээ нь эрх зүйн үндэс болдог бөгөөд эрх зүйг хэрэглэх, хууль тогтоогч, шүүгч, эрх зүйн номлолын хөгжлийг тодорхойлдог” гэжээ.¹³

Түүнчлэн доктор О.Амархүү “Зан заншлын хэм хэмжээ нь хүмүүсийн амьдралд олон зуун жилээр хэвшиж тогтсон, дахин давтан хэрэглэгддэг зан үйл юм. Түүнийг хуульчилсан тохиолдолд эрх зүйн хэм хэмжээ болдог”¹⁴ гэж, доктор Ч.Нямсүрэн “Зан заншил гэж хүмүүсийн амьдралын урт удаан хугацааны туршид олон дахин давтагдан хэвшил болон тогтсон зан үйлийн горим, журмууд юм. Зан заншлын хэм хэмжээ нь төрөөс зөвшөөрөгдөж, хуульчлагдсан тохиолдолд эрх зүйн хэм хэмжээ болно. Энэ агуулгаар зан заншил нь эрх зүйн эх сурвалж болно”¹⁵ гэж, доктор Б.Гүнбилэг “Заншил эрх зүйн эх сурвалж болохын тулд төрийн болоод албадлагын механизмаар хангагдсан байх ёстой. Шүүх заншлыг эх сурвалж болгон хэрэглэж шийдвэр гарахад энэ төрийн албадлагаар хангагдаж байна гэсэн үг”¹⁶ гэж, судлаач М.Ариунаа “Заншил бол урт хугацааны туршид байнга хэрэглэгдсээр дадал заншил болсон зан үйлийн түүхэн журмууд юм. Төрөөс хамгаалагдан хүлээн зөвшөөрөгдсөн заншлыг эрх зүйн заншил гэнэ”¹⁷ гэж тус тус тайлбарлаж байна.

Хувийн эрх зүйн салбарын зарим бүтээлд заншлын талаар тухайлан дурдсаныг авч үзвэл, доктор Т.Мэндсайхан “Иргэний эрх зүйн харилцаанд нийтээр хүлээн зөвшөөрсөн зан заншил, ёс суртахууны хэм хэмжээ болон сайн санааны зарчмыг харгалзан үзэж болохыг онолын үүднээс хүлээн зөвшөөрдөг”¹⁸ хэмээн

¹³ С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ. 2001., 120-121 дэх тал.

¹⁴ О.Амархүү. Эрх зүйн онол. УБ. 2018., 161-162 дахь тал.

¹⁵ Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. УБ. 2010., 160-161 дэх тал.

¹⁶ Б.Гүнбилэг. Заншлын эрх зүй ба жишгийн эрх зүйн харилцан хамаарал ба ялгаа. Монгол ба буриадын зан заншил, заншлын эрх зүй. УБ. 2008., 60-67 дахь тал.

¹⁷ М.Ариунаа. Төр, эрх зүйн онол. УБ. 2005., 111 дахь тал.

¹⁸ Т.Мэндсайхан. Олон Улсын хувийн эрх зүйн үндэс. УБ. 2002., 66 дахь тал.

үзжээ. Судлаач Б.Оюунчимэг “Хаана ч эх сурвалж болж бичигдээгүй боловч олон жил системтэй хэрэглэж ирсэн хэв журмыг зан заншил гэнэ”¹⁹ гэж үзсэн байна.

Заншил эрх зүйн эх сурвалж болох эсэх тухайд эрдэмтэн, судлаачид харилцан адилгүй байр суурийг илэрхийлсэн байдаг. Дийлэнх судлаачид төрөөс хүлээн зөвшөөрсөн заншил нь эрх зүйн сурвалж болдог болохыг зөвшөөрсөн бол зарим эрдэмтэд заншлыг эрх зүйн эх сурвалж гэж үзэхийг хүлээн зөвшөөрдөггүй. Тухайлбал, доктор Т.Мөнхжаргал “Хэдийгээр өнөөдөр Монголчуудын амьдрал ахуйд заншлын хэм хэмжээгээр зохицуулагдаж буй харилцаа олон бий ч /жишээ нь, хадаг тавьж сүй тавих гэх мэт/ дотоодын иргэний эрх зүйн харилцааг зохицуулах болон түүнээс үүдэлтэй аливаа маргааныг шүүх, арбитраар шийдвэрлэхэд заншлын хэм хэмжээг удирдлага болгох нь шүүх, арбитрын практикт төдийлөн дэлгэрээгүй. Мөн Шүүх, арбитр хэрэг маргааныг шийдвэрлэхдээ заншлын хэм хэмжээг удирдлага болгодоггүй, иргэний хуулийг баримталдаг тул заншил нь эрх зүйн эх сурвалж болохгүй” гэсэн бол доктор Д.Баярсайхан “Өнөө үед заншил нь эрх зүйн бие даасан эх сурвалж байх шинжээ алдсан боловч түүнийг бүрэн үгүйсгэж огт болохгүй”²⁰ гэж үзсэн байна.

Монголын иргэний эрх зүй, аж ахуйн гэрээ (социалист эдийн засгийн тогтолцооны үед улсын болон хамтрал, нэгдлийн хийдэг эдийн засгийн шинжтэй гэрээг ийнхүү нэрлэдэг байсан)-ний нэр хүнд бүхий судлаач заншлын ач холбогдол нь бодит практикт төдийлөн чухал биш, мөн эрх зүйн эх сурвалж болохгүй хэмээсэн нь анхаарал татаж байна. Харин эрх зүйн онолын гол судлаач заншлыг бие даасан эрх зүйн эх сурвалж болох шинжээ алдаад байгаа тухай, гэхдээ заншлыг бүрэн үгүйсгэж болохгүй гэсэн байр суурийг илэрхийлснийг тодотгон дурдах нь зүйтэй байна.

3.2.2. Гадаадын зарим улсад заншлыг авч үзсэн нь

1. ИБУИНВУ

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын эрх зүйн тогтолцооны нэг гол бүрэлдэхүүн хэсэг болох Английн эрх зүйд заншил байгаа эсэх талаар талууд маргасан тохиолдолд шүүхээс тухайн маргаж байгаа журмыг заншил болохыг хүлээн зөвшөөрч, шийдвэрийнхээ үндэслэл болгосон үед л заншил гэж үздэг байна. Үүнээс үзвэл Английн эрх зүйн тогтолцоонд шүүх хүлээн зөвшөөрөх замаар заншлыг тогтоодог байна. Английн эрх зүй нь заншлыг албан ёсоор заавал дагаж мөрдөх хуулийн хүчинтэй биш боловч эрх зүйг төгөлдөржүүлэхэд тусалдаг тодорхой эх сурвалжийн төрөл болохыг хүлээн зөвшөөрч байна.²¹

Францын эрдэмтэн Рене Давид өөрийн бүтээлдээ “эх газрын ажиглагчийн хувьд заншил гэж ойлгогдох тэр зүйл нь Англичуудын хувьд ердийн практик гэж ойлгогдох болно” гэсэн байдгаараа ямар зүйлийг заншил гэж ойлгох вэ, ямрыг нь үгүй вэ гэдэг хүрээнд ойлголтын ялгаатай болохыг тэмдэглэсэн²² байна.

¹⁹ Б.Оюунчимэг. Олон улсын иргэний эрх зүй. УБ. 2000., 18-19 дэх тал.

²⁰ Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ. 2000., 40-41 дэх тал.

²¹ Б.Амарсанаа. Харьцуулсан эрх зүй судлал. (Хоёр дахь хэвлэл). УБ. 2014., 164 дэх тал.

²² мөн тэнд 79 дэх тал.

2. Бүгд Найрамдах Франц Улс

Заншил нь эрх зүйн үндсэн эх сурвалжид хамаарах бөгөөд ард түмнээс гаралтай, төрөөс хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн хэм хэмжээ юм.

Францын Иргэний хуулийг батлахаас өмнө үйлчилж байсан ихэнх заншлыг Иргэний хуульд тусган хуульчилсан гэж түүнийг санаачлагч, боловсруулагчид үздэг. Хэдийгээр заншлыг хуульчлах замаар цөөлөхийг оролдсон боловч өнөөдөр Францын эрх зүйд заншил нь хууль тайлбарлах, хуулийг тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан ойлгоход ач холбогдолтой гэдгийг хэдийнэ хүлээн зөвшөөрчээ. Тухайлбал, Францын Хяналтын шүүх шүүгч хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ оршин байгаа нь тодорхой заншлыг харгалзан үзэх ёстой гэж шийдвэрлэсэн байдаг.

Францын эрдэмтэн Рене Давид “эрх зүйд захирагдаж буй этгээдийн биеэ авч явах үйл хөдлөлд нөлөөлж, эрх зүй шаардаж байна гэж ойлгогдохоор зан үйлийн үргэлжлэл”²³ нь эрх зүйн эх сурвалж болох заншил юм гэж үзсэн.

Францын эрх зүйд заншлын гурван төрөл байдаг гэж үздэг. *Нэгдүгээрт*, эрх зүйг дэмжигч буюу хууль тогтоомжоор тогтоосон хэм хэмжээг дэмжих буюу хэрэглэх явдлыг хангадаг заншил (*consuetudo secundum legem*). Францын эрх зүйд хуулийг тайлбарлахад дөхөм үзүүлдэг учир энэ төрлийн заншилд ихээхэн ач холбогдол өгдөг байна. *Хоёрдугаарт*, хуулиас хамааралгүй, хууль тогтоомжтой зөрчилддөггүй заншил (*consuetudo preter legem*). Энэ нь хуулиар зохицуулаагүй харилцааг харьцангуй бие даасан байдлаар зохицуулсан байдаг. Ийм төрлийн заншил нь онолын хувьд эрүүгийн эрх зүйгээс бусад салбар эрх зүйд хамаарна. *Гуравдугаарт*, эрх зүйтэй зөрчилддөг заншил (*consuetudo adversus legem*) буюу *contra legem*). Энэ нь ихэнхдээ зөрчилдөж байгаа хуулийн заалтыг уян хатан байдлаар тайлбарлах, заншлыг хэрэглэхгүй байх арга замыг сонгоход хүргэдэг²⁴ байна.

3. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Заншлыг хуулиас гадна хүлээн зөвшөөрөгдсөн цорын ганц албан ёсны эрх зүйн эх сурвалж гэж үздэг. Заншил нь удаан хугацааны туршид тогтсон, эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн шинжтэй байдаг бөгөөд зарим заншил нь орон нутгийн байх боломжтой байдаг. ХБНГУ-ын шүүх нь эрх зүйн заншлыг заавал дагаж мөрдөх ёстой.

Заншил нь эрх зүйн аль ч салбарт үйлчилж болох бөгөөд энэ нь хууль (*Gesetz*)-ийн нэг хэсэг байх боломжгүй, түүнээс үүдэн гардаггүй, шүүх буюу эрх зүйн аливаа мэргэжилтнүүдийн үйл ажиллагааны үр дүн биш байдаг.

Германы эрх зүйд заншил болон шүүхийн практикийг²⁵ ялгаатай авч үздэг бөгөөд заншлыг хүлээн зөвшөөрөх эсэх асуудал нь шүүхтэй салшгүй холбоотой юм.

Үүнээс гадна өнөө үед Германы эрх зүйд заншлын гүйцэтгэж буй үүргийг нилээд сонирхолтойгоор тайлбарласан үзэл баримтлал байдаг. Тухайлбал,

²³ Rene David, French Law: Its Structure, Sources and Methodology, 1972, p. 170

²⁴ Б.Амарсанаа. Харьцуулсан эрх зүй судлал. (Хоёр дахь хэвлэл). УБ. 2014., 115 дахь тал.

²⁵ Англ. Customary court practice

заншил нь хуульд байгаа тодорхой бус байдлыг эсхүл хуулиар зохицуулагдаагүй орон зайг нөхөх эрх зүйн ерөнхий зарчмын үүргийг гүйцэтгэж байгаа болно гэж үздэг.²⁶

4. Оросын Холбооны Улс

ОХУ-д гэрээний эрх зүйн үүргийн харилцааны хүрээнд хэвшсэн заншлыг эрх зүйн эх сурвалж гэж үздэг. ОХУ-ын Иргэний хуулийн 309 дүгээр зүйлд зааснаар гэрээний болон бусад үүргийг гүйцэтгэхдээ талууд хууль зүйн тусгай шаардлага эсхүл үүргийн нөхцөл байхгүй тохиолдолд ердийн тавигдаж буй шаардлагыг удирдлага болгох ёстой.

Энэхүү “ердийн шаардлага” гэдэг нь худалдаа (арилжаа)-ны заншил бөгөөд хууль, хэм хэмжээний акт, талуудын гэрээнд тусгагдаагүй боловч тэдгээрт үл харшлах олон удаа хэрэглэсээр ирсэн учраас эл харилцаанд бүрэлдсэн зан дадлын бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх юм. Хууль тогтоомж, талуудын хооронд байгуулагдсан гэрээнд шууд заасан зүйл байхгүй тохиолдолд зан заншил үйлчилдэг бөгөөд заншил нь баттай хэвшиж тогтсон байхаас гадна агуулга нь тодорхой байх ёстой, нөхөх хэм хэмжээ гэж үздэг.²⁷

Заншил, ердийн заншлыг ялгаатай гэж үздэг бөгөөд бодитоор бүрэлдэн тогтсон, хууль тогтоомжид тусгагдаагүй хуулиар буюу талуудын хэлэлцээрээр өөрөөр тогтоогоогүй бол хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий дүрмийг эрх зүйн заншил гэжээ. Харин ердийн заншил нь хуулиар зөвшөөрөгдсөн байхыг шаардахгүй гэрээний талууд удирдлага болгохыг шууд зөвшөөрдгөөрөө заншлаас ялгаатай байна.²⁸

Шүүхээс гэрээний нөхцлийг тайлбарлахдаа талуудын хоорондын харилцаанд тогтсон практикийг заншлаас илүүд үздэг байна. Харин тогтсон практик нь хууль тогтоомжийн зохицуулалт болон гэрээний нөхцөлд харшилж байвал хэрэглэдэггүй байна.

5. Япон улс

Заншил нь нийтийн дэг журам, ёс суртахуунд харшлахгүй байх ёстой бөгөөд хуулиар зөвшөөрсөн эсхүл тухайн харилцааг зохицуулсан хууль байхгүй бол дагаж мөрддөг.²⁹

3.2.3. Арилжааны заншил, тогтсон практикийг ялгах асуудал

Энэхүү судалгааны хүрээнд арилжаа (худалдаа)-ны арга ба тогтсон практик, тогтсон практик ба заншил, заншил ба шүүхийн прецедентийг ялгах шаардлага зайлшгүй гарч ирдэг.³⁰

²⁶ Б.Амарсанаа.Харьцуулсан эрх зүй судлал. (Хоёр дахь хэвлэл). УБ. 2014., 141-142 дахь тал

²⁷ См: Венская Конвенция о договорах международной купли-продажи товаров. Комментарий М., 1994.С.34

²⁸ Мөн тэнд

²⁹ Б.Амарсанаа.Харьцуулсан эрх зүй судлал. (Хоёр дахь хэвлэл). УБ. 2014., 222 дахь тал

1. Хувийн эрх зүйн субъектүүд тодорхой эрх зүйн харилцаанд удаа дараа оролцож, тэдгээрийн хооронд дадал болсон зүйлийг тогтсон практик гэж үзэж болох юм. Арилжааны эрхлэгчийн зах зээлд өөрийн бараа, үйлчилгээ, ажлын гүйцэтгэлээ санал болгох арилжааны арга (үйл ажиллагааны тасалдлын даатгал г.м. тухайн арилжаа эрхлэгчийн хувьд шинэ бүтээгдэхүүн санал болгох) нь тухайн талуудын хувьд эсхүл тухайн үйл ажиллагааны салбар (барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа буюу ломбард г.м.)-ын практик болдог зүй тогтол байхыг үгүйсгэхгүй. Өөрөөр хэлбэл, арилжаа эрхлэгч нь тодорхой шинэ бараа, үйлчилгээ, ажлыг санал болгохдоо бусдаас ялгарах, онцлог шинжийг тодорхойлдог ба эдгээр шинжийг дангаар эсхүл хамтдаа илэрхийлэгч гол элементүүд (нэг өдөр буюу маш богино хугацааны гэх шинжтэй өдрийн зээл г.м.) нь яваандаа тодорхой этгээдүүдийн дунд тогтсон практик болох боломжтой. Арилжааны арга нь нэг талын санал болгосон шинжтэй байдаг учир үүнийг өрсөлдөөний эрх зүй зэрэг салбар эрх зүйгээр зохицуулдаг бол ажил хэргийн хүрээнд тогтсон практик нь эрх зүйн харилцаанд оролцож буй аль аль талын хувьд сайн дураар дагаж мөрдөх, зөвхөн тэдгээрийн зан үйлийг журамлах шинжийг өөртөө агуулж байдаг

2. Заншил³¹ болон тогтсон практик³² хамаарал нь дараагийн анхаарах асуудал юм. Заншлын эрх зүйн хэм хэмжээний хувьд талууд мөрддөг тодорхой зан үйлийн журам тэдгээрээс үл хамааран оршдог байх (*material fact* (анг.) буюу *consuetudo* (лат.)),³³ тэрхүү зан үйлийг эрх зүйн хүчин чадалтай хэмээн ойлгодог байх (*opinio juris* буюу *opinio juris sive necessitatis* (лат.)) гэсэн 2 үндсэн элементтэй. Харин тогтсон практик нь тодорхой субъектүүдийн хооронд үүсдэг буюу тэдгээр нь өөрсдийн харилцаанд зориулан бий болгодог, тодорхой харилцаанд хамаарах дэг, журамласан зан үйлийг ойлгодог.

Дээрхийг задлан авч үзвэл, заншил нь нийтээр (энэ нь харьцангуй ойлголт болохыг тэмдэглэх нь зүйтэй) хүлээн зөвшөөрдөг, талуудаас хамаарал багатай, үл хамаарах объектив шинжтэй байдаг бол практик нь тодорхой субъектүүд өөрсдөдөө зориулан бий болгодог, заншилтай харьцуулахад илүү хязгаарлагдмал хүрээний, субъектив шинжтэй, мөн заншлыг талууд эрх зүй хэмээн ойлгож хүлээж авдаг бол практик нь тийм шинжийг өөртөө агуулдаггүй, талууд тийнхүү ойлгодоггүй боловч хоорондын тохиролцоо гэж ойлгодог зан үйлийн журам байдаг.

³⁰ Үүнээс гадна заншил, практикийн цаг хугацааны элемент (урт удаан хугацааны туршид тогтон бий болсон)-ийг эс тооцвол *soft law* эдгээртэй ойролцоо шинжүүдтэй мэт байна. Мөн улс хоорондын зарим “Ерөнхий нөхцөл”, FIDIC зэрэг гэрээний загварууд нь хэрхэх, стандарт нөхцөл нь заншил, практик мөн эсэхийг эцэслэн дүгнэх хэрэгтэй. Гэхдээ эдгээр нөхцөл нь зөвхөн талууд гэрээний нөхцөл болгон сонгосон үед л хүчин төгөлдөр болдог, тэдгээрийн сонголт хийх эрх чөлөөтэй холбоотой. Талууд сонгосон үед эдгээр нь тогтсон практик, заншлын илрэн гарах хэлбэр болно гэж үзэж болох болов уу. Гэхдээ заншлын эрх зүйн хэм хэмжээ байхын тулд *opinio juris* гэсэн элемент байх ёстойг санах нь зүйтэй.

³¹ Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийн заалтыг үндэслэвэл заншлыг “usages of which the parties knew or ought to have known and which are widely known to, and regularly observed by” гэж илэрхийлсэн байдаг

³² Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийн заалтыг үндэслэвэл практикийг “practice established between themselves” гэж илэрхийлсэн байдаг.

³³ *Consuetudo* нь хугацаа, давталт, түгээмэл байдал зэрэг шинжээр илэрхийлэгддэг.

Гадаадын зарим улсын заншлыг ойлгох байдлын тухай бидний олж мэдсэн шинж болон Монголын судлаачдын заншлын тухай авч үзсэн ч заншил, практикийн ялгагдахад хүндрэлтэй байдаг зарим тохиолдол, хандлага бий. Үүнд практик нь заншлын нэг хэсэг бөгөөд гагцхүү түгээмэл байдал (хамрах субъектын цар хүрээ)-ын хувьд ялгаатай гэж үзэх хандлага, эсхүл дээр дурдсан ялгаатай шинжүүдээс хамааран заншил, практикийн аль нь болохыг тодорхойлох боломжгүй байх зэрэг хамаарна.

3. Заншил, тогтсон практик нь эрх зүйн эх сурвалж болох эсэх, аль нь ямар тохиолдолд эрх зүйн эх сурвалж болох нь энэ судалгааны хүрээнд ач холбогдолтой. Тухайлбал, шүүх, арбитр нь тогтсон практик, эсхүл заншлыг харгалзан үзвэл эсхүл шийдвэрийн үндэслэлээ болговол, заншил, тогтсон практикаар зохицуулбал, эсхүл тэдгээрийг баримталбал эрх зүйн эх сурвалж гэж тооцож байна гэж ойлгогдох уу гэдэг асуудал юуны түрүүнд судалгааны хүрээнд тавигдах ёстой.

Ерөнхий хандлагыг авч үзвэл заншил нь эрх зүйн эх сурвалжид тооцогдох ба ингэснээр тэрхүү заншил нь заншлын эрх зүйн хэм хэмжээ болдог бол харин тогтсон практик нь эрх зүйн эх сурвалжид тооцогдохгүй, талуудын хоорондын тохиролцоо байх (хэлцлийн тодорхой талуудын хувьд), эсхүл заншлын эрх зүйн хэм хэмжээний төвшинд хүлээн зөвшөөрөх боломжгүй талууд тохиролцоо байдлаар ойлгох боломжтой.

Хувийн эрх зүйн харилцаанд оролцож буй талуудын зан үйлийг заншил зохицуулж, тэдгээр нь харилцаандаа заншлыг баримталж байвал *opinio juris* байна гэж үзэхэд хүргэж, улмаар тухайн заншил нь эрх зүйн эх сурвалж болно. Харин тогтсон практик нь эрх зүйн эх сурвалж бус, талуудын хувьд дахин давтан хэрэглэгддэг тохиролцоо хэмээн тооцогдоно. Харин талууд маргасан тохиолдолд шүүх, арбитр нь зарим үйл баримтыг үнэлэх, эрх зүйн дүгнэлт өгөхдөө харгалзан үзэх, шүүх, арбитр шийдвэрийн үндэслэлдээ харгалзах хүчин зүйл байна. Өөрөөр хэлбэл, тогтсон практикийн хувьд *opinio juris* байхгүй байдаг.

Эндээс *opinio juris* нь эрх зүйн эх сурвалж болох хангалттай үндэслэл мөн үү гэсэн дараагийн асуулт гарч болох юм. Хэрэв тийм гэж үзвэл хуульд *opinio juris* байх мэт ойлгогдож магадгүй. Гэхдээ *opinio juris* нь зөвхөн заншилтай холбогдон гарч ирдэг ойлголт бөгөөд хууль зэрэг эрх зүйн эх сурвалж нь угаас дагаж мөрдөгдөх ёстой, эрх зүй гэж тооцогддог учиртай.

4. Заншлын эрх зүйн хэм хэмжээ болон тогтсон практикийн хувьд нь эрх зүйн эх сурвалжийн олон төрлийн дотор эрэмбийн хувьд ямар байх асуудал хөндөгдөх юм. Энэ нь өмнө дурдсан эрх зүйн эх сурвалж болох эсэх асуудалтай холбоотой тавигддаг. Тухайлбал, заншлын эрх зүйн хэм хэмжээ нь эрх зүйн эх сурвалж болдог тул эрх зүйн эх сурвалжийн эрэмбийн асуудал яригдах бол тогтсон практик нь эрх зүйн эх сурвалж болохгүй тул энэхүү эрэмбийн асуудал яригддаггүй.

Энэ логикт үндэслэвэл, заншлын эрх зүйн хэм хэмжээ нь бичигдмэл хуультай эрэмбийн хувьд хэрхэн ангилагдах асуудал юуны түрүүнд гарч ирдэг. Иргэний болон арилжааны эрх зүй бие даан хөгждөг улсуудын хувьд арилжааны заншлыг зарим тохиолдолд хуулиас дээгүүр эрэмбэлэх байр суурь ажиглагддаг

гэж бичсэн байдаг.³⁴ Энэ нь арилжааны заншил нь Иргэний хуулиас дээгүүр эрэмбэлэгдэнэ гэсэн санаа юм. Харин иргэн болон арилжааны эрх зүйн нэгдмэл байдлаар хөгжсөн ОХУ зэрэг зарим улсуудад арилжааны заншил нь эрх зүйн нэмэлт эх сурвалж гэж тооцогддог байна.

5. Арилжаа эрхлэгчдийн дунд тогтсон аливаа заншил, тогтсон практик нь хууль, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш байх боломжтой байдаг нь бусад салбар эрх зүйн заншил (жишээлбэл, хүчээр бэр богтлон авч явах заншил)-тай адил гэж үзэж болно. Зарим тохиолдолд тэдгээр арилжааны заншил, тогтсон практикийг зөвтгөх боломжгүй (хуулиар хориглосон эсхүл тухайн харилцаанд оролцогчдод хэт хохиролтой, шударга бус, ёс суртахуунд үл нийцэх) байдаг тул шүүх, арбитраас тухайн заншил нь хүлээн зөвшөөрөхүйц эсэхийг үнэлсний үндсэн дээр маргааныг шийдвэрлэхдээ заншлын эрх зүйн хэм хэмжээ мөн эсэхийг тогтоодог.

3.3. Дүн шинжилгээ

Заншлыг тодорхойлсон Монголын зарим эрдэмтэн, судлаачдын байр суурийг нэгтгэн дүгнэвэл заншил нь урт хугацааны туршид байнга хэрэглэгдсээр дадал хэвшил болсон байх гэсэн гол шинжийг агуулдаг гэж үзэж болно.

Харин заншил эрх зүйн эх сурвалж болох эсэх тухайд:

- а. Заншил нь эрх зүйн эх сурвалжийн нэг төрөл мөн;
- б. Заншил нь төрөөс зөвшөөрөгдөж, хуульчлагдсан тохиолдолд эрх зүйн эх сурвалж болно;
- в. Заншил нь эрх зүйн эх сурвалж болохгүй гэсэн харилцан адилгүй байр суурийг илэрхийлсэн байна.

Энэ судалгааны хүрээнд заншил, заншлын эрх зүйн хэмжээний талаар дараах оюун дүгнэлт хийж болохоор байна. Нэгдүгээрт, цаг хугацааны хувьд Монголын аль ч эрдэмтэн, судлаач ямар хугацааг заншил бий болоход хангалттай хугацаа болох талаар нарийвчлан авч үзээгүй, тодорхойлох боломжгүй гэж үзэж байгаа нь харагдаж байна. Харин тэдгээрийн хувьд хэдэн зуун жилээс авахуулаад хангалттай хугацаа шаардагддаг тухайд санал нэг байна.

Хоёрдугаарт, заншил бий болж улмаар түүнийг төр хүлээн зөвшөөрөх, хамгаалах, албадлагаар хангах, эсхүл эдгээрийн нэг (товчхондоо эрх зүй хэмээн хувийн эрх зүйн харилцаанд оролцогчид үзэх буюу *opinio juris*) нь байхад заншил, заншлын эрх зүйн хэм хэмжээ болох талаар санал нэг, эсхүл ойролцоо байр суурьтай байна гэж үзлээ.

Гуравдугаарт, заншил нь эрх зүйн бие даасан эх сурвалж болох эсэх тухайд харилцан ялгаатай байр суурь байна. Тодруулбал, нэгдүгээрт дурдсан гипотезийн эсрэг байр суурь буюу үндсэндээ эрх зүйн заншил байхгүй болсон зэрэг шалтгаанаар заншил нь эрх зүйн эх сурвалж байхаа больсон, эсхүл больж байгаа гэсэн байр суурь байна.

³⁴ Ч.Нямсүрэн Эрх зүйн ерөнхий онол (2010), т.183

Үүнийг сүүлийн 30 жилийн хугацаанд Монгол Улсад хувийн өмчийг хүлээн зөвшөөрч, улмаар арилжааны үйл ажиллагаа идэвхтэй явагдсан гэж үзвэл энэ хугацаа хангалттай эсэх асуудал гарч ирнэ. Энэ хугацаанд арилжааны тогтсон практик бий болж, улмаар энэ практик нь арилжааны заншил болж, заншлыг төр хүлээн зөвшөөрөх, албадлагаар хангах, хамгаалах (*opinio juris* бий болох) хангалттай хугацаа мөн эсэх талаар бодолцох шаардлага үүснэ.

Мөн 1990 оноос өмнө Бүгд Найрамдах Монгол Ард Улсад төр, түүний байгууллага, хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй, хоршоолол аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байсан гэвэл энэ хүрээнд арилжааны шинжтэй заншил үүссэн эсэх асуудал 30 жилээс ч илүү хугацаагаар хөндөгдөх юм. Энэ судалгаа нь дээр дурдсан хугацаанд Монголд арилжааны заншил, тогтсон практик үүсэн бий болсон байх магадлалтай, тэрхүү арилжааны заншил, практикийг шүүх, арбитр маргаан шийдвэрлэхдээ эх сурвалж болгон ашигласан, харгалзсан байх магадлалтай юм.

Бусад улсуудын тухайд эрх зүйн тогтолцооны онцлогоос хамааран бичигдмэл хуулийг эрх зүйн эх сурвалж гэж үзэх хандлага зонхилж байгаа хэдий ч заншил нь тухайн улсын эрх зүйн эх сурвалжийн тогтолцоонд тодорхой байр суурь эзлэн оршсоор байна. Иймээс заншлыг шууд үгүйсгэх хандлага байхгүй, судлан авч үзсэн улс бүр заншлыг эрх зүйн хувьд эрс үгүйсгэсэн зүйл харагдахгүй байна. Тухайлбал, Английн эрх зүйн тогтолцоонд шүүхээс хүлээн зөвшөөрөх замаар заншил байгаа болохыг нь тогтоодог бол Францын эрх зүйн тогтолцоонд заншлыг тодорхой шалгуур хангасан тохиолдолд эрх зүйн эх сурвалж болохыг хүлээн зөвшөөрч, улмаар заншлыг хууль тайлбарлах, хуулийг тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан ойлгоход ач холбогдолтой гэж үздэг байна. ХБНГУ-ын хувьд заншил нь хуулиас гадна хүлээн зөвшөөрөгдсөн цорын ганц албан ёсны эрх зүйн эх сурвалж бөгөөд хуульд байгаа тодорхой бус хэм хэмжээ эсхүл зохицуулагдаагүй харилцааг нөхөн зохицуулахад зарчмын үүрэг гүйцэтгэдэг гэж үздэг байна. ОХУ-ын хувьд заншил нь зарим салбар эрх зүйн хувьд эх сурвалж болдог бол Япон улсад тухайн харилцааг зохицуулсан хууль байхгүй бол заншлыг дагаж мөрддөг байна. Эндээс заншилд тухайн эрх зүйн тогтолцооны өгч байгаа ач холбогдол (эрх сурвалжийн эрэмбэд эзлэх байр суурь г.м.) улс бүрд ялгаатай байхыг үгүйсгэхгүй юм. Ялангуяа арилжааны үйл ажиллагаанд холбогдох заншил, тогтсон практик нь эрх зүйн хувьд чухал болох нь харагдаж байна.

Эрх зүйн заншил тухайн улсад бодитой оршин байгаа эсэхээс үл хамааран эрх зүйн заншлын функциональ шинж нь эрх зүйн тогтолцоонд шаардлага (жишээлбэл, шударга ёсыг тогтооход буюу шүүх маргааныг шударгаар шийдвэрлэхэд)-тай байгаагаар холбоотой юм.

Харин арилжаа, худалдаа хийх арга (цаашид “арилжааны арга” гэх), практик нь шударга бус, нийтийн зан суртахуунд харш байх магадлал Монголын арилжааны орчинд байгааг үгүйсгэж болохгүй юм. Үүнийг гадаадын олон улсын арилжааны практик (гэрт нь зочлон худалдан авахыг шахах)-т байдгийг харгалзан, хэрхэн зохицуулсныг авч үзвэл, тухайн улсууд арилжааны арга, практикийг шүүх, арбитр тухайн маргаан гарсны дараа (*ex post*) шийдвэрлэх аргыг баримтлахаас илүүтэй урьдчилан (*ex ante*) бичмэл эрх зүйн эх сурвалж буюу хууль батлах замаар хязгаарлаж байна. Монголын арилжааны орчинд ч энэ арга нь илүү тохиромжтой байхыг үгүйсгэхгүй юм. Мөн холбогдох дотоод, гадаадын ном зүйг

судлан үзэхэд заншил, ялангуяа арилжааны заншил, тогтсон практикийн тухайд нэгдсэн байдлаар, нэг мөр ойлгож, тайлбарлаж байна гэж дүгнэхэд төвөгтэй байгаа юм.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

4.1. Монгол Улсын олон улсын гэрээнд арилжааны заншил, тогтсон практикийн талаар тусгасан нь

Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц (1980)-д Монгол Улс 1997 онд нэгдсэн орсон байна. Монгол улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Монгол улсын Олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэж заасан байдаг.

Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцид заншил болон талуудын хооронд ажлын хэргийн хүрээнд тогтсон практикийг худалдааны харилцаанд хэрэглэх талаар тодорхой зохицуулалт тусгагдсан байна.

Тус конвенцийн 9 дүгээр зүйлийн (1)-т *“Талууд хоорондоо хэлэлцэн тохиролцсон аливаа заншил болон харилцаандаа тогтоосон практикийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө”*. Мөн 9 дүгээр зүйлийн (2)-т *“Өөрөөр тохиролцоогүй бол талууд гэрээнд буюу гэрээ байгуулахад тэдний мэдэж байсан буюу мэдэх ёстой байсан, мөн олон улсын худалдаанд тухайн тодорхой худалдаанд хамаарах тухайн төрлийн гэрээнд оролцогч этгээдүүд өргөнөөр мэддэг бөгөөд тогтмол дагаж мөрддөг заншлыг хэрэглэж байна гэж үзнэ.”* хэмээн заажээ. Энэхүү зохицуулалтаас үзвэл худалдаа (арилжаа)-ны заншил нь гэрээ байгуулахад талууд мэдэж байсан эсхүл мэдэх ёстой байсан, тухайн төрлийн гэрээний харилцаанд оролцогчид өргөнөөр мэддэг бөгөөд тогтмол дагаж мөрддөг байх гэсэн гол шинжийг агуулж байна.

Түүнчлэн Олон улсын арилжаа, төлбөр тооцоо, тээвэрлэлт зэрэг харилцаанд түгээмэл хэрэглэгддэг Инкотермс-2010 (International Commercial Terms), Аккредитив (Uniform Customs and Practice for Documentary Credits №500/600), Инкасс (Uniform Rules for Collection №522) зэрэг баримт бичигт арилжааны заншил, тогтсон практикийн талаар тусгалаа олсон.

4.2. Хуульд арилжааны заншил, тогтсон практикийн талаар тусгасан нь

Арилжааны заншил, тогтсон практик нь Иргэний хуулийн 4 дүгээр зүйлд заасан нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцсэн байх шаардлага тавигддаг. Монгол Улсад 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 728 хуульд заншлын болон практикийн талаарх хуулийн зохицуулалт байгаа эсэхийг Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (<https://www.legalinfo.mn/>)-ээс “заншил”, “практик” гэсэн үгийн үндэстэй нэр томьёо, “зан суртахуун” гэсэн түлхүүр үгсээр хайлт хийсэн болно.

Ийнхүү хайлтын үр дүнгээс үзвэл нийт 31 хууль (Хавсралт 27)-д “заншил” гэсэн нэр томьёо, 14 хуульд “практик” гэсэн нэр томьёог хэрэглэсэн байна. Эдгээр 33 хуулиас 31 хуульд буюу уламжлалт заншил, ёс заншил буюу соёл боловсролтой холбогдох зохицуулалт, 14 хуулиас 12 хуульд хууль тогтоомжийг хэрэглэж байгаа практик, эмнэлгийн практик, шүүхийн практик, практикийн ач холбогдол, практикт хэрэгжих боломж, практикт хэрэглэх, захиргааны ажлын практик гэсэн бизнесийн харилцаа, энэхүү судалгааны асуудалд үл хамаарах заншил, практикийн зохицуулалт агуулагдаж байна.

Харин Иргэний хууль болон Арбитрын тухай хуульд бизнесийн харилцаанд хамаарах арилжааны заншил, мөн Иргэний хууль болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд арилжааны хүрээнд тогтсон практикийн зохицуулалт тусгагдсан байна.

Хүснэгт 3. Арилжааны заншлын хэм хэмжээний талаар дурдсан хууль

№	Хуулийн нэр	Холбогдох заалт
1.	Иргэний хууль /2002/	42 дугаар зүйл. Хэлцлийн хэлбэр 42.3.Ажил хэргийн хүрээнд тогтсон заншлын дагуу техникийн хэрэгслээр шууд хуулбарлан буулгасан гарын үсгийг түүний эхтэй адилтган үзэж болно. 43 дугаар зүйл. Хэлцэл хийсэн гэж үзэх 43.1.Амаар хийх хэлцлийг дараахь тохиолдолд хийсэн гэж үзнэ: 43.1.2.хэлцэл хийснийг нотолсон пайз, тасалбар зэрэг хэрэглэж заншсан зүйлийг олгосон; 196 дугаар зүйл. Гэрээг байгуулсанд тооцох 196.1.Дараахь үндэслэлээр гэрээг байгуулсанд тооцно: 196.1.7.ажил хэргийн хүрээнд тогтсон заншил ёсоор санал гаргагч талыг хүлээн зөвшөөрнө гэж үзээд санал хүлээн авагч тал нь саналд дурдсанаас өөр нөхцөлөөр гэрээ байгуулахаар хариу илгээсэн тохиолдолд санал гаргагч татгалзсан тухайгаа нэн даруй мэдэгдээгүй; 198 дугаар зүйл. Гэрээг тайлбарлах 198.3.Гэрээний зарим үг хэллэгийг нутгийн онцлогоос шалтгаалан өөр өөр агуулгаар тайлбарлаж болохоор байвал гэрээ байгуулсан талуудын оршин суугаа газарт хэрэглэж заншсан агуулгаар, талууд нь өөр өөр газар оршин суудаг бол гэрээ байгуулах саналыг хүлээн зөвшөөрсөн талын оршин суугаа газарт хэрэглэж заншсан агуулгаар тайлбарлана. 198.6.Энэ хуулийн 198.1-198.5-д заасан журмаар

		гэрээний агуулгыг тодорхойлох боломжгүй бол гэрээний зорилгыг харгалзан талуудын нэгдмэл санааг тодруулах бөгөөд үүний тулд гэрээ байгуулахаас өмнө хийсэн хэлэлцээ, харилцан илгээсэн баримт бичиг, талуудын хооронд тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзнэ 449 дүгээр зүйл. Аккредитив 449.3.Аккредитивийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг баримтална. 450 дугаар зүйл. Инкасс 450.2.Инкассийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд хууль, олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг баримтална. 457 дугаар зүйл. Банкны баталгааны гэрээ 457.17.Энэ хуулиар зохицуулаагүй банкны баталгаатай холбогдсон бусад харилцааг олон улсын хэмжээнд хэрэглэдэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлаар зохицуулна. 540 дүгээр зүйл. Гадаад улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх 540.1.Шаардлагатай бол шүүх иргэний хэрэг, маргаан шийдвэрлэх буюу иргэний эрх зүйн бусад харилцааг зохицуулахад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд харшлаагүй гадаад улсын хууль, эрх зүйн болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээг хэрэглэж болно.
2.	Арбитрын тухай хууль /2017/	40 дүгээр зүйл.Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээ 40.5.Арбитрын бүрэлдэхүүн талуудын хооронд байгуулсан гэрээний нөхцөлд үндэслэн тухайн асуудлаар тогтож хэвшсэн худалдааны зан заншлыг харгалзан маргааныг шийдвэрлэнэ.

Хүснэгт 4. Арилжааны хүрээнд тогтсон практикийн талаар дурдсан хууль

№	Хуулийн нэр	Холбогдох заалт
1.	Иргэний хууль /2002/	198 дугаар зүйл. Гэрээг тайлбарлах 198.6.Энэ хуулийн 198.1-198.5-д заасан журмаар гэрээний агуулгыг тодорхойлох боломжгүй бол гэрээний зорилгыг харгалзан талуудын нэгдмэл санааг тодруулах бөгөөд үүний тулд гэрээ байгуулахаас өмнө хийсэн хэлэлцээ, харилцан илгээсэн баримт бичиг, талуудын хооронд тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзнэ.
2.	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль /2008/	15 дугаар зүйл. Уялдуулан хэрэглэх үнийн арга 15.2.Уялдуулан хэрэглэх үнийн аргыг дараахь хоёр арга замаар хэрэгжүүлнэ: 15.2.2.гаалийн үнийг тодорхойлоход олон улсын худалдааны практик болон тухайн үеийн арилжааны бусад мэдээлэлд тулгуурлах худалдааны дараахь мэдээлэл, бичиг баримтыг ашиглах: 15.2.2.1.худалдагчийн үнийн жагсаалт, үнийн лавлагаа болон каталог; 15.2.2.2.статистикийн мэдээ, нийтээр хэрэглэж буй зардлын тариф; 15.2.2.3.экспортлогчийн үнийн санал, бараагаар төрөлжсөн олон улсын биржийн мэдээлэл, төрөлжсөн сонин хэвлэлийн мэдээлэл, зах зээлд зонхилох импортлогчдын гэрээ, түүний үнэ; 15.2.2.4.интернетээр нийтэд зориулан тараасан экспортын үнэ; 15.2.2.5.хил залгаа улс орны Монгол Улсад экспортоор гаргаж байгаа барааны үнийн судалгаа; 15.2.2.6.гаалийн байгууллагад мэдүүлсэн барааны тухайн цаг үед бий болсон үнийн дундаж үзүүлэлт. 20 дугаар зүйл. Зах зээлийн мэдээлэл, судалгааны үнийн арга 20.1.Экспортын барааны гаалийн үнийг тодорхойлох сүүлчийн арга нь зах зээлийн мэдээлэл, судалгааны үнийн арга болно. 20.2.Зах зээлийн мэдээлэл, судалгааны аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлохдоо олон улсын худалдааны практик, тухайн үеийн дэлхийн зах зээлийн үнийн дараахь мэдээлэл, судалгааг үндэслэнэ: 20.2.1.экспортлогчийн нийтэд зориулан тараасан үнийн жагсаалт, лавлагаа, интернетийн мэдээлэл;

		20.2.2.гадаад худалдааны болон гаалийн статистикийн мэдээ зэрэг олон нийтэд зориулсан мэдээ, мэдээлэл; 20.2.3.барааны төрөлжсөн биржийн мэдээлэл, төрөлжсөн сонин хэвлэлийн мэдээлэл, зах зээлд зонхилох экспортлогчдын гэрээ, түүний үнэ.
--	--	---

Харин Иргэний хуулийн 541 дүгээр зүйлийн 541.1 дэх хэсэгт дурдагдсан практик нь гадаад улсад хуулийг хэрэглэдэг практикийг хөндсөн байхг тул судалгааны хүрээнд хөндөгдөж байгаа ажил хэргийн хүрээнд тогтсон практикт үл хамаарах юм.

4.3. Дүн шинжилгээ

1. Энд дурдсан Монгол Улсын хүчин төгөлдөр хуулийн зохицуулалтыг ангилан авч үзвэл дараах дүр зураг харагдаж байна. Сийрүүлбэл,

Нэг дэх бүлэг эрх зүйн хэм хэмжээ (Иргэний хуулийн 42 дугаар зүйлийн 42.3, 43 дугаар зүйлийн 43.1.2, 196 дугаар зүйлийн 196.1.7) нь тогтсон заншил гэрээ байгуулсанд, хэлцэл хийсэнд тооцох үндэслэл болох, гэрээ, хэлцэл хийхэд зурах гарын үсэг, түүнтэй адилтгах зүйлийг зөвшөөрсөн,

Хоёр дахь бүлэг эрх зүйн хэм хэмжээ (Иргэний хуулийн 198 дугаар зүйлийн 198.3, 198.6) нь гэрээний үг хэллэг, талуудын хүсэл зориг тайлбарлахад заншлыг харгалзах,

Гурав дахь бүлэг эрх зүйн хэм хэмжээ (Иргэний хуулийн 449 дүгээр зүйлийн 449.3, 450 дугаар зүйлийн 450.2, 457 дугаар зүйлийн 457.17, 540 дүгээр зүйлийн 540.1) нь аккредитив, инкасс, банкны баталгааны харилцаанд заншлыг баримтална, заншлаар зохицуулах, олон улсын хувийн эрх зүйн харилцааг зохицуулахад олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээг хэрэглэх,

Дөрөв дэх бүлэг эрх зүйн хэм хэмжээ (Арбитрын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 40 дүгээр зүйлийн 40.5) нь арбитрын маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээний хүрээнд тухайн асуудлаар тогтож хэвшсэн худалдааны зан заншлыг харгалзахыг зөвшөөрсөн байна.

2. Монгол Улсын олон улсын гэрээ, хуулийн хувьд арилжааны заншил, тогтсон практикийн эрх зүйн ач холбогдол ямар байхыг тодруулсан шинжтэй заалт тусгагдсан байна. Тухайлбал, зарим заалт нь талууд дагаж мөрдөх эрх зүйн эх сурвалж байхаар, зарим заалт нь харгалзан үзэх эх сурвалж байхаар, зарим заалт нь заншлыг хэрэглэхийг зөвшөөрсөн агуулгатай байна. Өөрөөр хэлбэл, бичигдмэл эрх зүйн эх сурвалж болох олон улсын гэрээ, хууль нь заншлын эрх зүйн хэм хэмжээний эрх зүйн үр дагаврыг тодруулах байдлаар эрх зүйн тодорхой байдал (legal certainty (анг.))-ыг бий болгох хандлагыг барьжээ.

3. Иргэний хуулийн зохицуулалтад анхаарлаа хандуулбал, “практик”-ийг томьёолохдоо талуудын хооронд тогтсон байхаар, “заншил”-ыг ажил хэргийн хүрээнд тогтсон байхаар хүрээний хувьд ялгаатай хуульчилсан гэж үзэхээр байна.

4. Арилжааны заншил болон тогтсон практиктай холбоотой хуульд туссан хэм хэмжээг шинжлэн үзвэл, заншил гэсэн үгийн үндэстэй илэрхийлэл (заншсан

г.м.) нь заавал заншлын хэм хэмжээг илэрхийлсэн байх албагүй байна. Мөн хуулиуд дахь зарим томъёолол нь заншил, тогтсон практикийг ялгаагүй байх магадлалтай байна. Тухайлбал, Иргэний хуулийн 43 дугаар зүйлийн амаар хэлцэл хийсэн гэж үзэх хэлцэл хийснийг нотолсон пайз, тасалбар зэрэг хэрэглэж заншсан зүйлийг олгосон бол гэсэн агуулга нь гагцхүү заншил тогтсон байхыг илэрхийлэхгүй бөгөөд харин хэвшил болсон байдал буюу тогтсон практик байхыг ч үгүйсгэхгүйг энэ зүйлийн агуулга, зорилгын үүднээс дүгнэж болох юм. Харин Иргэний хуулийн 196 дугаар зүйлийн 196.1.7 дахь заалтын гэрээг байгуулсанд тооцох үндэслэлийн хувьд ажил хэргийн хүрээнд тогтсон заншил байхыг шаардсан нь тогтсон практикаас илүү өндөр шалгуур хууль тогтоогчтавьсан гэж үзэхээр байна.

Иргэний хуулийн 198 дугаар зүйлийн гэрээг тайлбарлахтай холбоотой 198.3 дахь заалт, 198.6 дахь заалтын хувьд хамтад нь авч үзвэл заншил гэсэн үгийн үндэстэй томъёолол аль алинд нь хэрэглэсэн боловч өөр өөр агуулгыг илэрхийлж байгаа мэт байна. Тодруулбал, мөн зүйлийн 198.3 дахь хэсэгт заасан хэрэглэж заншсан агуулгаар гэрээг тайлбарлах (гэрээний зарим үг хэллэгийг нутгийн онцлогоос шалтгаалан өөр өөр агуулгаар тайлбарлаж байвал) тухайд зохицуулсан бол мөн зүйлийн 198.6 дахь хэсэг нь “хэрэглэж заншсан агуулгаар” гэрээний агуулгыг тодорхойлох боломжгүй тохиолдлыг зохицуулсан байдаг.

Ийнхүү гэрээний агуулгыг заншсан агуулгаар тодорхойлох боломжгүй бол ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг харгалзан үзэхээр заасан байдаг. Эдгээр заалтад дурдагдсан заншил гэсэн үгийн үндсийг агуулсан хуулийн зохицуулалтын зорилго, логикийг анхаарвал хоорондоо ялгаатай зүйлийг илэрхийлсэн мэтээр ойлгогдож болохоор байна. Ингэж үзвэл Иргэний хуулийн 198 дугаар зүйлийн 198.3 дахь хэсэгт дурдагдаж байгаа хэрэглэж заншсан агуулга гэдэг нь заншил бус тогтсон практик байх боломжтой мэт, мөн зүйлийн 198.6 дахь заалт нь заншлын асуудлыг хөндөж байна гэж тайлбарлах орон зай байгааг анхаарч үзэхээр байна.

Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5 дахь заалтын маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээний талаарх зохицуулалтад арбитр нь маргаж байгаа асуудлаар тогтож хэвшсэн худалдааны зан заншлыг харгалзан маргааныг шийдвэрлэхээр зааж өгсөн байдаг. Гадаадын олон улс дахь арилжааны арбитрын хэрэг, маргаан шийдвэрлэдэг практик, арбитрын зорилго зэргийг харгалзан үзвэл дээрх хуулийн заалт нь зөвхөн арилжааны заншил төдийгүй тогтож хэвшсэн практикийг ч илэрхийлж байх бололцоотой байна.

5. Мөн худалдааны зан заншил, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил, олон улсын худалдааны практик зэргээр ялгаатай, олон янзын томъёоллоор нэг зүйлийг илэрхийлэн холбогдох хуулиудад хуульчилсан байх магадлал байна.

ТАВ. АРИЛЖААНЫ ЗАНШИЛ, ТОГТСОН ПРАКТИКТ ХОЛБОГДОХ ШҮҮХ, АРБИТРЫН ШИЙДВЭР

5.1. АРИЛЖААНЫ ЗАНШИЛД ХОЛБОГДОХ ШҮҮХ, АРБИТРЫН ШИЙДВЭР

Арилжааны заншил нь арилжааны эрх зүйн заншил болсон эсэхийг тогтоох гол шалгуур нь ямарваа нэг зан үйлийг шүүх, арбитр өөрийн шийдвэртээ (эх сурвалжийн хэмжээнд) харгалзан үзсэн, эсхүл шийдвэрээ гаргахдаа хүрсэн оюун дүгнэлтийн аль нэг хэсэг (жишээлбэл, тодорхой үйл баримтыг үнэлэх)-тээ ийн үндэслэл болгон авч үзсэн эсэх асуудал юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын шүүх, арбитр маргаан шийдвэрлэхдээ арилжааны заншил хэмээн хүлээн зөвшөөрч, түүнийг шийдвэр гаргахдаа эх сурвалж (эсхүл харгалзан үзсэн) гэж үзсэн бол арилжааны заншил Монгол Улсад байна гэж үзэх хангалттай үндэслэл болно.

Шүүхийн шийдвэр

Шүүхийн шийдвэрийн судалгааг Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn)-д байршиж буй (2013.12.18-ны өдрөөс 2020.01.01-ны өдрийг хүртэлх) нийт 164,198 иргэний хэргийн 223,826 шүүхийн шийдвэрийн хүрээнд хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр шүүхийн шийдвэрээс “заншлын хэм хэмжээ”-г хэрэглэсэн шүүхийн шийдвэрүүдийг бүрэн гүйцэд судлах зорилгоор “заншил” гэсэн үгийн үндэстэй түлхүүр үгсээр хайлт хийсэн болно.

Хайлтын үр дүнд илэрсэн нийт 2808 шүүхийн шийдвэрээс 2729 шийдвэр нь гэр бүлийн холбогдолтой маргааныг шийдвэрлэсэн, 62 шийдвэр нь заншлын хэм хэмжээнд хамаарахгүй байх бөгөөд харин 15 шийдвэр нь арилжааны харилцааны заншлын хэм хэмжээтэй холбоотой байна.

Гэр бүлийн холбогдолтой маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулсан ч Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.3-т заасан (*хүүхдээ үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх, түүнд суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадлага олгох*) үүрэг нь эцэг, эхийн үүрэг хэвээр үлдэх болохыг дурдсан байна. Заншил гэсэн үг орсон боловч заншлын хэм хэмжээнд хамаарахгүй шийдвэрүүдийн тухайд хэргийн оролцогчид нэхэмжлэл, тайлбартаа заншил гэсэн үгийг үндэсний түүх, өв соёл, уламжлалт ёс заншил зэрэг утгаар хэрэглэн мэтгэлцсэн байна.

Энэхүү судалгаанд хамаарах “заншил”-ын талаар талууд үндэслэл гаргаж мэтгэлцсэн, түүнчлэн шүүхээс зарим нэг дүгнэлт өгсөн дараах 15 шүүхийн шийдвэрийг авч үзье. Үүнд:

1.Нэхэмжлэгч Б.М нь Д.Д-тэй 2011.11.02-ны өдөр байгуулагдсан бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бусад тооцож, ...орон сууцны өмчлөгчөөр Д.Д-г бүртгэсэн бүртгэлийг хүчингүй болгож, Б.М-ийн өмчлөх эрхийг сэргээлгэх тухай нэхэмжлэл гаргасан байна.³⁵

Хариуцагч нарын шүүхэд гаргасан хариу тайлбарыг дэмжиж тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа “...Барилгын

³⁵ Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 10 сарын 15-ны өдрийн 6367 дугаартай шийдвэр <http://shine.shuukh.mn/irgenanhan/8002/view>

компаниуд бетон зуурмагийн төлбөрт машин, орон сууц өгөх нь элбэг байдаг. Бетон зуурмагийн төлбөрт авсан машин, орон сууцаа цааш нь мөн л түүхий эд /элс, хайрга, цемент/ нийлүүлсэн компаниудад төлбөрт нь шилжүүлэн өгдөг. Иймд компанийн нэр дээр байнга авч дахин шилжүүлэхэд ажиллагаа их ордог, ялангуяа “Т 3” ХХК-ийн захирлаар ажиллаж байгаа Д.Д нь ид ачааллын үед тэр болгон харилцагч нараас төлбөрт шилжүүлж буй бартерийн байрны гэрээг байгуулж, цааш шилжүүлэх ажиллагаанд явах цаг зав муу байдаг учир ихэнх тохиолдолд өөрийн компанийн итгэлтэй ажилтан болох менежер Б.М-ын нэр дээр бартерийн байрны гэрээг хийлгүүлэх албан тоотыг харилцагч компаниуд руу явуулан Б.М-ын нэр дээр гэрээг хийлгэн авч, дараа нь бусдад шилжүүлүүлэх ажлыг хийлгүүлдэг байсан. Энэ ажиллагаа нь бидний хувьд ажил хэргийн хүрээнд байнга хийгддэг **тогтсон заншил** болсон үйл ажиллагаа юм.” гэж тайлбарласан.

Энэхүү маргааныг шүүхээс шийдвэрлэхдээ хариуцагчийн хариу тайлбартаа дурдсан ажил хэргийн хүрээнд байнга хийгддэг тогтсон заншлын талаар дүгнэлт өгөлгүйгээр шийдвэрлэсэн байна .

2.Иргэн Б.Э нь 500 ам доллар буюу 971.195 төгрөгийг гаргуулах тухай нэхэмжлэлийг “Г” ХХК-д холбогдуулан гаргасан байна.³⁶

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт “Иргэний хуулийн 198 дугаар зүйлийн 198.6-д “Энэ хуулийн 198.1-198.5-д заасан журмаар гэрээний агуулгыг тодорхойлох боломжгүй бол гэрээний зорилгыг харгалзан талуудын нэгдсэн санааг тодруулах бөгөөд үүний тулд гэрээ байгуулахаас өмнө хийсэн хэлэлцээ, харилцан илгээсэн баримт бичиг, талуудын хооронд **тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил** зэрэг нөхцөл байдлыг харгалзан үздэг тул нэхэмжлэгч Б.Э Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Далиан хотод тэтгэлгээр суралцах хүсэл зоригоо илэрхийлсэн, хариуцагч “Г” ХХК нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Их, дээд, сургууль, коллежид элсэн суралцахад зуучлах үүрэг хүлээсэн ” байна гэсэн дүгнэлт хийсэн байна.

Харин давж заалдах шатны шүүхээс заншлын хэм хэмжээ болон Иргэний хуулийн 198 дугаар зүйлийн 198.6 дахь заалтыг хэрэглэлгүйгээр маргааныг шийдвэрлэсэн байна.

3.Нэхэмжлэгч Г.Э нь хариуцагч “Г” ХХК-д холбогдуулан гэрээнээс татгалзсанаас үүссэн үр дагаварт 971.195 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэл гаргасан.³⁷

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт “Иргэний хуулийн 198 дугаар зүйлийн 198.6-д “Энэ хуулийн 198.1-198.5-д заасан журмаар гэрээний агуулгыг тодорхойлох боломжгүй бол гэрээний зорилгыг харгалзан талуудын нэгдсэн

³⁶. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 07 сарын 08-ны өдрийн 181/ШШ2016/00328 дугаартай шийдвэр <http://new.shuukh.mn/irgenanhan/30362/view>

³⁷. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 06 сарын 30-ны өдрийн 181/ШШ2016/00233 дугаартай шийдвэр <http://new.shuukh.mn/irgenanhan/31804/view>

санааг тодруулах бөгөөд үүний тулд гэрээ байгуулахаас өмнө хийсэн хэлэлцээ, харилцан илгээсэн баримт бичиг, талуудын хооронд **тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил** зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзнэ” гэж заасан байх ба нэхэмжлэгч Г.Э-ийн зорилго нь БНХАУ-д тэтгэлгээр суралцах, “Г” ХХК нь БНХАУ-ын Их, дээд, сургууль, коллежид элсэн суралцахад зуучлах байсан байна.” гэж дүгнээд нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн байна.

4.Нэхэмжлэгч “А” ХХК нь даатгалын гэрээнээс татгалзсан татгалзлыг баталгаажуулах, даатгалын баталгааг хүчин төгөлдөр бус байх хэлцэлд тооцуулахаар “Ү” ХХК-д холбогдуулан нэхэмжлэл гаргасан.³⁸

Нэхэмжлэгч нь шүүхэд гаргасан нэхэмжлэл болон хяналтын журмаар гаргасан гомдолдоо: “ИХ-ийн 198.6-д Энэ хуулийн “198.1-198.5-д заасан журмаар гэрээний агуулгыг тодорхойлох боломжгүй бол гэрээний зорилгыг харгалзан талуудын нэгдмэл санааг тодруулах бөгөөд үүний тулд гэрээ байгуулахаас өмнө хийсэн хэлэлцээ, харилцан илгээсэн баримт бичиг, талуудын хооронд **тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил** зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзнэ гэж заасан. Гэтэл анхан болох давж заалдах шатны шүүх Иргэний хуулийн энэхүү заалтыг хэрэглээгүй. Тиймээс Иргэний хуулийн энэхүү заалтаар маргааныг шийдвэрлэж өгнө үү” гэсэн байна. Хяналтын шатны шүүх³⁹ гомдлын энэхүү үндэслэлийн талаар дүгнэлт хийгээгүй байна.

5.Нэхэмжлэгч “СБХ” ХХК нь ажил гүйцэтгэх гэрээний үүрэгт 25.795.000 төгрөгийг гаргуулахаар Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газарт холбогдуулан нэхэмжлэл гаргасан байна.⁴⁰

Нэхэмжлэгчийн өмгөөлөгч нь шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа “ИХ-ийн 196 дугаар зүйлийн 1.5 дахь хэсэгт зааснаар тэр даруй гэрээ байгуулсанд тооцдог. Мөн хуулийн 198.6 дугаар зүйлд энэ хуулийн 198.1-198.5-д заасан журмаар гэрээний агуулгыг тодорхойлох боломжгүй бол гэрээний зорилгыг харгалзан талуудын нэгдмэл санааг тодруулах бөгөөд үүний тулд гэрээ байгуулахаас өмнө хийсэн хэлэлцээ, харилцан илгээсэн баримт бичиг, талуудын хооронд **тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил** зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзнэ гэж заасан. Тэгэхээр энэ байгуулагдсан гэрээ нь нөхөн тарилт хийхтэй холбоотой гэрээ гэж үзэх хууль зүйн бүрэн үндэслэлтэй” гэж дурьдсан боловч шүүх энэхүү үндэслэлтэй нь холбоотой дүгнэлт хийгээгүй байна.

6.Нэхэмжлэгч “ХБ” ХХК нь тээвэр зуучийн үйлчилгээний гэрээний үүрэгт 36.287.167 төгрөгийг “Т” ХХК-иас гаргуулахаар нэхэмжлэл гаргасан байна.⁴¹

³⁸. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 07 сарын 24-ний өдрийн 01604 дугаартай шийдвэр <http://new.shuukh.mn/irgenanhan/78817/view>

³⁹. МУ-ын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны 2019 оны 02 сарын 28-ны өдрийн 001/ХТ2019/00284 дүгээр тогтоол <http://new.shuukh.mn/irgenhyanal/5686/view>

⁴⁰. Өмнөговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 08 сарын 06-ны өдрийн 318 дугаар шийдвэр <http://new.shuukh.mn/irgenanhan/78696/view>

⁴¹. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 сарын 27-ны өдрийн 181/ШШ2018/02447 дугаар шийдвэр <http://new.shuukh.mn/irgenanhan/82124/view>

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт “Талуудын хоорондох гэрээнд “Захиалга авах хуудас” гэрээний салшгүй хэсэг байхаар, зууч нь “Захиалга авах хуудас”-ны дагуу ачаа тээвэрлэх үйл ажиллагаа зохион байгуулахаар тус тус заажээ. Нэхэмжлэгч ачаа тээвэрлүүлэх тухай захиалгыг “Захиалга авах хуудас”-ын дагуу өгөөгүй болох нь зохигчдын тайлбараар тогтоогдож байх боловч талууд **ажил хэргийн хүрээнд тогтсон заншил** ёсоор тухайн тохиолдолд нэхэмжлэгч гэрээ байгуулах саналыг цахим шуудангаар гаргасан, хариуцагч саналыг хүлээн авч, зөвшөөрсөн болох нь хэрэгт авагдсан хоёр байгууллагын хариуцсан ажилтнуудын хооронд харилцсан цахим шуудангаар тогтоогдож байна. Иймд Иргэний хуулийн 196 дугаар зүйлийн 196.1.7, 196.2-т зааснаар талуудын хооронд гэрээ байгуулагдсан гэж үзнэ” гэж дүгнээд нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн байна.

7.Нэхэмжлэгч “Б” ХХК нь чингэлэгийг Улаанбаатар хотоос БНХАУ-ын Эрээн хот хүртэл тээвэрлэхийг даалгах, хугацаа хэтрүүлсний төлбөрт 9.752.120 төгрөгийг “А” ХХК-иас гаргуулахаар нэхэмжлэл гаргасан байна.⁴²

Нэхэмжлэгч “Б” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.М нь шүүхэд гаргасан тайлбартаа “А компани тохирсон ёсоор Замын-Үүд боомтоос Улаанбаатар хот хүртэл чингэлэгийг тээвэрлэж захиалагч С.Б чингэлэг доторх бараагаа 2017 оны 12 сарын 11-нд хүлээн авсан. **Тогтсон ажил хэргийн заншил** ёсоор бол хоосон чингэлэгийг манай компани А компаниас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрээн хотод хүлээн авах ёстой юм. Гэтэл С.Б-ын ачааг тээвэрлэсэн чингэлэг хугацаандаа Эрээн хотод ирээгүй. Тиймээс төлбөрийн гаргуулж өгнө үү.” гэжээ. Шүүхээс энэ үндэслэлийг хүлээн авч чингэлэгийг Эрээн хот хүртэл тээвэрлэхийг даалгах нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, хугацаа хэтрүүлсний төлбөр гаргуулах нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

8.Нэхэмжлэгч “М” ХХК нь “ӨБ” ХХК-иас Худалдах-худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлд 10.000.000 төгрөг гаргуулахаар нэхэмжлэл гаргасан байна.⁴³

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт “Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1-д зааснаар гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа 3 жил байдаг боловч мөн хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, 79.7-д тус тус зааснаар үүрэг хүлээсэн этгээд нь урьдчилгаа олгох, хүү төлөх, баталгаа гаргах буюу бусад хэлбэрээр шаардлагыг хүлээн зөвшөөрсөн бол хөөн хэлэлцэх хугацаа тасалдаж, хугацааг шинээр эхлэн тоолдог. Хуульд заасан бусад хэлбэрээр шаардлагыг зөвшөөрөх гэдэгт талуудын хооронд **тогтсон ажил хэргийн заншил**, тухайлбал үүрэн холбоо, цахим шуудан ашиглаж хүсэлт, санал гаргах зэрэг зан үйлийг хамруулж үзнэ. Хариуцагч “ӨБ” ХХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшигч, тус компанийг тухайн үед төлөөлөх эрхтэй байсан этгээд болох Г.Ц нь М ХХК-ийг төлөөлөх эрх бүхий этгээдэд илгээсэн болон

⁴² Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 06 сарын 26-ны өдрийн 102/ШШ2018/02087 дугаар шийдвэр <http://new.shuukh.mn/irgenanhan/78165/view>

⁴³ Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017-10-17-ны өдрийн 184/ШШ2017/02246 дугаар шийдвэр <http://new.shuukh.mn/irgenanhan/72252/view>

түүнээс хүлээн авсан зурвасуудад хадгалагдсан мэдээллээр, талуудын хооронд үүссэн өр төлбөрийг төлж барагдуулахаа хүлээн зөвшөөрч байсан болох нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д заасан журмын дагуу, хариуцагч хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээдийн үүрэн холбооны төхөөрөмжид үзлэг хийж бэхжүүлсэн тэмдэглэлээр тогтоогдож байна.” гэж дүгнээд нэхэмжлэлийн шаардлагын бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн байна.

9.Нэхэмжлэгч П.Б нь “ИӨ” ХХК-д холбогдуулан нөхөн олговор болох 9.000.000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэл гаргасан байна.⁴⁴

Маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт “Талуудын хооронд байгуулсан гэрээний харилцаа нь Иргэний хуулийн 274 дүгээр зүйлийн 274.1-т зааснаар арилжааны гэрээ байгуулсан бөгөөд гэрээний 2.7-д зааснаас үзэхэд Иргэний хуулийн 198 дугаар зүйлийн 198.5-д зааснаар гэрээний агуулгыг тодорхойлох боломжгүй бол гэрээний зорилгыг харгалзан талуудын нэгдмэл санааг тодруулах бөгөөд үүний тулд гэрээ байгуулахаас өмнө хийсэн хэлэлцээ, харилцан илгээсэн баримт бичиг, **талуудын хооронд тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил** зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзсэн болно.” гэж дүгнээд, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн байна.

10.Иргэн Б.А нь СБД ЗДТГ, СБД-ийн ... хороонд холбогдох “СБД-ийн ... хорооны Хэсгийн ахлагчаар ажиллуулахыг даалгаж, 2018 оны 08 сараас 2019 оны 01 сар хүртэлх хугацааны цалин хөлсөөр хохирсон хохиролд 2,160,000 төгрөгийг гаргуулж, 2018 оны 06 сараас хойшхи хугацааны Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг нөхөн төлүүлж, холбогдох бичилтийг хийлгүүлэхээр нэхэмжлэл гаргасан байна.⁴⁵

Нэхэмжлэгч нь шүүхэд гаргасан нэхэмжлэл болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа “2018-08-29-ны өдөр СБД-ийн ЗДТГ-ын даргын Б/252 дугаартай тушаал гарч намайг хүүхэд асрах чөлөөтэй байхад ажлаас чөлөөлсөн. Би уг тушаалыг нь хууль зүйн үндэслэлгүй гэж үзэж байна. Хөлсөөр ажиллах гэрээний хугацаа 2018-06-30-ны өдөр дуусгавар болсон ч **өмнө хэвшсэн заншил** болон тус гэрээний 5.2-т зааснаар 6 сарын хугацаагаар сунгагдсан төдийгүй би энэ хугацаанд хүүхэд асрах чөлөөтэй байсан болно.” гэжээ.

Энэхүү маргааныг шүүхээс шийдвэрлэхдээ нэхэмжлэгчийн нэхэмжлэлдээ дурдсан хэвшсэн заншлын талаар дүгнэлт өгөлгүйгээр шийдвэрлэсэн байна.

11.Иргэн Ц.А нь иргэн Б.А-аас “Зээлийн гэрээний үүрэгт 12,783,665.75 төгрөг гаргуулах тухай” нэхэмжлэл гаргасан байна.⁴⁶

⁴⁴. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018-02-22-ны өдрийн 430 дугаар шийдвэр <http://new.shuukh.mn/irgenanhan/73894/view>

⁴⁵. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 03 сарын 29-ний өдрийн 748 дугаар шийдвэр <http://new.shuukh.mn/irgenanhan/84638/view>

⁴⁶. Өмнөговь аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 09 сарын 13-ны өдрийн 257 дугаар шийдвэр <http://new.shuukh.mn/irgenanhan/86622/view>

Шүүхийн шийдвэрийн үндэслэлд “Зээлдэгч зээлийг эргүүлж төлөх хугацааг хэтрүүлсэн бол 0,5 хувийн алданги төлөхөөр гэрээнд харилцан тохиролцсон байх ба харин хуульд алдангийг хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр тооцохоор хуульчилсан байх тул нэхэмжлэгч нь хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0,5 хувийн алданги тооцож нэхэмжилсэн нь төлбөр тооцооны **тогтсон заншилд** нийцсэн” гэж дүгнээд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн “зөвхөн үндсэн зээлийн 0,5 хувиар тооцож алдангид 32,500 төгрөгийг нэг л удаа төлнө, хоног тутамд алданги тооцохоор тохироогүй” гэх тайлбар үндэслэлгүй байна” гэж дүгнэж, маргааныг шийдвэрлэсэн байна.

12. Урьдчилгаа төлбөрийн болон гүйцэтгэлийн баталгааны гэрээний үүрэгт 2,394,878.435 төгрөг гаргуулах үндсэн нэхэмжлэлийн шаардлагатай, “Б” ХХК-аас гаргасан 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 1 тоот урьдчилгаа төлбөрийн баталгаа, мөн өдрийн 2 тоот гүйцэтгэлийн баталгааг тус тус хүчин төгөлдөр бусад тооцуулах тухай сөрөг нэхэмжлэлийн шаардлагатай иргэний хэрэг.⁴⁷

Нэхэмжлэгч шүүхэд гаргасан нэхэмжлэл, шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: ... “Олон улсын хэмжээнд нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн, нийтлэг хэрэглэгддэг, нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээ болох Баталгааны нэгдсэн журам буюу URDG-ийн хүрээнд гаргаж өгдөг энэ төрлийн баталгааг Баталгааны нэгдсэн журам-ын 2-р зүйлд тодорхой заасны дагуу арилжааны банк, даатгалын компани зэрэг санхүүгийн байгууллагууд гаргаж өгдөг бөгөөд уг гаргаж өгсөн баталгаа нь буцаан үл дуудагдах, үл маргах журмаар буюу баталгаа хүлээн авагчийн анхны шаардлагаар төлөгддөг гол онцлог нөхцөлөөрөө дотоодын болон **олон улсын практикт нэгэнт хэвшин тогтсон** санхүүгийн хэрэгсэл юм”, мөн “Урьдчилгаа төлбөрийн болон Гүйцэтгэлийн баталгаанд тус баталгаанууд нь Олон улсын худалдааны танхимын 458 дугаар болон 758 дугаар Баталгааны нэгдсэн журмаар зохицуулагдахыг заасан. Энэ нь Иргэний хуулийн 457 дугаар зүйлийн 457.17 дахь хэсэгт “Энэ хуулиар зохицуулаагүй банкны баталгаатай холбоотой бусад харилцааг олон улсын хэмжээнд хэрэглэдэг нийтлэг зохицуулалт, **ажил хэргийн хүрээнд тогтсон заншлаар** зохицуулна” гэж заасны дагуу маргаан бүхий баталгаанууд гарсан байна. Өөрөөр хэлбэл, маргаан бүхий баталгаанууд нь Банкны баталгааны олон улсын туршлага, зохицуулалтын дагуу гарсан Банкны баталгааны гэрээ байна” гэж тайлбарласан.

Шүүхээс нэхэмжлэгчийн дурдсан заншлын талаарх тайлбартай холбогдуулан ямар нэг дүгнэлт өгөөгүй бөгөөд үндсэн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

13. Иргэн Ч.Г нь Хаан банкны Замын-Үүд салбартай байгуулсан 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн орон сууцны зээлийн гэрээг хүчин төгөлдөр бусад

⁴⁷ Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 06 сарын 13-ны өдрийн 182/ШШ2018/01266 дугаартай шийдвэр <http://new.shuukh.mn/irgenanhan/82770/view>

тооцуулж, учирсан хохиролд 4074.000 төгрөг гаргуулах, хариуцагч Ч.Г-ийн итгэмжлэлээр Г.Ц-тэй байгуулсан 2013 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн орон сууц худалдах, худалдан авах гэрээг хүчин төгөлдөр бусад тооцуулах тухай нэхэмжлэл гаргасан байна.⁴⁸

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт: ... *“Нэхэмжлэгч Ч.Г эд хөрөнгийг худалдан авахдаа уг доголдлын талаар мэдсэн буюу мэдэх боломжтой байсан болох нь нэхэмжлэгчийн шүүхэд гаргасан нэхэмжлэл, шүүх хуралдаанд гаргасан тайлбарт: “...О цэвэр усны газар ажиллуулаач ашигтай гэсэн. Бид ч уг байрыг очиж үзэхэд үнэхээр хүн юм хийхийн аргагүй байсан ба бүх зүйлийг нь цэвэрлэж янзлаад ажиллуулах гэсэн боловч цаашид ажиллах ямар ч боломжгүй байсан” гэснээс, мөн Хаан банкинд гаргасан зээл хүссэн өргөдөлд “ бид үйлчилгээний зориулалттай орон сууц худалдан авах хүсэлтэй байгаа тул 80 сая төгрөгийн зээл олгож өгнө үү” гэсэн тайлбаруудаар тогтоогдож байх ба худалдан авагч өөрийн худалдан авч байгаа эд хөрөнгийн талаар судлах нь нийтэд **тогтсон заншлын хэм хэмжээ**” гэж шүүх дүгнээд, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.*

14. Нэхэмжлэгч Б.М нь 2011.11.02-ны өдөр байгуулагдсан бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бусад тооцож, Хан-Уул дүүрэг, 1 дүгээр хороо, Үйлдвэр /17041/ ХД 65 дугаар байр, 28 тоот 85.36 мкв талбай бүхий 3 өрөө орон сууцны өмчлөгчөөр Д.Д-ийг бүртгэсэн бүртгэлийг хүчингүй болгож, өмчлөх эрхээ сэргээлгэх, “ЭСЭЭ” ХХК-ийг төлөөлж Б.М, Н.А нарын хооронд 2012.08.23-ны өдөр байгуулсан “Гарааш худалдах, худалдан авах” гэрээг хүчингүйд тооцож, худалдах, худалдан авах гэрээний зүйл болох Хан-Уул дүүрэг, 1 дүгээр хороо, “Ш” цогцолбор Үйлдвэр-2 /17042/, ХД-76 байрны зоорийн давхарт байрлах 5,6 тоот 36 мкв талбай бүхий 2 авто зогсоолыг эргүүлэн “ЭСЭЭ” ХХК-ний нэр дээр буцаан олгуулахаар нэхэмжлэл гаргасан байна.⁴⁹

Хариуцагч нар нь шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: *“.... Нэхэмжлэгч гэгч Б.М нь “Т” ХХК-д менежерээр 2012 оны 9-р сарын 10-ний өдөр хүртэл ажилладаг байсан. Барилгын компаниуд бетон зуурмагийн төлбөрт машин, орон сууц өгөх нь элбэг байдаг. Энэ нь бетон зуурмаг болон барилгын компаниудын хувьд Эргэлтийн хөрөнгө гэсэн утгаар ашиглагддаг. Бетон зуурмагийн төлбөрт авсан машин, орон сууцаа цааш нь мөн л түүхий эд /элс, хайрга, цемент/ нийлүүлсэн компаниудад төлбөрт нь шилжүүлэн өгдөг. Иймд компанийн нэр дээр байнга авч дахин шилжүүлэхэд ажиллагаа их ордог, ялангуяа “ТЗ” ХХК-ийн захирлаар ажиллаж байгаа Д.Д ид ачааллын үед тэр болгон харилцагч нараас төлбөрт шилжүүлж буй бартерийн байрны гэрээг байгуулж, цааш шилжүүлэх ажиллагаанд явах цаг зав муу байдаг учир ихэнх тохиолдолд*

⁴⁸. Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 12 сарын 14-ний өдрийн 343 дугаартай шийдвэр <http://shine.shuukh.mn/irgenanhan/11650/view>

⁴⁹. Баянгол, Хан-уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 10 сарын 15-ны өдрийн 102/ШШ2015/06367 дугаартай шийдвэр <http://shine.shuukh.mn/irgenanhan/8002/view>

өөрийн компанийн итгэлтэй ажилтан болох менежер Б.М-ын нэр дээр бартерийн байрны гэрээг хийлгүүлэх албан тоотыг харилцагч компаниуд руу явуулан Б.М-ын нэр дээр гэрээг хийлгэн авч, дараа нь бусдад шилжүүлүүлэх ажлыг хийлгүүлдэг байсан. Энэ ажиллагаа нь бидний хувьд ажил хэргийн хүрээнд байнга хийгддэг тогтсон **заншил** болсон үйл ажиллагаа юм. Эд хөрөнгө гэдэг тоглоом биш, ухаан мэдрэлгүй явж байгаад хэн нэгэнд шилжүүлдэг ч эд биш. Нэхэмжлэлд дурьдаж буй байр ч энэ **тогтсон заншлын хүрээнд** хийгдсэн ажлын нэг юм” гэж дурдсан байна.

Шүүх Иргэний хуулийн 198 дугаар зүйлийн 198.6 дахь хэсэгт заасан зохицуулалтыг хэрэглээгүй ч дээр дурдсан гэрээнүүдийг Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-т заасан хүчин төгөлдөр бус байх хэлцэлд тооцуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

15.Нэхэмжлэгч “СО” ХХК нь худалдах, худалдан авах гэрээний үүрэгт 28,926,000 төгрөгийг “Д” ХХК-иас гаргуулахаар нэхэмжлэл гаргасан байна.⁵⁰

Хариуцагч тайлбартаа: “... Талуудын хооронд гэрээний эрх зүйн харилцаагаар бус гэрээ байгуулалгүйгээр, **тогтсон заншлын дагуу** шатахуун нийлүүлсэн харилцаа байгаа юм. Тийм учраас гэрээний 5.2-т зааснаар алданги тооцох боломжгүй, мөн 5.2-т заасны дагуу алданги тооцлоо гэхэд давхар зохицуулагдах 4.5-д төлбөр барагдуулах хугацааг заагаагүй байна. Түүнчлэн зээлээр худалдах, худалдан авах тохиолдолд барьцаа хөрөнгө авахаар гэрээний 4.4-т заасан байна. Гэтэл бид шатахууны үнийн дүнгийн 80 хувьтай тэнцэх барьцаа хөрөнгийг барьцаалаагүй ба тогтсон заншлын дагуу нэхэмжлэгчээс шатахуун авсан байдаг юм.” гэж дурьдсан байна. Шүүх уг маргааныг шийдвэрлэхдээ заншлын талаар дүгнэлт хийгээгүй байна.

Арбитрын шийдвэр

МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын олон улсын арбитрын шийдвэрийн 2006-2019 оны оныг хамруулан хайлт хийсэн болно. Энэхүү судалгаанд хамаарах “заншил”-ын талаар талууд үндэслэл гаргаж мэтгэлцсэн, түүнчлэн арбитраас заншил хэмээн дүгнэсэн байж болох дараах 2 арбитрын шийдвэр байгааг авч үзлээ. Үүнд:

16.Нэхэмжлэгч М хуулийн этгээд нь хариуцагч Х ХХК-иас ашигт малтмалын худалдах, худалдан авах гэрээний үлдэгдэл төлбөр /үндсэн үнэ болон үнийн тохируулга/ болох 4,052.62 ам.долларыг гаргуулах нэхэмжлэл гаргасан.⁵¹

Арбитр нь арбитрын шийдвэрийн үндэслэлдээ “энэ нь Иргэний хуулийн 196 дугаар зүйлийн 196.2-д заасан ажил хэргийн хүрээнд тогтсон заншлын дагуу ажил төрлийн байнгын холбоо бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн хууль ёсны тохиролцоо гэж үзэх үндэслэлтэй” хэмээн гуравдагч этгээдийн өмнө хүлээх

⁵⁰ Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2015 оны 04 сарын 30-ны өдрийн 2877 дугаар шийдвэр <http://www.shuukh.mn/irgenanhan/40934/view>

⁵¹ МҮХАҮТ-ийн дэргэдэх Монголын олон улсын ба үндэсний арбитрын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 382 дугаар шийдвэр

нэхэмжлэгчийн үүргийг хариуцагч гүйцэтгэснийг дүгнэсэн байдаг. Арбитрын шийдвэрийн үндэслэх хэсэгт мөн “.. талуудын өмнө нь хийж байсан гэрээнүүдийн практик нь төлбөр төлөгдсөн өдрийн ханшаар ам.долларыг тооцдог байсан гэсэн тайлбарыг нэхэмжлэгч талаас гаргасныг дурдах нь зүйтэй” хэмээсэн байдаг ба арбитрын шийдвэрийн тогтоох хэсэгт Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсгийг баримтлан тухайн асуудлаар тогтож хэвшсэн худалдааны зан заншлыг харгалзан маргааныг шийдвэрлэсэн байдаг.

17.Нэхэмжлэгч М хуулийн этгээд нь хариуцагч Г ХХК-иас ашигт малтмалын нийлүүлсний үлдэгдэл төлбөр /үндсэн үнэ болон үнийн тохируулга/ болох 14,259.15 ам.долларыг гаргуулах нэхэмжлэл гаргасан.⁵²

Арбитр нь арбитрын шийдвэрийн үндэслэлдээ “Гэрээний 3.1, 3.4 дэх хэсэгт заасан үлдэгдэл төлбөрийг тогтоох аргыг талууд худалдааны практикт тогтсон заншил ёсоор тогтоохоор харилцан тохиролцсон байна” хэмээн ашигт малтмал нийлүүлэх гэрээнд үнийн тохируулга хийдэг олон улсын худалдааны практикийг дурдсан ба арбитрын шийдвэрийн тогтоох хэсэгтээ Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсгийг баримтлан тухайн асуудлаар тогтож хэвшсэн худалдааны зан заншлыг харгалзан маргааныг шийдвэрлэсэн байдаг.

5.2. АРИЛЖААНЫ ОРЧИНД ТОГТСОН ПРАКТИКТ ХОЛБОГДОХ ШҮҮХ, АРБИТРЫН ШИЙДВЭР

Шүүхийн шийдвэр

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn)-д байршиж буй 2013.12.18-ны өдрөөс хойшхи иргэний хэргийн шүүхийн шийдвэрүүдээс “**тогтсон практик**”- гэсэн түлхүүр үгээр хайлт хийхэд нийт 5 шийдвэр илэрсэн болно. Эдгээр шийдвэрийг товч авч үзье.

1.Нэхэмжлэгч Б.М нь “Х банк” ХХК-д холбогдох ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны олговор, урамшуулалд 6 250 000 төгрөг гаргуулахаар нэхэмжлэл гаргасан байна.⁵³

Нэхэмжлэгч тайлбартаа: “...Зээлийн судалгаа хийж, зээлийн хороогоор хэлэлцүүлээгүй 60 000 000 төгрөгийн тодорхойлолт гаргаж өгсөн үйлдлийг намайг явал буруутгах вэ гэдэгт нэмэр, шалтаг болгож байгаа бөгөөд би банкны салбарын захирлын хувьд үйлчлүүлэгч “У” ХХК-ийн хүсэлтийн дагуу урьд өмнө нь манай банкнаас 80 000 000 төгрөгийн зээл авч байсан зээлийн хорооны шийдвэр, хувийн хэргийг үндэслэн тендерт оролцох тодорхойлолт гаргаж өгсөн. Тус компанийн үйл ажиллагаа өргөжиж, ашиг олох үйл ажиллагаа нь сайн байгууллага гэж үзсэн. Тэгээд ч энэ нь банкны хууль, миний хүлээсэн үүргийн дагуу ажил бөгөөд энэ мэт тодорхойлолт банкны салбарын захирал гаргахдаа

⁵² МҮХАҮТ-ийн дэргэдэх Монголын олон улсын ба үндэсний арбитрын 2019 оны 10 дугаар сарын 22-ний өдрийн 345 дугаар шийдвэр

⁵³ Монгол улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2015 оны 06 сарын 30-ны өдрийн 532 дугаартай тогтоол, <http://www.shuukh.mn/irgenhyant/1411/view>. /Тогтсон практикийн талаар магадлал, тогтоолд дурдагдсан./

зээлийн хороогоор заавал хэлэлцүүлэх журам, зохицуулалт байхгүй. “Х банк”-ны хувьд **тогтсон практик**, “У” ХХК-д зээл олгох ямар ч үндэслэл болохгүй бөгөөд энэ тодорхойлолтоор ямар нэгэн зээл аваагүй. “Х банк”-д хохирол учруулаагүй.” гэжээ.

Давж заалдах болон хяналтын шатны шүүхээс нэхэмжлэгч талаас тайлбарласан “тогтсон практик” гэсэн үйлдлийг тогтсон практик бус харин банкинд мөрдөгддөг “Дотоодын баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ыг зөрчсөн үйлдэл боловч сахилгын зөрчил давтан гаргасан болох нь тогтоогдоогүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн байна.

2.Нэхэмжлэгч “ЭЗ” ХХК нь “МЭ” ХХК-иас Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу үлдэгдэл төлбөр 510 сая төгрөг гаргуулахаар нэхэмжлэл гаргасан байна.⁵⁴

Шүүх шийдвэрийнхээ үндэслэх хэсэгт “... Дээрх хоёр албан бичгийн талаар хариуцагчийн нэг төлөөлөгч шүүх хуралдаанд “...удаа дараа нэхэмжлэх ирүүлээд байсан тул урьдын ажил хэргийн харилцааг бодолцоод 510 сая төгрөг төлөхийг зөвшөөрсөн ...дараа нь компанийн эрх бүхий ажилтнууд хэлэлцээд 510 сая төгрөгийг төлөх үндэслэлгүй гэж үзсэн тул төлөөгүй, энэ талаар албан бичиг хүргүүлээгүй нь төлбөр төлөх үндэслэлгүй гэдгээ дуугүй байдлаар илэрхийлсэн хэрэг...” гэсэн тайлбарыг дурьдсан байна.

Шүүх “МЭ” ХХК-ийн 139-065/13, 139-371/13 тоот албан бичгүүдийг нэг бус удаагийн хамтын ажиллагаатай байсан хоёр компанийн хоорондын **ажил хэргийн харилцаанд тогтсон практик** гэж үзэхийн зэрэгцээ иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нэг этгээд тодорхой асуудлаарх хүсэл зоригийн илэрхийллээ нөгөө этгээдэд бичгээр гаргаж байсан бол уг илэрхийллээ дуусгавар болгоход мөн адил хэлбэрийг баримтлах ёстой гэж үзнэ.” хэмээн дүгнэж, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн байна.

3.Нэхэмжлэгч “Т” ХХК нь “Х банк” ХХК, “Б” ХХК, “Р” ХХК-д холбогдуулан хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах, хэлцлээр шилжүүлсэн 465 519 990 төгрөгийг Х банкаас гаргуулах тухай нэхэмжлэл гаргасан байна.⁵⁵

Анхан шатны шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн бөгөөд нэхэмжлэгч нь давж заалдах журмаар гомдол гаргасан байна.

Давж заалдах шатны шүүхээс “... “ТЖ” ХХК-ийн дээрх албан бичигт гарын үсэг зурсан ЛЛ нь компанийг төлөөлөх эрхгүй гэх боловч тус компанийн Ерөнхий захирал ШСЖ-аас гүйцэтгэх захирал ЛЛ-д шүүхэд төлөөлөх эрх олгосон итгэмжлэлийг шүүхэд баримтаар гаргасан нь хэрэгт авагдсан, мөн тус компанийг төлөөлөн бусадтай Гүйцэтгэх захирлын хувиар гэрээ байгуулсан баримтууд хэрэгт авагдсанаас үзвэл тус компанийн Гүйцэтгэх

⁵⁴. Шүүхийн шийдвэрийн цахим санд <http://www.shuukh.mn/irgenanhan/7045/view>. холбоосоор ороод 4-19 дүгээр хуудсанд “ЭЗ” ХХК-ийн нэхэмжлэлтэй “МЭ” ХХК-д холбогдох хэргийн шүүхийн шийдвэрийг байршуулсан байна.

⁵⁵. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018-06-22-ны өдрийн 210/МА2018/01471 дүгээр магадлал <http://new.shuukh.mn/irgendavah/9723/view>

захирал ЛЛ гэж гарын үсгээр баталгаажуулсан санал нь Иргэний хуулийн 198 дугаар зүйлийн 198.6 дахь хэсэгт заасан **тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил байх** бөгөөд Х банк хүлээн авсныг буруутгах боломжгүй.” гэж дүгнээд нэхэмжлэгчийн давж заалдах журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисон байна.

4.Нэхэмжлэгч “Б” ХХК нь “Н” ХХК-иас гэрээний үүрэгт 1,451,823,900 төгрөгийг гаргуулахаар нэхэмжлэл гаргасан байна.⁵⁶

Нэхэмжлэгчээс хяналтын журмаар гаргасан гомдолдоо: “...Хэдийгээр гэрээнд төлбөрийг хэзээ төлөх талаар тодорхой заагаагүй боловч Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1-д зааснаар худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийнхээ дагуу “Н” ХХК нь захиалсан барааныхаа үнийг тухай бүрд нь төлдөг байсан нь нотлох баримтаар нотлогддог. Нийлүүлсэн тэжээлийн үнийг тухай бүрд нь төлдөг байсныг нотлох 3 төрлийн нотлох баримт хэрэгт авагдсан. Үүнд: Иргэний хуулийн 198 дугаар зүйлийн 198.6-д зааснаар талуудын нэгдмэл санааг тодруулахын тулд харилцан илгээсэн баримт бичиг, талуудын хооронд **тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил** зэргийг харгалзан үзнэ гэж заасан байдаг ба нотлох баримтаар нотлогдож байгаа дээрх үйл баримтаас харахад нийлүүлсэн барааны үнийг тухай бүрд нь худалдан авагч тал төлж байсан нь талуудын хооронд **практик болон тогтсон** байна.” гэж тайлбарласан байна.

Хяналтын шатны шүүх нэхэмжлэгчийн дурьдсан худалдан авсан барааныхаа үнийг тухай бүр төлдөг байсан нь талуудын хооронд тогтсон практик гэх тайлбарыг үндэслэлгүй гэж үзэн тооцоо нийлж, нэхэмжлэх хүргүүлсэн өдрөөс эхлэн алданги нэхэмжлэх эрхтэй гэж дүгнээд нэхэмжлэгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисон байна.

5.Нэхэмжлэгч Ц.Э, Ю.Б нар нь иргэн А.О, Д.Т нарт холбогдуулан хувийн орон сууцыг захиран зарцуулах эрхийг олгосон итгэмжлэлийг хүчингүй болгуулах, мөн хариуцагч нар нь зээлийн гэрээний үүрэгт 32,000,000 төгрөг гаргуулах тухай сөрөг нэхэмжлэл гаргасан байна.⁵⁷

Нэхэмжлэгч тайлбартаа “... зээлийн гэрээний дагуу зээлдүүлэгч Д.Т хэлсний дагуу дүү нь гэх Д.Т 2015 оны 4 дүгээр сарын 19-нд 1,200,000 төгрөг өгсөн.” гэж тайлбарласан байдаг.

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт “Ц.Э хэд хэдэн удаа Д.Т-гийн Хаан банкны дансанд мөнгө шилжүүлж, зээл төлж байсан талаарх ХААН банкны орлого, мөнгөн шилжүүлэгийн мэдүүлэг хэрэгт авагдсан, тэдгээрийг хариуцагч тал эсэргүүцээгүйн зэрэгцээ гэрч Д.Т, Ю.Х-ын нарын мэдүүлэг үйл баримтыг

⁵⁶ Монгол улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2018 оны 05 сарын 15-ны өдрийн 001/ХТ2018/00769 дугаартай тогтоол <http://new.shuukh.mn/irgenhyanalt/4715/view>

⁵⁷ Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх хуралдааны 2015 оны 11 сарын 13-ны өдрийн 7717 дугаартай шийдвэр <http://shine.shuukh.mn/irgenanhan/8810/view> /Тогтсон практикийн талаар шийдвэр, магадлал, тогтоолд дурдагдсан./

тогтооход ач холбогдол үзүүлэхүйц байна. Дээрх нь талуудын хооронд **тогтсон практик** гэж үзэж болохоор байна” гэж дүгнээд үндсэн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, сөрөг нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн байна.

Арбитрын шийдвэр

МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын олон улсын арбитрын шийдвэрийн 2012-2019 оны оныг хамруулан хайлт хийсэн болно. Энэхүү судалгаанд хамаарах “практик”-ийн талаар талууд үндэслэл гаргаж мэтгэлцсэн, түүнчлэн арбитраас практик хэмээн дүгнэсэн байж болох 1 арбитрын шийдвэр байна.

6. М ХХК-ийн нэхэмжлэлтэй, С ХХК-д холбогдох маргаанд хариуцагч С ХХК нь 367,400 ам.доллар гаргуулах сөрөг нэхэмжлэл гаргасан байдаг.⁵⁸

Арбитр нь арбитрын шийдвэрийн сөрөг нэхэмжлэлийг авч үзсэн үндэслэлдээ “гүйцэтгэлийн баталгааг ... захиалагч тал ... барилгын салбарт төлөвшин тогтсон практикийн дагуу өөрийн дансандаа байршуулсан байна” хэмээн дүгнэсэн байдаг.

5.3. Дүн шинжилгээ

Шүүх, арбитрын шийдвэрт дурдагдсан заншлыг нээн илрүүлэхдээ нэхэмжлэл, тайлбартаа заншил хэмээн хэргийн оролцогчид мэтгэлцсэн болон шүүх, арбитр хэргийг шийдвэрлэхдээ үндэслэл болгосон заншлын хэм хэмжээний аль алинд анхаарал хандуулсан болно. Үүний үр дүнд дараах дүн шинжилгээг хийж болохоор байна. Үүнд:

1. Шүүхийн шийдвэрийн цахим сан, МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын олон улсын арбитрын шийдвэрийн сангаас хайлт хийхэд тодорхой тооны шийдвэрт арилжааны заншил болон тогтсон практикийн асуудал туссан байх ба энэ нь шүүх, арбитр арилжааны заншил, тогтсон практикийг тодорхой хэмжээнд анхаарч үздэг болохыг харуулж байна.
2. Зохигчид, талууд арилжааны заншил, тогтсон практикийн талаар үндэслэлээ гаргаж мэтгэлцдэг боловч шүүх энэ үндэслэлийнх нь талаар нухацтай авч үзэж, дүгнэлт өгдөггүй байх магадлалтай байна.
3. Эдгээр шүүхийн шийдвэрүүдийн агуулгыг судалж үзэхэд шүүх хэрэглэхдээ тухайн харилцаа нь тогтсон практик эсхүл заншлын чухам алинаар нь зохицуулагдахын зааг ялгааг гаргаж дүгнэхгүй, эсхүл тийнхүү тусгайлан дүгнэхээс зайлсхийдэг байж болзошгүй байна.
4. Шүүх нь өөр шүүх өмнө нь заншил хэмээн тодорхойлж, шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон арилжааны заншлыг өөрийн шийдвэрийн үндэслэл болгож маргааныг дүгнэсэн тохиолдол одоогоор байхгүй байна гэж дүгнэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, шүүх нь хандлагын хувьд өөр шүүхийн өмнө нь заншил хэмээн тодорхойлсон зан үйлийн журмыг эрх

⁵⁸ МҮХАҮТ-ийн дэргэдэх Монголын үндэсний арбитрын 2012 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 104 дүгээр шийдвэр

зүйн эх сурвалж хэмээн зөвшөөрөхөөс түдгэлздэг, аль болох бичмэл эх сурвалжид шийдвэрээ үндэслэдэг байх магадлалтай.

5. Шүүх нь заншил, тогтсон практикийг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгохдоо тодорхой үйл баримтыг дүгнэх үндэслэл болгох байдлаар заншил, тогтсон практикийн хэрэглээг хязгаарладаг байх магадлалтай байна.
6. Арилжааны заншил, тогтсон практикийг хууль, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан эсэх талаар дүгнэсэн шүүх, арбитрын шийдвэр одоогоор байхгүй байна.

ЗУРГАА. АРИЛЖААНЫ ХҮРЭЭНД ТОГТСОН ПРАКТИКИЙН ЖИШЭЭ

6.1. Ярилцлагын, ажиглалтын болон баримт бичгийн судалгааны дүн

Бизнесийн орчны зарим харилцаанд дараах практик тогтсон байна. Үүнд:

1. Зээлийн харилцаанд

Цалингийн зээл⁵⁹

Арилжааны банкууд цалингийн орлогыг барьцаалан зээл олгох үйлчилгээг хэрэглэгчдэд санал болгодог. Харин цалингийн зээл авах ажилтантай Зээлийн гэрээ байгуулахдаа цалингийн орлогыг барьцаалахаас гадна тухайн зээлдэгчийн гэр бүлийн эд хөрөнгөнөөс заавал давхар барьцаалж зээл олгодог практик тогтсон байна.

Шигтгээ 1.

Би ХААН Банкнаас 2020 оны 1 сард 3.5 сая төгрөгийн цалингийн зээл авахаар очиход банкны зээлийн эдийн засагч нь надтай Зээлийн гэрээ байгуулахдаа цалингийн орлогыг барьцаалахаас гадна манай гэрийн Samsung брэндийн хөргөгч, угаалгын машины мэдээллийг барьцааны гэрээнд тусгаж давхар барьцаалсан. Би тухайн үед гайхаад өнгөрсөн. Дараа нь манай ажлын хүн цалингийн зээл авахад яг адилхан гэрийнх нь эд хөрөнгөөс давхар барьцаалсан байна лээ. Уг нь бол банк цалингийн орлогыг барьцаалж зээл олгоно гэж сурталчилдаг ч бодит байдалд давхар эд хөрөнгө барьцаалж байгаа нь буруу практик гэж бодож байна.

“ДХА” ХХК-ийн менежертэй хийсэн ярилцлагаас

Гар утасны дугаар барьцаалан зээл олгох үйлчилгээ⁶⁰

Жил ирэх тусам хувь хүн, хуулийн этгээдийн хооронд үүрэн телефоны гар утасны дугаар барьцаалан зээл олгох үйлчилгээ өсөн нэмэгдэж байна. Зээлдүүлэгч нь зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлд зээлдэгчийн эзэмшлийн

⁵⁹ <https://www.khanbank.com/mn/personal/product/72>

⁶⁰ <https://gsbcapital.mn/content/9?mid=3>

үүрэн телефоны дугаар (9911xxxx, 9909xxxx, 8811xxxx гэх мэт)-ыг барьцаалан зээл олгодог байна. Зээлийг олгохдоо барьцаалж буй гар утасны дугаарыг зээлдүүлэгч өөрийн нэр дээр шилжүүлэн авдаг практик тогтсон байна.

Шигтгээ 2.

Манай захирал гар утасны дугаар барьцаалан зээл олгох үйлчилгээг судлаж өгөхийг надаас хүссэн юм. Би хэд хэдэн энэ төрлийн зээл олгодог банк бус санхүүгийн байгууллагыг судалж үзэхэд бүгд л барьцаалж буй гар утасны дугаарыг өөрийн нэр дээр шилжүүлэн авна гэж байсан. Тухайлбал:

“Ж Капитал” ББСБ нь 30 сая төгрөг хүртэлх зээлийг 3,5 хувийн хүүтэй, 12 сар хүртэл хугацаатай, гар утасны дугаар барьцаалан, сар бүр тэнцүү төлөлттэй, зээлийн дүнгийн 0,5 хувийн шимтгэлтэй, өргөдлийн хураамжийг 10,000 төгрөгөөр тогтоон зээл олгож байна. Тэгэхээр гар утасны дугаар барьцаалан зээл олгохдоо барьцаалж буй гар утасны дугаарыг банк бус санхүүгийн байгууллага өөрийн нэр дээр шилжүүлэн авдаг байна.

“Б компьютерс” ХХК-ийн захирлын туслахтай хийсэн ярилцлагаас

Өдрийн зээл⁶¹

Монгол Улсад “Өдрийн зээл”-ийн харилцаа 2000 оноос эхлэн бий болсон байх бөгөөд сарын 10-40 хувийн хүүтэй мөнгийг хувиараа жижиг бизнес эрхлэгч болон иргэдэд өдөр тутмын орлогоос нь эргэн төлөлт хийх нөхцлөөр олгодог байна. “Өдрийн зээл”-ийн харилцаа нь ихэвчлэн “100 айлын барилгын материалын зах”, “Наран туул” олон улсын худалдааны төв, “Бөмбөгөр” худалдааны төв зэрэг томоохон худалдааны төвд лангуу эзэмшигчдийн дунд үүсдэг байна. Зээлдэгчид нь өдрийн зээлээ хугацаандаа эргэн төлж чаддаггүйн улмаас зээлдсэн мөнгөнөөсөө хэд дахин илүү хүү төлөх тохиолдол түгээмэл гардаг байна.

Шигтгээ 3.

Манай компани худалдаа, жижиг үйлдвэрлэл эрхэлдэг тул томоохон зах, худалдааны төвүүдэд бизнес эрхэлдэг хүмүүст бараа бүтээгдэхүүнээ нийлүүлдэг. Манай бүтээгдэхүүнийг худалдан борлуулдаг хүмүүс бараа бүтээгдэхүүний үнийг төлөхдөө өдрийн зээл их авдаг юм байна лээ. Өдрийн зээл гээд байгаа нь маш өндөр хүүтэй, хууль бус мөнгө хүүлэлтийн хэлбэр гэж ойлгож болно.

Жишээлбэл, 1 сая төгрөгийн зээл авлаа гэж бодоход эхний 22 хоногийн хугацаанд хүү нь өдрийн 50 мянган төгрөг байна. Зөвхөн хүүнд 1,100,000 мянган төгрөг төлнө. 22 хоногийн дараа нийт 2,100,000 мянган төгрөг өгөх ёстой болно. Хэрвээ тохирсон хугацаандаа анхны зээлсэн мөнгөө төлж чадахгүй бол 22 дахь хоногоос эхлээд хүүгээс хүү бодогддог байна.

⁶¹. <http://dardas.mn/news/view/1254>

Ийнхүү 1 сая төгрөгөөс эхэлсэн зээл богино хугацаанд буюу ойролцоогоор хагас жилийн дараа 10 орчим сая төгрөг болдог. Зээлдүүлэгч нь барьцаа хөрөнгө шаарддаггүй учраас зээлийн процесс шуурхай байдаг гэсэн. Мөн тухайн зээлээ хугацаандаа төлөөгүй тохиолдолд цагаар алданги тооцдог бөгөөд энэхүү “өдрийн зээл” нэртэй өндөр хүүтэй, хүүгийн хүү болон алданги боддог харилцаа ялангуяа жижиглэн худалдаа эрхэлдэг бизнес эрхлэгчдийн дунд түгээмэл байгаа.

“БНБ” ХХК-ийн нягтлан бодогчтой хийсэн ярилцлагаас

Барьцаалан зээлдэх журмаар зээл олгох үйлчилгээ

Иргэний хуульд Зээлдэгч зээлсэн мөнгө болон түүний хүүг хугацаанд нь буцаан төлөөгүй тохиолдолд барьцаалан зээлдэх газар барьцаалагдсан хөрөнгийг худалдан борлуулах замаар үүргийг хангуулах тухай зээлдэгчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэнээс хойш 10 хоногийн дотор зээлдэгч үүргээ гүйцэтгээгүй бол барьцааны зүйлийг комиссийн буюу дуудлага худалдаагаар худалдаж, борлуулсан үнийн дүнгээс үүргийг хангуулж үлдсэн мөнгийг буцаан олгоно гэж заасан байдаг.

Гэвч барьцаалан зээлдүүлэх газар буюу ломбард нь үүргийг хангуулах тухай бичгээр зээлдэгчид мэдэгддэггүй, хуульд заасан 10 хоногийн хугацааг хүлээдэггүй, комиссийн буюу дуудлага худалдаагаар худалддаггүй шууд худалдан борлуулдаг мөн үүргийг хангуулж үлдсэн мөнгийг буцаан олгодоггүй, хэдэн төгрөгөөр худалдсан нь тодорхой бус байх тохиолдол түгээмэл байна. Энэ нь манай улсад дуудлага худалдааны орчин бий болоогүй иргэд хуулийн мэдлэг дутмаг байгааг харуулж байна.

Шигтгээ 4.

Би Н нэртэй ломбарданд мөнгөний хэрэг гараад охиныхоо 2.000.000 төгрөгийн үнэтэй нөүтвүүкийг барьцаалан 1 сарын хугацаатай 6 хувийн хүүтэй 600,000 төгрөгийг зээлсэн. Тухайн үед эхнэрийн бие тааруу би эмнэлэгт сахих болж, ажлаа хийгээгүй учраас хугацаандаа зээлсэн мөнгөө өгч чадаагүй юм. Тэгээд тохирсон хугацаанаасаа 10 хоногийн дараа мөнгө олоод нөүтбүүкээ авахаар очиход та хугацаа хэтрүүлсэн учраас таны нөүтбүүкийг зарсан гэж хэлсэн. Надад худалдах талаар мэдэгдээгүй ш дээ гэхэд таны утас холбогдохгүй байсан гээд өнгөрсөн.

Уг нь бол 2.000.000 төгрөгийн үнэтэй нөүтбүүкийг арай ч 600,000 төгрөгөөр зараагүй байх тэгэхдээ надад зөрүү мөнгө юу ч өгөөгүй, та хугацаа хэтрүүлсэн учраас таны зээлсэн мөнгө, хүүний төлбөрийн нийлбэрээр тооцож худалдан борлуулсан гэсэн.

Иргэн А-тай хийсэн ярилцлагаас

2.Барьцаа хөрөнгийн үнэлгээний харилцаанд

Банк, санхүүгийн байгууллагаас зээл олгохдоо барьцаа хөрөнгийг зах зээлийн үнээс маш багаар үнэлэх, зээлийн өр төлбөрөө шууд тооцон авах практик байна. Тухайлбал, банкнаас зээл авч, тухайн барьцаа хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийсний дүнд зах зээлийн үнэ цэнэ өссөн байхад банк санхүүгийн байгууллага тухайн хөрөнгийг зээлийн өр төлбөртөө шилжүүлэн авдаг практик байна.

Шигтгээ 5.

Манай компани У банкнаас ашигт малтмалын хайгуул хийх зорилгоор өөрийн эзэмшлийн лицензээ барьцаалан зээл авсан юм. Улмаар тухайн зээлийн хөрөнгөөр хайгуул хийж, лицензийнхээ үнэ цэнийг өсгөсөн. Гэтэл хугацаандаа зээлээ төлөөгүй гэсэн шалтгаанаар банк өөрийн нэрлэсэн компанийн нэр дээр лицензийг шилжүүлэн авч биднийг ихээхэн хохироож байна.

“Р” ХХК-ийн захиралтай хийсэн ярилцлагаас

3. Түрээсийн харилцаанд

Түрээсийн гэрээ байгуулахад тавигдах шаардлага

Иргэний хуульд түрээсийн гэрээг бичгээр байгуулж, эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлэхээр заасан боловч үл хөдлөх эд хөрөнгийн зарим хэсэг болон багахан хэсгийг түрээслэхэд түрээсийн гэрээг зөвхөн бичгээр байгуулаад нотариатаар гэрчлүүлдэг практик тогтсон байх бөгөөд үүнийг шүүх буруутгадаггүй байна.

Шигтгээ 6.

Иргэн А өөрийн үйлдвэрийн барилгаас 200м² талбайг Б-д түрээслүүлсэн бөгөөд түрээсийн гэрээг бичгээр хийсэн. Түрээслэгч Б түрээсийн гэрээг Иргэний хуульд зааснаар үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлээгүй тул хүчин төгөлдөр бус тул түрээсийн төлбөр төлөхгүй гэж маргасан хэргийг шүүхээс шийдвэрлэхдээ “А, Б нарын хооронд байгуулсан “түрээсийн гэрээний зүйл нь тусдаа улсын эрхийн бүртгэлд бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгө биш бөгөөд үл хөдлөх эд хөрөнгийн зарим хэсгийг түрээслэхэд гэрээг улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагагүй тул хэлцэл хүчин төгөлдөр гэж үзнэ.” гэжээ.⁶²

Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2007-06-18-ны өдрийн 287 дугаар магадлалын хэсгээс

Түүнчлэн түрээсийн гэрээний хугацаанд түрээслэгч тал түрээсийн байрыг үйл ажиллагаанд нийцүүлэн өөрийн хөрөнгөөр засвар тохижилт, засан

⁶² Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2007-06-18-ны өдрийн 287 дугаар магадлал. Монгол улсын шүүхийн шийдвэрийн эмхэтгэл (иргэний хэрэг). Цуврал 7. УБ.2008., 89 дэх тал

сайжруулсны дараа түрээслүүлэгч нь гэрээний нөхцлийг өөрчлөх, гэрээг цуцлах, гэрээний хугацааг үндэслэлгүйгээр сунгадаггүй практик байна.

4. Үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах харилцаанд

- Орон сууц худалдах, худалдан авах харилцаанд орон сууцны талбайн зөрүү гарах тохиолдол түгээмэл байдаг. Энэ тохиолдолд барилгын компани талбайн зөрүүг шийдвэрлэж, худалдан авагчийг хохиролгүй болгох алхмыг хийдэггүй байна. Тиймээс худалдан авагч нь шүүхэд хандахад хүрдэг.

Шүүх Иргэний хуулийн 255 дугаар зүйлийн 255.1.1-д заасан “эд хөрөнгө хүлээж авах үедээ уг эд хөрөнгийн доголдлын талаар мэдсэн буюу мэдэх боломжтой байхад түүнийг хүлээн авсан,” байх гэсэн үндэслэлээр худалдан авагч орон сууцаа хүлээж авах үедээ талбайн хэмжээ дутуу, доголдлыг мэдэх боломжтой байсан гэж тайлбарлан нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэх болсон байна. Үүнээс улбаалан барилгын компани нь зураг төсөл болон гэрээгээр тохиролцоноос дутуу хэмжээтэй орон сууц барьж, худалдан авагчийг хохироож, үндэслэлгүй хөрөнгөжиж, шударга бус байдлыг бий болгож байна.

Шигтгээ 7.

Баянзүрх дүүргийн иргэн Б миний бие “Д” ХХК-тай орон сууц захиалгын гэрээ байгуулж 88 м.кв орон сууцыг 96,800,000 төгрөгөөр худалдан авсан. 2008 оны 6 дугаар сард орон сууцаа хүлээн авсан. 2009 оны 1 дүгээр сард орон сууцны талбайг Мэргэжлийн хяналтын газарт хандан хэмжилт хийлгэхэд 78 м.кв байсан буюу 10 м.кв дутуу байсан. Илүү төлсөн 11,000,000 төгрөгийг “Д” ХХК-аас нэхэмжилсэн бөгөөд шүүхээс Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1, 255 дугаар зүйлийн 255.1.1-д заасныг удирдлага болгон нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шударга бус хандсан.

Баянзүрх дүүргийн оршин суугч Б-тэй хийсэн ярилцлагаас

- Тухайн үл хөдлөх эд хөрөнгийг бүрэн хэмжээгээр баригдаж дуусахаас өмнө, “Үл хөдлөх эд хөрөнгийн захиалгын гэрээ” нэртэй гэрээ байгуулж, төлбөрийг урьдчилан бүхэлд нь болон хэсэгчлэн төлдөг практик тогтсон байна. Энэ нь зарим тохиолдолд худалдан авагчийг хохироож байна.

Шигтгээ 8

Миний бие “М” компаниас 100 м.кв 4 өрөө орон сууц худалдан авахаар тохиролцож, тухайн орон сууцны барилга баригдаж дуусаагүй байхад “Орон сууцны захиалгын гэрээ” байгуулж, төлбөрөө урьдчилан бүрэн төлсөн юм. Орон сууцаа хүлээн авч, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг гаргуулан авах гэтэл улсын бүртгэлийн газраас “Таны байр банкны барьцаанд байгаа тул өмчлөх эрхийн гэрчилгээ гарах боломжгүй” гэсэн хариу өгсөн. Ингээд барилгын компанийн удирдлагатай уулзаж тодруулахад тухайн орон сууцны барилгыг бүхэлд нь банкинд барьцаалан зээл авсан байсан. Энэ

асуудлаар шүүхэд хандахад шүүхээс “тухайн орон сууцыг барьцаатай нь худалдан авсан байна” гэж шийдвэрлэж, тухайн компанийн авсан зээлийн дүнгээс тодорхой хэсгийг төлөх үүрэг хүлээж, хөрөнгө мөнгөөрөө хохирсон.

Өмчлөгч Ж-тэй хийсэн ярилцлагаас

5. Ажил, үүргээ дүгнэхтэй холбоотой харилцаанд Гүйцэтгэх удирдлага ажлаа хүлээлгэн өгөхгүй байх

Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийн хугацаа дуусахад ажил, үүргээ хүлээлгэн өгөхгүй, компанийн хэвийн үйл ажиллагаанд санаатайгаар саад болж, алдагдал, хохирол учруулдаг байна.

Шигтгээ 9.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулж, шинэчилсэн дүрэм баталсан. Уг дүрмээ улсын бүртгэлд бүртгүүлж баталгаажуулахын тулд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан УБ-05 маягтыг бөглөх ёстой. Гэтэл өмнөх гүйцэтгэх захирал нь тамга дарж баталгаажуулж өгөхгүй байгаа тул өнөөдрийг хүртэл шинэчилсэн дүрмээ улсын бүртгэлд бүртгүүлж чадахгүй байна.

Үүнээс хойш тус компани нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулсан. Уг хурлаар гэрээний хугацаа дууссан гэх үндэслэлээр гүйцэтгэх захирлыг ажлаас нь чөлөөлсөн. Гэтэл гүйцэтгэх захирал нь шинээр томилсон гүйцэтгэх захиралд ажлаа хүлээлгэж өгөхгүй, компанийн холбогдох баримт бичиг, тамга тэмдгийг өгөхгүй байх явдал гарсаар байна.

“МТ” ХХК-ийн гүйцэтгэх захиралтай хийсэн ярилцлагын хэсгээс

6. Итгэлцэлтэй холбоотой харилцаанд

Иргэд хооронд болон аж ахуйн нэгжүүд нь хоорондоо хөрөнгө оруулж хамтран ажиллахдаа хөрөнгө оруулагч тал нь хөрөнгө оруулалтынхаа баталгаа болгон нөгөө талынхаа эд хөрөнгө, эзэмших эрхийг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авдаг харилцаа түгээмэл гарч байна. Үүний нэг жишээ нь доорх тохиолдлоор илэрч байна.

Шигтгээ 10.

Иргэн би Т миний бие “СМ” ХХК-аа 2011 онд ганцаараа үүсгэн байгуулж, 100%-ийн хувьцааг дангаараа эзэмшиж ирсэн юм. 2013 онд компанийнхаа үйл ажиллагааг өргөтгөх үйлчилгээний барилгын ажилд маань хөрөнгө оруулалт шаардлагатай болсон юм. Ингээд өөрийн танилтайгаа уулзахад “компанийхаа 90%-ийн хувьцааг баталгаа болгоод миний нэр дээр шилжүүлчих, тэгвэл

барилгын ажилд чинь хөрөнгө оруулья” гэсэн. Уг саналыг хүлээн зөвшөөрч хамтран ажиллахаар болж компанийнхаа 90%-ийн хувьцааг бэлэглэлийн журмаар үнэ төлбөргүй шилжүүлсэн. Ингээд барилгын ажил дуусч, барилгыг ашиглалтанд оруулж өөрсдийн зохих хувь хэмжээг авсан боловч “СМ” ХХК-ийн маань 90%-ийн хувийн хувьцааг буцаан шилжүүлэхгүй байх бөгөөд өнөөдрийг хүртэл маргаантай хэвээр байна.

“СМ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч Т-тэй хийсэн ярилцлагаас

7.Компанийн харилцаанд

Компанийн тухай хуульд зааснаар (63.5, 69.1) Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор хүрдэг. Харин хэлэлцэх асуудлуудыг тухайн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэдэг. Гэтэл практикт 2 ба түүнээс дээш, тэнцүү тооны хувьцаа эзэмшигчтэй компанийн хувьцаа эзэмшигч нар хоорондоо маргаан үүсч, компанийн үйл ажиллагаанд санал зөрөлдвөл дээрх зохицуулалтын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах боломжгүй болдог. Өөрөөр хэлбэл, хурлын ирц хүрэхгүй бол тухайн хурал хүчин төгөлдөр бус болдог эсвэл хурлын ирц бүрдсэн ч хэлэлцэх асуудалд санал хураахад хувьцаа эзэмшигчдийн олонхийн санал авч чадахгүйгээс болж тухайн хурал амжилтгүй дуусдаг.

Түүнчлэн хувьцаа эзэмшигчдийн хурлын дээрх хувь хүрээгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг дахин товлох зохицуулалт Компанийн тухай хуульд бий. Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал саналын эрхийн 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хүчин төгөлдөр болох боловч бүх хувьцаа эзэмшигч хуралд оролцвол дахиад хэлэлцэх асуудлуудад олонхийн санал авч чадахгүй тул хойшлогдсон хурал шийдэлд хүрэхгүйгээр хуралддаг асуудал үүсдэг байна.

Шигтгээ 11.

Миний бие “Ж” ХХК-ийн 50 хувийн хувьцаа эзэмшигч юм. Манай компанийн хувьцаа эзэмшигч нар 2003 оноос маргалдаж эхэлсэн бөгөөд компанийн дүрмийг шинэчлэх, гүйцэтгэх захирлыг сонгох зэрэг асуудлыг шийдвэрлэхээр хувьцаа эзэмшигчдийн хурал зарладаг ч шийдвэр гаргаж чадахгүй өнөөдрийг хүрлээ. Үүнээс болж компанийн бүх үйл ажиллагаа зогсож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг удаа дараа зарлах л ажил хийж байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлахад 2 тал оролцвол хурлын ирц хүрсэн ч Компанийн тухай хуулийн дагуу хэлэлцэх асуудал нь олонхийн санал авч чадахгүй учраас амжилтгүй болдог. Харин хувьцаа эзэмшигчдийн хуралд нэг тал л оролцвол баярлаж, хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарладаг.

Эцэст нь дээрх хуулийн зохицуулалтыг талууд аль аль нь мэддэг болсон тул сүүлийн үед зарласан бүх хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр

гарахгүйгээр дуусч, компанийн үйл ажиллагаа гацаанд орсон байгаа.

Үүнээс болж компанийн үйл ажиллагаа бүхэн зогсож, орлогогүй болох бөгөөд хэд хэдэн маргаануудыг шүүхэд л хандаж шийдвэрлүүлэхэд хүрдэг болохыг нэмж хэлмээр байна.

“Ж” ХХК-ийн 50 хувийн хувьцаа эзэмшигч иргэн А-тай хийсэн ярилцлагаас

8. Фидуцийн харилцаанд

Фидуцийн гэрээний хувьд үүрэг хүлээгч нь мөнгө төлөх үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, үүрэг хүлээгч үндсэн үүргээ хугацаанд гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч уг эд хөрөнгийг түүнд буцаан өгөх үүргийг тус тус хүлээдэг харилцаа юм. Энэхүү гэрээг Банк, банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд түгээмэл хэрэгжүүлдэг.

Гэвч дээрх хуулийн этгээдүүд нь зээлдэгчидэд зээл олгохдоо зээлдэгчийн хөдлөх эд хөрөнгийг хэт бага үнээр үнэлж, өмчлөх эрхийг шилжүүлэн авч байгаа тохиолдлууд нилээд их байгаа юм⁶³. Мөн фидуцийн гэрээгээр тохиролцсон өмчлөлд нь шилжүүлсэн үнээс бага үнээр хөдлөх хөрөнгийг гуравдагч этгээдэд шилжүүлсэн тохиолдол байна⁶⁴. Үүнээс харахад банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага нь иргэд, байгууллагын эд хөрөнгийг хэт бага үнээр үнэлэн өөрийн өмчлөлд шилжүүлэн зээл олгож байгааг иргэд, байгууллага нь байдаг л зүйл мэт хүлээж авдаг болсон байна. Хэт өндөр үнэ тогтоох, эсхүл фидуцийн гэрээгээр тохиролцсон үнээс доогуур үнээр дуудлага худалдаанд оролцуулалгүй худалдах, үүрэг хүлээгчийн зөвшөөрлийг авалгүйгээр бусад этгээдэд бага үнээр худалдаж, үүрэг хүлээгчийг алдагдалд оруулж байна.

Шигтгээ 12.

Нэхэмжлэгч Д.Т нэхэмжлэлийн шаардлагадаа: “2013 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр зээлийн гэрээг байгуулж, 20.000.000 төгрөгийг 6 сарын хугацаатай, сарын 6.5 хувийн хүүтэй, зээлж, зээлийн барьцаанд Ренж ровер маркын жип ангиллын улсын дугаартай автомашинаа барьцаалж, унаад явах нөхцөлтэйгээр гэрээ байгуулан, машиныг барьцаалагчийн нэр дээр шилжүүлсэн. Гэтэл Ю.Б.К.К ББСБ ХХК-ийн захирал Д.Р нь автомашиныг Сүхбаатар дүүрэг, 11-р хороолол, 10 дугаар байрны хажууд байхад байрны гаднаас ирж шууд булаагаад аваад явсан.

Гүйцэтгэх захирал Д.Р-той уулзах гэсэн боловч утсаа огт авахгүй, ор сураггүй

⁶³. Монгол Улсын дээд шүүхийн 2017-12-26-ны өдрийн 8 дугаар тогтоол <http://new.shuukh.mn/irgenhyanalt/3379/view>, Монгол Улсын дээд шүүхийн 2017-12-05-ны өдрийн 1540 дугаар тогтоол <http://new.shuukh.mn/irgenhyanalt/3486/view>

⁶⁴. Монгол Улсын дээд шүүхийн 2018-02-22-ны өдрийн 284 дугаар тогтоол <http://new.shuukh.mn/irgenhyanalt/3920/view>

алга болсон. Д.Т би Америкийн нэгдсэн улсаас уг машиныг 2010 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр татвар, даатгал ороод 43.889 ам.доллараар худалдан авсан. Би өөрөө уг машиныг АНУ-д унаж байгаад 2011 оны 11 дүгээр сарын 20-нд Монгол руу ачуулаад 2012 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Монголд буусан. АНУ-аас Монгол руу ачуулахдаа автомашинд заавал хийгдэх ёстой байдаг үйлчилгээг 6.696,80 ам.доллараар хийлгүүлсэн. Ю.Б.К.К ББСБ ХХК нь надад зээлийн гэрээний улмаас 103.703.036 төгрөгийн хохирол учруулсан. Энэ хохирлыг гаргуулж өгнө үү”⁶⁵ хэмээн нэхэмжлэлийн шаардлагаа тодорхойлсон байна.

Монгол улсын Дээд шүүхийн 2017-12-05-ны өдрийн 01540 дугаар шүүхийн тогтоолын хэсгээс

9.Гэрээний харилцаанд

Талууд гэрээг чөлөөтэй байгуулах эрх зөрчигдөж байгаа тухай

... Зарим нэг байгууллага зах зээлийн давамгайл байдлаа ашиглан өөрийн боловсруулсан гэрээний төслийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд гэрээ байгуулна гэсэн шаардлага тавьдаг байна. Аргагүй эрхэнд гэрээг нь хүлээн зөвшөөрч гэрээ хийх тохиолдол түгээмэл байдаг. Гэтэл Иргэний хуульд “гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй”, “Зах зээлд давамгайлж байгаа этгээд нөгөө талдаа тэгш бус нөхцөл тулган санал тавих буюу гэрээ байгуулахаас татгалзах эрхгүй” гэж тус тус заасан байдаг. Энэ нь бодит байдал дээр хэрэгждэггүй бөгөөд гэрээ байгуулагдсаны дараа талуудын хооронд маргаан үүсэхэд гэрээг боловсруулсан талд ашигтай шийдвэр гарах тохиолдлууд практикт их байна.

Шигтгээ 13.

Банк, банк бус санхүүгийн байгууллага, үүрэн телефоны оператрууд зэрэг байгууллагууд нь өөрсдийн бэлтгэсэн гэрээний төслийг үйлчлүүлэгчид шууд санал болгодог. Жишээлбэл, Би “А” ББСБ-аас зээл авахаар очиход Зээлийн гэрээг уншиж танилцаад зөвшөөрч байгаа тохиолдолд гарын үсэг зурна гэсэн. Зээлийн эдийн засагч нь тус гэрээний зүйл заалттай санал та нийлэхгүй байх, өөрийн зүгээс гэрээнд өөр зохицуулалт оруулах ямар ч боломжгүй гэж хэлсэн. Ихэнх тохиолдолд хүмүүс гэрээний төсөлтэй бүрэн гүйцэд танилцалгүй гарын үсэг зурдаг. Энэ нь хожим талуудын хооронд маргаан гарахад үйлчлүүлэгч талд их хохирол учруулдаг. Энэ асуудлыг хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай гэж бодож байна.

“СТР” ХХК-ийн ахлах хянагчтай хийсэн ярилцлагаас

Гэрээний талуудын байнгын тогтмол харилцаа

⁶⁵. Монгол улсын Дээд шүүхийн 2017-12-05-ны өдрийн 01540 дугаар шүүхийн тогтоол <http://new.shuukh.mn/irgenhyanalt/3486/view>

Зээл авах болон бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, бөөнөөр худалдан авах зэрэг харилцаанд талууд байнгын тогтмол харилцсаар итгэлцэл бий болж, тухайн тохиолдол бүрт тусдаа гэрээ байгуулахгүйгээр өгч, авалцдаг практик түгээмэл байна.

Шигтгээ 14.

Манай компанийн хувьд гоо сайхны бараа бүтээгдэхүүн нийлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ба борлуулагч нартайгаа байнгын харилцсаар сүүлдээ гэрээ байгуулалгүй бараа бүтээгдэхүүн хүлээлгэн өгөх тохиолдлууд байдаг. Энэ тохиолдолд маргаан гарвал шүүх ихэнх тохиолдолд заавал бичгээр байгуулсан гэрээг үндэслэн шийдвэрээ гаргадаг. Иймд байнгын харилцаатай түншүүдийн харилцааг хүлээн зөвшөөрсөн хуулийн зохицуулалт бий болговол бизнесийн үйл ажиллагааны түргэн шуурхай байдалд эерэг нөлөө үзүүлнэ.

“СМГ” ХХК-ийн ерөнхий менежертэй хийсэн ярилцлагаас

- Зарим үнэ цэнэ бүхий хөрөнгө (үл хөдлөх эд хөрөнгө, газар, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл)-ийг шилжүүлэхдээ хэд хэдэн төрлийн хэлцэл хийхийн зэрэгцээ үнийн дүнг бодит тохиролцооноос бууруулан хэлцэлд тусгадаг практик байна. Жишээ нь: Үл хөдлөх эд хөрөнгө худалдан худалдан авах харилцаанд худалдах худалдан авах гэрээ хийхийн зэрэгцээ бэлэглэлийн гэрээ хийж, түүнийгээ улсын бүртгэлд бүртгүүлж байна.
- Бөөний худалдаа эрхэлдэг зарим компаниуд борлуулагчийн үйл ажиллагааны эрсдлээс өөрийгөө хамгаалахын тулд түүний өмчлөл, эзэмшлийн хөрөнгө (орон сууц, хашаа байшин, машин гэх мэт)-ийг барьцаалдаг, компанийн нэр заасан этгээдэд шилжүүлдэг практик байна.

Шигтгээ 15.

Би “Ц” компанид борлуулагчаар 2017 оноос ажиллаж байгаа юм. Компанийн зүгээс надтай хөлсөөр ажиллах гэрээ байгуулж, мөн миний эзэмшлийн хашаа байшинг барьцаалж барьцааны гэрээ байгуулсан. Бараа бүтээгдэхүүний төлбөр тооцоог дутаах, төлөхгүй байх тохиолдолд миний хашаа байшинг худалдан борлуулж, өр төлбөрийг барагдуулна гэж надад тайлбарласан.

“Ц” ХХК-ийн борлуулагчтай хийсэн ярилцлагаас

10.Бизнесийг шилжүүлэхтэй холбоотой харилцаанд

Зарим бизнес эрхлэгч нь нийлүүлэгч, зуучлагчдын нийлүүлж буй бараа, бүтээгдэхүүний борлуулалтын тооцоо, эргэлт, ашгийн тухай мэдээлэлдээ үндэслэн үйлдвэрлэгч болон нийлүүлэгчтэй шууд харилцан замаар харилцагчийн бизнесийг өөрийн болгож, түүнийг уг бизнесийн харилцаанаас шахан гаргадаг практикт байна.

Шигтгээ 16.

Манай компани БНСУ-ын “А” компанитай дистрибьютерийн гэрээ байгуулж, гэр ахуйн цэвэрлэгээний бараа бүтээгдэхүүн борлуулдаг. Гэтэл нэг үйлчлүүлэгч биднээс бараа бүтээгдэхүүн худалдан авдаг байсан “К” ХХК нь БНСУ-ын “А” компанитай шууд харилцан бараа бүтээгдэхүүн оруулж ирдэг болсон. Мөн манай компанийн нилээдгүй хэдэн үйлчлүүлэгчийг өөрийн болгосон.

“ХОМ” ХХК-ийн борлуулалтын албаны ахлах менежертэй хийсэн ярилцлагаас

11. Үүрэн телефоны сүлжээгээр дамжуулан хэлцэл байгуулах

Үүрэн телефоны сүлжээний оператор компаниуд нь өөрсдийн тусгай дугаараар дамжуулан үйлчилгээ, бүтээгдэхүүн санал болгож, хэлцэл хийж байгаа практик түгээмэл байна. Тухайлбал, дата багц худалдан авах, нэгж шилжүүлэх, худалдан авах зэрэг болно.

12. Цахим орчин дахь арилжааны харилцаанд

- Цахим орчин (вэбсайт, фэйсбүүк/Facebook/, вайбер /viber/, вичат /we chat/, гэх мэт) ашиглан зээл, худалдах худалдан авах, зуучлал, зар сурталчилгааны зэрэг гэрээний гол нөхцлийг тохиролцож байна. Тухайлбал, банк санхүүгийн байгууллага цахим хуудас ашиглан зээл олгохдоо зээлийн гэрээнд талууд гарын үсэг зурахаас бусад тохиролцоог хийж байна.

- Цахим орчинд худалдан авалт хийж байгаа нөхцөлд бараа, бүтээгдэхүүний чанар шаардлага хангахгүй, тоо хэмжээ нь хүрэхгүй байх тохиолдол цөөнгүй байна.

13. Газрын харилцаанд

- Газрын өмчлөгч өөрийн өмчлөлийн газар дээр нийтийн зориулалттай орон сууц барьж, худалдаж байгаа тохиолдол нилээдгүй байна. Энэ тохиолдолд орон сууцны доорх болон орчны газар иргэний өмчлөлд, орон сууц нь оршин суугчдын өмчлөлд байгаа болно.

- Дахин төлөвлөлттэй холбоотой харилцаанд иргэний өмчлөх эрхтэй газрыг дахин төлөвлөлт хэрэгжүүлж байгаа компани шилжүүлэн авах хууль тогтоомжоор тогтоосон журам байхгүйн улмаас тухайн компанийн итгэл хүлээсэн хувь хүний нэр дээр газрын өмчлөх эрхийг шилжүүлэн авдаг практик хэдийн тогтсон байна.

- Хууль тогтоомжоор газар эзэмших эрхийг үнэлж, худалдахтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулаагүй, шүүхийн практик тогтоогүй байна. Үүний улмаас газар эзэмших эрх шилжүүлэх гэрээнд үнэ төлбөрийн талаар тусгахгүйгээр байгуулж байна. Харин бодит байдал дээр газар эзэмших эрхийг үнэ тогтоож худалддаг практик хэдийн тогтсон.

Шигтгээ 17 .

2020 оны 5 дугаар сар 15-ны өдрийн байдлаар “Unegui.mn” вэбсайтад “газар зарна” гэсэн 2586 зар байна.

“Unegui.mn” вэбсайтаас

13. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал

Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал (COVID-19)-аас улмаас нийтийг хамарсан хорио цээрийн үед гэрээний талууд үүргээ биелүүлж чадахгүй байх нөхцөл үүсч байна. Ийм нөхцөлд Иргэний хуульд тодорхой зохицуулалт байхгүйн улмаас гэрээний аль нэг талын шаардлага, хүсэл зоригт үндэслэн тухайн асуудалд хандаж байна.

14. Төлбөр тооцооны харилцаанд

- Худалдааны салбарт бараа бүтээгдэхүүний худалдан авалтыг урьдчилан баталгаажуулсан карт, талон зэргийг олгодог практик тогтсон байна. Тухайлбал, шатахууны карт, хүнсний дэлгүүрээс бараа худалдан авах эрхийн карт гэх мэт.

- Мөн банкны зарим карт, гишүүнчлэлийн карт ашигласан тохиолдолд тухайн бараа бүтээгдэхүүний үнийн дүнг тодорхой хувиар бууруулж байна.

- Бүтээгдэхүүн үйлчилгээ худалдан авсны хариуд урамшууллын оноо өгч, түүгээрээ худалдан авалт хийх замаар төлбөр тооцооны хэрэгсэл болгодог практик тогтсон байна. Тухайлбал, Мобикомын sandy, Юнителийн u-point гэх мэт.

Гэрээний үнийн дүнд татварыг оруулан тооцож, тухайн үнийн дүнгээс татварын суутган тооцож байна.

Шигтгээ 18.

Гэрээний талууд гэрээний үнэ, ажлын хөлс, бараа бүтээгдэхүүний үнэлгээ зэрэгт “татвар⁶⁶ орсон болно” хэмээн тодорхойлсоноор тухайн гэрээний үнэ, ажлын хөлс, бараа бүтээгдэхүүний үнэлгээ зэрэгт албан татварыг оруулан тооцох тохиолдлууд цөөнгүй байна. Энэ нь гэрээний төлбөр хүлээн авагч хууль тогтоомжид заасан татварыг гэрээнд заасан үнээс суутган тооцож байна.

“ББ”ХХК-ийн захиралтай хийсэн ярилцлагаас

⁶⁶ “Татвар” гэдгийг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу төлөгдөх бүхий л албан татвар, хураамж, төлбөр, шимтгэл болон эдгээртэй адилтгах бүх төрлийн суутгалыг ойлгохоор тодорхойлсон байна.

15. Өрсөлдөгч, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад шилжин ажиллах тухай

Тухайн байгууллагын удирдах албан тушаалтан эсхүл бизнесийн нууц, нууц мэдээлэл, ноу-хауг мэдэх ажилтан өрсөлдөгч аж ахуйн нэгжид ажиллах, адил төрлийн бизнес эрхлэхийг түүнтэй байгуулсан гэрээ, хэлцэлд хориглосон зохицуулалт оруулдаг ч хэрэгждэггүй практик байна.

Шигтгээ 19.

Томоохон компаний удирдах албан тушаалтнаар ажиллаж байсан хүн адил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг хэд хэдэн компанид дамжин ажиллаж байгаа бодит жишээ байна. Энэ нь бизнесийн муу дуурайлал болж, халдвар нь бусад салбарт дамжиж байна.

Манай салбарт гэхэд л ахлах тогоочоор ажилладаг хүмүүс бидний хоолны жор, орц найрлага үйлчлүүлэгчийн сонголт, хоолны цэсний төлөвлөлт зэрэг байгууллагын нууцад хамаарах мэдээллийг мэдсэнийхээ дараа ажлаас гарч, тусдаа ресторан нээж эсхүл өөр ресторанд дамжин ажиллаж байна.

“У” рестораны захирал “Ч”-тэй хийсэн ярилцлагаас

16. Даатгалын харилцаанд

Даатгалын компаниуд даатгуулагчид учирсан бодит хохирлыг барагдуулахгүй тохиолдлууд байна.

Шигтгээ 20.

Автомашины ослын улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан эдийн хохирлыг гүйцэд арилахгүй байгаа нь ажиглагдаж байна. Тодруулбал, Автомашины ослын улмаас буруутай жолооч нь Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээн торгуулийн шийтгэл хүлээдэг ч нөгөө талдаа болон өөрт учирсан хохирлоо Даатгалын компаниар төлүүлэхэд бодит хохирлыг төлөхгүй зөвхөн мэргэжлийн үнэлгээний компанийн үнэлгээг үндэслэн хохирлыг барагдуулж байна.

“Т” ХХК-ийн захирал “ПР”-тэй хийсэн ярилцлагаас

6.2. Дүн шинжилгээ

Манай улсад бизнес эрхлэгчдийн хоорондын харилцаанд дараах практикууд байна. Тухайлбал,

- Үл хөдлөх эд хөрөнгийн зарим хэсгийг түрээслэх харилцаанд түрээсийн гэрээг улсын бүртгэлд бүртгүүлээгүй нь тус гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй байна;

- Бизнесийн тогтмол харилцаатай түншүүдийг хувьд гэрээг заавал бичгээр байгуулахгүйгээр итгэлцэлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулж байна;
- Үүрэн телефоны сүлжээний оператор компаниуд нь өөрсдийн тусгай дугаараар дамжуулан үйлчилгээ, бүтээгдэхүүн санал болгож, хэлцэл хийж байна;
- Иргэд, хувиараа бизнес эрхлэгчдийн хооронд “Өдрийн зээл” гэх 10-40 хувийн хүүтэй зээлийн харилцаа байна;
- Барьцаалан зээлдүүлэх газар буюу ломбард нь зээлдэгчийн барьцааны хөрөнгөөр үүргийг хангах тухай бичгээр мэдэгддэггүй, ийнхүү мэдэгдсэнээс хойш 10 хоногийн дотор зээлдэгч үүргээ гүйцэтгээгүй бол барьцааны зүйлийг комиссийн буюу дуудлага худалдаагаар худалдаж, борлуулсан дүнгээс үлдсэн мөнгийг буцаан олгодоггүй, тухайн барьцааны зүйлийн худалдсан үнэ нь тодорхой бус болдог практик байна;
- Банк, санхүүгийн байгууллага зээлийн барьцаа хөрөнгийг зах зээлийн бодит үнэлгээнээс хэт доогуур үнэлдэг байна;
- Орон сууцны талбайн зөрүүтэй холбоотой маргаанд талбайн хэмжээ дутуу, доголдолыг худалдан авагч мэдэх боломжтой гэж үзэн шийдвэрлэдэг шүүхийн практик тогтсон байна. Үүний улмаас орон сууц худалдан авагч хохирч барилгын компани үндэслэлгүй хөрөнгөжиж байна;
- Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болоход ажил, үүргээ хүлээлгэн өгөхгүй, компанийн хэвийн үйл ажиллагаанд санаатайгаар саад учруулж, тухайн компани төдийгүй хувьцаа эзэмшигчдийг хохироож байна;
- Компанийн хувьцааг тэнцүү (50:50) хэмжээгээр эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэхэд хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц хүрэхгүй байх, хурлын ирц бүрдсэн ч санал хураахад хувьцаа эзэмшигчдийн олонхийн санал авч чадахгүй байх, хэлэлцсэн асуудлаар тодорхой шийдэлд хүрэхгүй байх зэргээр компанийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулж байна;
- Фидуцийн харилцаанд зээл олгохдоо зээлдэгчийн хөдлөх эд хөрөнгийг хэт бага үнээр үнэлэх, үүрэг хүлээгчийн зөвшөөрлийг авалгүйгээр дуудлага худалдаанд оролцуулалгүй хэт бага үнээр гуравдагч этгээдэд худалдаж байна;
- Зарим бизнес эрхлэгчид зах зээлийн давамгайл байдлаа ашиглан өөрт ашигтай, нөгөө талд хэт хохиролтой гэрээний төслийг санал болгож, аргагүй байдалд оруулан гэрээ байгуулсаар байна;
- Зарим бизнес эрхлэгч нь харилцагчийнхаа борлуулалтын тооцоо, эргэлт, ашгийн тухай мэдээлэлд үндэслэн үйлдвэрлэгч болон нийлүүлэгчтэй шууд харилцах замаар тухайн бизнесийг өөрийн болгодог байна;
- Цахим орчинд худалдан авалт хийхэд бараа, бүтээгдэхүүн чанарын шаардлага хангахгүй, тоо хэмжээ нь хүрэхгүй байх доголдлууд түгээмэл байна;
- Дахин төлөвлөлттэй холбоотой харилцаанд иргэний өмчлөх эрхтэй газрыг тухайн компанид шилжүүлэх хууль тогтоомжийн зохицуулалтгүй тул компанийн нэрлэсэн хүний өмчлөлд газрын өмчлөх эрхийг шилжүүлж байна;

- Хууль тогтоомжоор газар эзэмших эрхийг үнэлж, худалдахтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулаагүйгээс бодит байдалд газар эзэмших эрхийг үнэ тогтоож худалдаж байна;
- Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал (COVID-19)-ын үед гэрээний үүрэг биелүүлэхтэй холбоотой тодорхой зохицуулалт Иргэний хуульд байхгүйн улмаас талууд хүссэн нөхцөл, шаардлагаа санал болгож, асуудлыг шийдвэрлэхэд хүндрэл үүсгэж байна;
- Удирдах албан тушаалтан эсхүл бизнесийн нууц, нууц мэдээлэл, ноу-хауг мэдэх ажилтан өрсөлдөгч аж ахуйн нэгжид ажиллах, адил төрлийн бизнес эрхлэхийг түүнтэй байгуулсан гэрээ, хэлцэлд хориглосон зохицуулалт тусгадаг ч энэ нь бодит байдалд хэрэгждэггүй байна;
- Зарим банк цалингийн зээл олгохдоо зээлдэгчийн цалингийн орлогыг барьцаалахаас гадна тухайн гэр бүл, өрхийн эд хөрөнгийг давхар барьцаалж байна;
- Бизнес эрхлэгчдийн гэрээ, хэлцлийн харилцаанд цахим гарын үсэг хэрэглэгдэхгүй харин төр (татвар, санхүүгийн тайлан гэх мэт)-тэй харилцах харилцаанд “Цахим гарын үсгийн тухай хууль” үйлчилж байна;
- Гар утасны дугаар барьцаалан зээл олгохдоо тухайн дугаарыг банк бус санхүүгийн байгууллага өөрийн нэр дээр шилжүүлэн авч байгаа зэрэг практикууд хэдийн тогтсон байна.

Арилжааны орчинд талууд байнга тогтмол харилцсанаар итгэлцэл бий болж, тухайн тохиолдол бүрт гэрээ байгуулахгүйгээр үүргээ биелүүлдэг практик нэгэнт тогтсон байх тул энэ талаарх харилцааг хүлээн зөвшөөрсөн тодорхой зохицуулалт шаардлагатай байна.

Түүнчлэн зээл авах; хөрөнгө барьцаалан зээл олгох; барьцаа хөрөнгийн үнэлгээ тогтоох; үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах; фидуци, барьцаа, гэрээ хэлцлийн харилцаа; компанийн хувьцаа эзэмшигчдийн хоорондын болон бизнесийн үйл ажиллагааг шилжүүлэх; компанийн эрх бүхий албан тушаалтан ажил, үүргээ дүгнэх, хүлээлгэн өгөх; өрсөлдөгч байгууллагад шилжин ажиллах; газрын эрхийн асуудал; цахим болон төлбөр тооцооны харилцаа, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал зэрэгт хууль тогтоомжийн нарийвчилсан зохицуулалт байхгүй, зарим харилцаанд зохицуулалт байгаа хэдий ч бодит байдалд хэрэгждэггүйн улмаас буруу практикууд тогтсон байна.

Иймд арилжааны орчинд тогтсон нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш практикийг хууль тогтоомжийн зохицуулалтаар зөвтгөх, бизнес эрхлэгчдийн хооронд нэгэнт тогтсон зарим харилцааг хуулиар хүлээн зөвшөөрөх; бизнесийн харилцаа болон техник технологийн хөгжлийн уялдааг хангах зохицуулалт бий болгох шаардлага нэгэнт үүсчээ.

ДОЛОО. ДҮГНЭЛТ, САНАЛ

Арилжааны орчинд тогтсон практик, заншлыг нээн илрүүлэх судалгааг ярилцлага, баримт бичиг судлах, ажиглалтын аргаар мэдээлэл цуглуулж дараах дүгнэлтийг гаргалаа.

Бичмэл эрх зүйн эх сурвалж жишээлбэл, Монгол Улсын олон улсын гэрээ, Иргэний хуульд тодорхой зохицуулалт тусгах замаар заншлыг эрх зүйн эх сурвалж хэмээн хүлээн зөвшөөрч байна. Монголын эрх зүйд заншил нь гагцхүү хуульд тухайлан дурдагдсан үед эрх зүйн ач холбогдолтой мэт ойлгогдож байна. Шүүх, арбитр нь хуульд заншлыг эрх зүйн эх сурвалж хэмээн заасан, эсхүл заншлыг харгалзан гэх мэтээр шууд заасан үед заншил байгаа эсэхэд дүгнэлт өгч, тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэж байгаа практик ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, бичмэл эх сурвалж (хууль)-д бичмэл бус эх сурвалж (заншил)-ийг дурдах байдлаар заншлыг эрх зүйн хувьд ач холбогдолтой гэж үзэх байдал, хандлага байна. Мөн Монгол Улсын хувийн эрх зүйд ажил хэргийн хүрээнд тогтсон заншил болон тогтсон практикийг тус тусад нь авч үзсэн байх хэдий ч эдгээрийг хэрхэн ялгаж ойлгох, тайлбарлан хэрэглэх талаар нэгдсэн ойлголт бий болоогүй байна гэж дүгнэж болохоор байна.

Монголын бизнесийн орчинд арилжаа эрхлэгчид мөрддөг арилжааны заншил (Инкотермст туссан зэрэг) тодорхой хэмжээгээр үйлчилж байгаа гэж дүгнэж болох ба энэ хүрээнд эдгээр заншил нь эрх зүйн хувьд ямар ач холбогдолтой (эрх зүйн эх сурвалжийн эрэмбэ г.м.) болох нь асуудлын гол болж байна.

Мөн Монгол Улс дахь арилжааны орчинд тогтсон практик байна гэж дүгнэж болохуйц байгаа ба эдгээрийг бусад ойролцоо эрх зүйн ойлголтуудаас тухайлан ялгаж салгаж байх нь зүйтэй байна. Тогтсон практик нь урт хугацаанд хамтран ажиллаж байгаа этгээдүүдийн хооронд, эсхүл үйл ажиллагааны тодорхой салбар, хэсэгт илүүтэй ажиглагдаж байна.

Арилжааны заншил, тогтсон практик нь зарим тохиолдолд хуульд нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш байх бололцоотой нь гадаадын улс орнуудын жишээ, энэ судалгааны хүрээнд олж цуглуулсан баримтаас харагдаж байгаа бөгөөд Монголын арилжааны орчинд арилжаа, ажил хэргийн хүрээнд зарим эргэлзээтэй практик (жишээлбэл, өдрийн зээл) тогтож байгаа, эсхүл тогтсон байна. Үүнийг шүүх, арбитрт тодорхой маргаан шийдвэрлэх хүрээнд авч үзэж болох хэдий ч хууль зүйн бодлогын хувьд бодлого боловсруулагчид анхаарах, дүгнэлт өгөх, шаардлагатай бол хуулиар зохицуулах хэрэгтэй байна.

Монгол Улсын шүүх, арбитр нь арилжааны заншил, тогтсон практикийг хэрэглэж маргаан шийдсэн тохиолдол төдийлөн түгээмэл биш хэдий ч арилжааны заншил, тогтсон практикийг шүүх, арбитр харгалзан үзэж, эсхүл үндэслэл болгон тодорхой маргааныг шийдвэрлэх явдал Монголын эрх зүйн тогтолцоо, шүүх, арбитрын практик (2013-2019 оны шүүхийн шийдвэр, 2006-2019 оны арбитрын шийдвэр (МҮХАҮТ-ын дэргэдэх арбитр))-т байна. Өөрөөр хэлбэл, заншил, тогтсон практикийг шүүх, арбитр нь огт хэрэглэдэггүй гэж дүгнэх боломжгүй юм.

Шүүх хэрэг маргааны шийдвэрлэхдээ арилжаа эрхлэгчдийн хооронд тогтсон практик уу, заншил уу гэдэгт ач холбогдол өгөлгүйгээр хэргийг шийдвэрлэх

хандлага байна. Харин арилжааны заншил, тогтсон практикийг хэрэглэх, шийдвэрээ үндэслэх хүрээний хувьд шүүх, арбитр тодорхой үйл баримтыг үнэлэхдээ заншил, тогтсон практикийг хэрэглэх байдлаар хязгаарлагдаж байгаа нь ажиглагдаж байна. Мөн цөөнгүй тохиолдолд хэргийн зохигчид, талууд нэхэмжлэл, тайлбартаа талуудын хооронд арилжааны заншил, тогтсон практик байгаа талаар тайлбарладаг байна.

Гадаадын олон улсын жишээг авч үзвэл заншил, тогтсон практикийг бусад бичмэл эрх зүйн эх сурвалжтай харьцуулахад шүүх, арбитр нь бага хэрэглэдэг жишиг байдгийг анхаарах нь зүйтэй байна. Энэ нь парламентаас батлагдсан хуулиар эрх зүйн харилцааг бүхэлд нь зохицуулах 19 дүгээр зууны Европт дэлгэрсэн хандлагаас үүдэлтэй хэдий ч бүх харилцааг хуулиар зохицуулах бодит боломжгүй байдаг, тэрхүү орон зайг заншил болон бусад эх сурвалж нөхөн зохицуулдаг, заншил нь “бодит амьдрал”-аас үүсэж гардаг учир олон тохиолдолд шударга ёсонд нийцдэг, илүү “ард түмний” буюу “ардчилсан” шинжтэй байдагтай холбоотой. Иймд олон улсын бизнесийн практикийг харгалзаж, гадаадын олон улсын эрх зүйн тогтолцоог судалбал арилжааны заншил нь анхаарал хандуулах ёстой эрх зүйн эх сурвалж, арилжааны хүрээнд тогтсон практик нь харгалзан үзэх хүчин зүйл мөн байна.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд цуглуулсан мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ, дүгнэлтэд үндэслэн дараах саналыг гаргаж байна. Үүнд:

1. Арилжааны хуулийн төслийг боловсруулахдаа арилжааны заншлыг эрх зүйн эх сурвалжийн хэмжээнд, арилжаа эрхлэгчдийн дунд тогтсон практикийг гэрээг тайлбарлах, үйл баримтыг үнэлэхэд харгалзан үзэх шалгуур болгон авч үзэх нь зүйтэй байна.
2. Арилжааны бие даасан хууль (Commercial Code)-ийн төсөл боловсруулагдан, улмаар батлагдахын тулд арилжааны заншил нь Иргэний хуулиас давуу эрэмбэтэй эрх зүйн эх сурвалж байх эсэхэд дүгнэлт өгөх шаардлагатай.
3. Хууль тогтоогч, бодлого боловсруулагчид Монголын арилжааны орчинд үүсээд байгаа нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш байж болох зарим заншил, тогтсон практик, худалдааны аргыг хориглох, хязгаарлах, зохицуулах шаардлага бий болсон бөгөөд үүнийг эрх зүйн хэм хэмжээг шинээр батлах, эсхүл өөрчлөх, холбогдох төрийн болон бусад институтийн тусламжтайгаар арилжаа эрхлэгчдийн зан үйлд нөлөөлөх арга хэмжээ авах арга замыг тодорхойлох шаардлагатай байна. Ингэхдээ анхаарах чухал хүчин зүйл нь арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааны үндэс болдог чөлөөт байдлын зарчимд халдахгүй байхыг онцгойлон анхаарах нь зүйтэй.
4. Монголын эрх зүйн тогтолцоо нь нэгдмэл байх шалгуурыг үндэс болговол заншил, практиктай холбоотой хууль тогтоомжийн нэр томъёоны оноолтын нэг мөр байдлыг анхаарах, жигдрүүлэх шаардлагатай байна.
5. Арилжааны хүрээнд тогтсон практик, арилжааны арга нь байнга шинэчлэгдэж байдаг тул шүүх, арбитрт үүссэн маргааныг шийдвэрлэсэн шийдвэр, арилжааны практикийг тодорхой давтамжтайгаар тусгайлан судалж байх, шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээ тогтоох, нэг

бүрчилсэн зохицуулалт хийх бодлогын арга хэмжээ авч байх нь зүйтэй байна.

6. Арилжааны заншил, заншлын эрх зүйн хэм хэмжээ, тогтсон практикийн талаарх арбитр, иргэний шүүх, арбитрч, шүүгчдэд мэдээлэл өгөх, шүүх, арбитр нь судалгаа хийж байх нь маргаан шийдвэрлэхэд дөхөм байхыг үгүйсгэхгүй болно.

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

1. **Хавсралт 1.** БНМАУ-ын Худалдааны тухай хууль
2. **Хавсралт 2.** Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 10 сарын 15-ны өдрийн 6367 дугаартай шийдвэр
3. **Хавсралт 3.** Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 07 сарын 08-ны өдрийн 181/ШШ2016/00328 дугаартай шийдвэр
4. **Хавсралт 4.** Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 06 сарын 30-ны өдрийн 181/ШШ2016/00233 дугаартай шийдвэр
5. **Хавсралт 5.** Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 07 сарын 24-ний өдрийн 01604 дугаартай шийдвэр
6. **Хавсралт 6.** МУ-ын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны 2019 оны 02 сарын 28-ны өдрийн 001/ХТ2019/00284 дүгээр тогтоол
7. **Хавсралт 7.** Өмнөговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 08 сарын 06-ны өдрийн 318 дугаар шийдвэр
8. **Хавсралт 8.** Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 сарын 27-ны өдрийн 181/ШШ2018/02447 дугаар шийдвэр
9. **Хавсралт 9.** Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 06 сарын 26-ны өдрийн 102/ШШ2018/02087 дугаар шийдвэр
10. **Хавсралт 10.** Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017-10-17-ны өдрийн 184/ШШ2017/02246 дугаар шийдвэр
11. **Хавсралт 11.** Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018-02-22-ны өдрийн 430 дугаар шийдвэр
12. **Хавсралт 12.** Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 03 сарын 29-ний өдрийн 748 дугаар шийдвэр
13. **Хавсралт 13.** Өмнөговь аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 09 сарын 13-ны өдрийн 257 дугаар шийдвэр
14. **Хавсралт 14.** Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 06 сарын 13-ны өдрийн 182/ШШ2018/01266 дугаартай шийдвэр
15. **Хавсралт 15.** Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 12 сарын 14-ний өдрийн 343 дугаартай шийдвэр
16. **Хавсралт 16.** Баянгол, Хан-уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 10 сарын 15-ны өдрийн 102/ШШ2015/06367 дугаартай шийдвэр
17. **Хавсралт 17.** Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2015 оны 04 сарын 30-ны өдрийн 2877 дугаар шийдвэр
18. **Хавсралт 18.** Монгол улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2015 оны 06 сарын 30-ны өдрийн 532 дугаартай тогтоол
19. **Хавсралт 19.** Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 04 сарын 08-ны өдрийн 1020 дугаар шийдвэр
20. **Хавсралт 20.** Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018-06-22-ны өдрийн 210/МА2018/01471 дүгээр магадлал

21. **Хавсралт 21.** Монгол улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2018 оны 05 сарын 15-ны өдрийн 001/ХТ2018/00769 дугаартай тогтоол
22. **Хавсралт 22.** Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх хуралдааны 2015 оны 11 сарын 13-ны өдрийн 7717 дугаартай шийдвэр
23. **Хавсралт 23.** МҮХАҮТ-ийн дэргэдэх Монголын олон улсын ба үндэсний арбитрын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 382 дугаар шийдвэр
24. **Хавсралт 24.** МҮХАҮТ-ийн дэргэдэх Монголын олон улсын ба үндэсний арбитрын 2019 оны 10 дугаар сарын 22-ний өдрийн 345 дугаар шийдвэр
25. **Хавсралт 25.** МҮХАҮТ-ийн дэргэдэх Монголын үндэсний арбитрын 2012 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 104 дүгээр шийдвэр
26. **Хавсралт 26.** Заншил ёсоор гэрээг байгуулсанд, хэлцэл хийсэнд тооцох
27. **Хавсралт 27.** “Заншил” гэсэн үг агуулагдсан бусад хууль

ЗАНШИЛ ЁСООР ГЭРЭЭГ БАЙГУУЛСАНД, ХЭЛЦЭЛ ХИЙСЭНД ТООЦОХ

Иргэний хууль /2002/

42 дугаар зүйл. Хэлцлийн хэлбэр

42.3.Ажил хэргийн хүрээнд тогтсон заншлын дагуу техникийн хэрэгслээр шууд хуулбарлан буулгасан гарын үсгийг түүний эхтэй адилтган үзэж болно.

43 дугаар зүйл. Хэлцэл хийсэн гэж үзэх

43.1.Амаар хийх хэлцлийг дараахь тохиолдолд хийсэн гэж үзнэ:

43.1.2.... хэрэглэж заншсан зүйлийг олгосон;

196 дугаар зүйл. Гэрээг байгуулсанд тооцох

196.1.Дараахь үндэслэлээр гэрээг байгуулсанд тооцно:

196.1.7.ажил хэргийн хүрээнд тогтсон заншил ёсоор санал гаргагч талыг хүлээн зөвшөөрнө гэж үзээд санал хүлээн авагч тал нь саналд дурдсанаас өөр нөхцөлөөр гэрээ байгуулахаар хариу илгээсэн тохиолдолд санал гаргагч татгалзсан тухайгаа нэн даруй мэдэгдээгүй;

ГЭРЭЭГ ТАЙЛБАРЛАХАД ЗАНШЛЫГ ХАРГАЛЗАНА

Иргэний хууль /2002/

198 дугаар зүйл. Гэрээг тайлбарлах

198.3.Гэрээний зарим үг хэллэгийг ... өөр өөр агуулгаар тайлбарлаж болохоор байвал ... хэрэглэж заншсан агуулгаар тайлбарлана.

198.6.... талуудын нэгдмэл санааг тодруулах(ийн) тулд ... талуудын хооронд тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзнэ

ЗАНШЛЫГ БАРИМТАЛНА, ЗАНШЛААР ЗОХИЦУУЛНА

Иргэний хууль /2002/

449 дүгээр зүйл. Аккредитив

449.3.Аккредитивийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг баримтална.

450 дугаар зүйл. Инкасс

450.2.Инкассийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд хууль, олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг баримтална.

457 дугаар зүйл. Банкны баталгааны гэрээ

457.17.Энэ хуулиар зохицуулаагүй ... бусад харилцааг олон улсын хэмжээнд хэрэглэдэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлаар зохицуулна.

540 дүгээр зүйл. Гадаад улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх

540.1.Шаардлагатай бол шүүх иргэний хэрэг, маргаан шийдвэрлэх буюу иргэний эрх зүйн бусад харилцааг зохицуулахад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд харшлаагүй гадаад улсын хууль, эрх зүйн

болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээг хэрэглэж болно.

Арбитрын тухай хууль

40 дүгээр зүйл.Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээ

40.5.Арбитрын бүрэлдэхүүн талуудын хооронд байгуулсан гэрээний нөхцөлд үндэслэн тухайн асуудлаар тогтож хэвшсэн худалдааны зан заншлыг харгалзан маргааныг шийдвэрлэнэ.

“Заншил” гэсэн үг агуулагдсан бусад хууль

№	Хуулийн нэр	Холбогдох заалт
1.	Амьтны тухай хууль	21 дүгээр зүйл. Иргэн, нөхөрлөл, амьтан хамгаалах чиглэлийн мэргэжлийн болон төрийн бус байгууллагыг амьтны нөөцийг хамгаалахад оролцуулах 21.5. Амьтны нөөцийг хамгаалах зорилго бүхий төрийн бус байгууллага агнуурын нөөцийг хамгаалах талаар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ: 21.5.4. амьтныг хайрлах ёс зүй, зан заншил, үндэсний уламжлал, хууль тогтоомжийг сурталчлах.
2.	Аялал жуулчлалын тухай хууль	8 дугаар зүйл. Аялал жуулчлалын байгууллагын бүрэн эрх 8.1. Аялал жуулчлалын байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.1.4. Монгол Улсын нийгэм, эдийн засаг, төрийн байгуулалт, түүх соёл, ёс заншил, зан үйлийн талаар жуулчдад үнэн бодит мэдээлэл өгөх; 8.2. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хүн амын эрүүл мэнд, уламжлалт зан заншилд харшлахгүй аялал жуулчлалын хэлбэрийг хөгжүүлнэ. 13 дугаар зүйл. Хөтөч-тайлбарлагчийн эрх, үүрэг 13.1. Хөтөч-тайлбарлагч нь дараах эрх, үүрэгтэй. 13.1.3. Монгол Улсын нийгэм эдийн засаг, төрийн байгуулал, байгаль, түүх, соёл, ард түмний зан заншлын талаар жуулчдад бодит мэдээлэл өгөх, улс, хувь хүн, байгууллагын нууцад хамаарах мэдээллийн нууцыг задруулахгүй байх;
3.	Бага, дунд боловсролын тухай хууль	4 дүгээр зүйл. Бага боловсролын агуулга 4.1. Бага боловсролын агуулга нь дараахь зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ: 4.1.4. гоо зүй, хүмүүнлэг, үндэсний дэвшилт, ёс заншил, соёлын өв уламжлал, эрүүл ахуйн зохих шатны мэдлэг, чадвар эзэмшүүлэх; 5 дугаар зүйл. Суурь боловсролын агуулга 5.1. Суурь боловсролын агуулга нь дараахь зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ: 5.1.2. гоо зүй, ёс суртахууны соёлтой, эрүүл чийрэг, иргэний үүргээ ухамсарласан, үнэнч шударга, хамтач, энэрэнгүй, эх оронч, хууль ёсыг дээдлэн сахидаг, үндэсний болон хүн төрөлхтний дэвшилт ёс заншил, соёлын үнэт зүйлсийг хүндлэн хайрладаг болгон

		төлөвшүүлэх; 7 дугаар зүйл.Бага, дунд боловсрол эзэмшүүлэх хугацаа 7.5.Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ эзэмшүүлэх хөтөлбөрийг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, батална.
4.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	4 дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг 2.Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ: 2/байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил эзэмшиж хэрэглэх, үр хүүхэддээ экологийн хүмүүжил олгох; 56 дугаар зүйл.Экологийн боловсрол, хүмүүжил 2.Экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг дараахь байдлаар зохион байгуулна: 3/хэвлэл, мэдээллийн хэрэгслээр экологийн мэдлэг, байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил, хууль тогтоомж сурталчлах.
5.	Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль	3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.4.“газар зүйн заалт” гэж тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, эсхүл тухайн газар нутгийн хүмүүсийн дадал заншил зэрэг хүчин зүйлээр тодорхойлогдсон чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанар бүхий бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутгийн газар зүйн тодорхойлолтыг; 5 дугаар зүйл.Барааны тэмдэгт тавих шаардлага 5.2.Дараахь барааны тэмдгийг бүртгэхгүй: 5.2.4.агуулга нь нийгмийн дэг журам, зан суртахуунд харш;
6.	Биеийн тамир, спортын тухай хууль	4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.5.“үндэсний спорт” гэж ард түмний уламжлал, зан заншилд тулгуурлан хөгжсөн үндэсний онцлог шинжийг агуулсан спортыг;
7.	Боловсролын тухай хууль	10 дугаар зүйл.Боловсролын хөтөлбөр, агуулга 10.3.Бүх шатны боловсролын хөтөлбөрт монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний төлөвшил, хөгжил, гэр бүл, хүн

		төрөлхтний нийтлэг үнэт зүйл, суралцагчийн гүйцэтгэх сайн дурын үйл ажиллагааны төрөл, агуулгыг заавал тусгаж, музей, номын сан, кино зэрэг соёл, урлаг, спортын байгууллагын боломжийг ашиглахаар зохион байгуулна 41 дүгээр зүйл.Төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт 41.4.Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, ёс заншил, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлж болох бөгөөд дэмжлэг үзүүлэх нөхцөл, шаардлага, хэмжээг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна.
8.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль	8 дугаар зүйл.Гадаадын иргэнд хориглох зүйл 8.1.Гадаадын иргэнд Монгол Улсын нутаг дэвсгэрт дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 8.1.4.тус улсын үндэсний эв нэгдлийн эсрэг сурталчилгаа явуулах, үндэсний, зан заншилд хохирол учруулж болох хүмүүнлэг бус шашны урсгал, хүчирхийллийн аливаа хэлбэр, садар самуун, мансууруулах бодисыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хэрэглэх;
9.	Гэр бүлийн тухай хууль	26 дугаар зүйл. Хүүхдээ хүмүүжүүлэх эрх, үүрэг 26.2.Эцэг, эх дараахь үүрэг хүлээнэ: 26.2.3.хүүхдээ үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх, түүнд суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадлага олгох;
10.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхийг хориглох 7.3.Хохирогчийг хуульд заасан эрхээ эдлэхэд түүний шашин шүтлэг, соёл, зан заншлын хэм хэмжээтэй холбогдуулан аливаа хязгаарлалт тогтоохыг хориглоно.
11.	Далай ашиглах тухай хууль	21 дүгээр зүйл. Хөлөг онгоцон дээр хүн төрөх, нас барах 21.4.Хөлөг онгоц далайд удаан хугацаагаар аялах болон шарилыг хадгалах боломжгүй байгаа онцгой тохиолдолд ахмад нь зохих баримт бүрдүүлэн шарилыг далайчдын ёс заншлын дагуу далайд оршуулж болно.
12.	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль	6 дугаар зүйл. Залуучуудын эрхэмлэх зүйл 6.1.Залуучууд нийгмийн хөгжил, бүтээн байгуулалтад оролцохдоо дараахь зүйлсийг эрхэмлэнэ: 6.1.1.эх оронч үзлийг эрхэмлэж, ёс заншил, өв уламжлалаа дээдлэх; 12 дугаар зүйл. Аюулгүй амьдрах, хөгжих орчныг бүрдүүлэх 12.3.Залуучуудын өөрийгөө хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үйл

		ажиллагааг дараахь чиглэлээр дэмжинэ: 12.3.3.түүх, соёлын өвийг хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ардын урлаг, ёс заншил, уламжлалт зан үйлийг хөгжүүлэхэд залуучуудын оролцоог хангах;
13.	Захиргааны ерөнхий хууль	48 дугаар зүйл. Хууль бус захиргааны актыг хүчингүй болгох 48.2.Эерэг нөлөөлөл бүхий хууль бус захиргааны актыг дараах тохиолдолд хүчингүй болгоно: 48.2.5.нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан.
14.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	11 дүгээр зүйл. Хууль хэрэглэх 11.7.Шүүх хууль хоорондоо зөрчилтэй болон хууль шударга бус, эсхүл нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш гэсэн үндэслэлээр хуулийн хэм хэмжээг хэрэглэхээс татгалзах эрхгүй.
15.	Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль	8 дугаар зүйл. Зохиогчийн эрхээр үл хамгаалах бүтээл 8.1.Дараахь бүтээлийг зохиогчийн эрхээр хамгаалахгүй: 8.1.7.ардын урлагийн бүтээл, үндэсний зан заншил;
16.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	4.12 дугаар зүйл. Хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийн талаар авах арга хэмжээ 16.Хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийг буцаан олгох нь хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд хортой нөлөө үзүүлэх, нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх бодит үндэслэлтэй, эзэмшигч, өмчлөгч нь тодорхойгүй, эсхүл хуулиар хориглосон, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахаар бол эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 15.2, 15.3 дахь заалтад заасан шийдвэрийг гаргана.
17.	Зөрчлийн тухай хууль	5.1 дүгээр зүйл. Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах 2.Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон газарт архидан согтуурсан, эсхүл ажил, үйлдвэрлэлийн зайлшгүй шаардлагатай нөхцөл, эсхүл заншлын дагуу хэрэглэж байгаагаас бусад тохиолдолд хот, суурин газарт биедээ хутга, эсхүл хүний биед гэмтэл учруулж болох тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл авч явсан бол зэвсэг, хэрэгслийг хурааж хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
18.	Малын генетик нөөцийн тухай хууль	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.5.“уламжлалт мэдлэг” гэж малын генетик нөөцийг ашиглах явцад өвлөгдөн уламжлагдаж ирсэн арга,

		аман болон бичгэн хэлбэрийн мэдээлэл, дадал заншлыг;
19.	Монгол улсын засгийн газрын тухай хууль	9 дүгээр зүйл. Нийгмийн хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хүн амын нийгмийн хамгаалалтын талаархи Засгийн газрын бүрэн эрх 2.Ард түмний оюуны өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, уламжлалт зан заншлыг дэмжин хөгжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
20.	Монгол улсын Их хурлын тухай хууль	20 дугаар зүйл. Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээ 20.3. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо: 20.3.10. монгол хэл, бичиг, үндэстний цөөнхийн хэл, бичиг, ёс заншил.
21.	Монгол хэлний тухай хууль	11 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар 11.1.Монгол Улсын Засгийн газар монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар дараах үүрэг хүлээнэ: 11.1.3.гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэн, түүний гэр бүлд монгол хэл, бичиг үсэг, уламжлалт зан заншил, түүх соёлын мэдлэг эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах; 13 дугаар зүйл. Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 13.1.Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ: 13.1.5.үндэстний цөөнх монгол хэл болон эх хэл дээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;
22.	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль	3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.2.“нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр” гэж түүхэн болон тодорхой үйл явдалтай холбоотой, нийгмийн тодорхой давхаргыг хамарсан, бүх нийтээр тэмдэглэж заншсан өдрийг.
23.	Ойн тухай хууль	20 дугаар зүйл. Иргэний эрх, үүрэг 20.2.Иргэн ойг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ: 20.2.3.ойг хамгаалах үндэсний уламжлал, ёс заншлыг сахиж, хүүхэддээ экологийн хүмүүжил олгох;
24.	Олон нийтийн радио, телевизийн тухай хууль	8 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлого 8.2.Олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ дараахь бодлого баримтална:

		8.2.3.үндэсний соёл, урлаг, түүх, ёс заншил, уламжлалыг хүндэтгэх, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх, хүрээлэн байгаа орчноо хамгаалахыг дэмжих; 21 дүгээр зүйл.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, түүнийг томилох 21.6.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар түүх уламжлал, ёс заншил, соёл урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчид; эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Улсын Их Хуралд; эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Засгийн газарт тус тус санал болгоно.
25.	Соёлын өвийг хамгаалах тухай хууль	3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 3.1.5.“соёлын биет бус өв” гэж хамт олон, бүлэг, хувь хүн соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зан заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, уламжлалт мэдлэг, арга барил, тэдгээртэй холбоотой эд өлгийн зүйл, зэмсэг, урлагийн бүтээл, соёлын орон зайг;
26.	Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль	5 дугаар зүйл. Сургуулийн өмнөх боловсролын агуулга, стандарт 5.1.Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулга нь дараахь зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ: 5.1.4.хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах.
27.	Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль	3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.15.“зан үйлийн эмгэг” гэж нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахуун, эрх зүй, ёс заншил, харилцаа, сахилга бат, амьдралын эрүүл хэв маягийн хэм хэмжээг баримталдаггүй, нийгэм, хамт олны дунд дасан зохицох чадваргүй байдлыг;
28.	Төр, сүм хийдийн	7 дугаар зүйл. Сүм хийд, лам санваартны үйл

	харилцааны тухай хууль	ажиллагааны эрх зүйн үндэс 5.Сүм хийд нь тухайн шашны уламжлалт ёс дэгийг тусгасан дотоод журмыг чанд баримтлах бөгөөд Монголын ард түмний уламжлал, зан заншилд харшлах болон хүмүүнлэг бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
29.	Харьяатын тухай хууль	9 дүгээр зүйл. Монгол Улсын харьяат болох нөхцөл 1.Монгол Улсын харьяат болохын тулд дараахь нөхцөлийг хангасан байна: 2/Монголын ард түмний ёс заншил, төрийн албан ёсны хэл, Монгол Улсын Үндсэн хуулийн талаар зохих мэдлэг эзэмшсэн ба иргэний харьяатын асуудлаар өргөдөл гаргасан өдрөөс өмнө Монгол Улсын нутаг дэвсгэр дээр таваас доошгүй жил байнга оршин суусан байх; 10 дугаар зүйл. Монгол Улсын харьяат болгохоос татгалзах, түдгэлзүүлэх үндэслэл 1. Дор дурьдсан үндэслэлээр гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсын харьяат болгохоос татгалзана: 7/Монгол үндэсний ёс заншил, хуульд харш шашны урсгалыг сурталчилсан бол.
30.	Хог хаягдлын тухай хууль	42 дугаар зүйл. Хог хаягдлын талаархи боловсрол олгох 42.2.Хог хаягдлын талаархи боловсролыг дараахь байдлаар олгоно: 42.2.3.хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хог хаягдлын талаархи үндэсний уламжлал, зан заншил, тэргүүн туршлага, хууль тогтоомжийг сурталчлах;
31.	Хүүхдийн эрхийн тухай хууль	4 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийн үндсэн зарчим 4.1.Хүүхдийн эрхийг хамгаалахад дараахь зарчмыг баримтална: 4.1.4.хүүхдийн эрхийг хангахад үндэсний уламжлалт зан заншил, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурлах;